



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

**Төрийн болон орон нутгийн өмчийн эд
хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллого
ГАРЫН АВЛАГА**

**Улаанбаатар хот
2022 он**

Хянасан: Д.Нарангэрэл, Б.Мөнхбаатар

Эх бэлтгэсэн: М.Лхагважав

Хаяг: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Засгийн газрын IX байр,
Энхтайвны өргөн чөлөө-16 Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

Утас/Факс: (976-51) 262350

Вебсайт: www.pfsp.gov.mn

АГУУЛГА

Өмнөх үг

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллоготой холбоотой шийдвэр, гарын авлага:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын тухай танилцуулга
2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 9 дүгээр тогтоол
3. “Улсын үзлэг, тооллогын ажлын бэлтгэл хангах зөвлөмж, албан даалгавар хүргүүлэх тухай” Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А-1/2179 дүгээр албан бичиг
4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн “Маягт батлах тухай” 323 дугаар тогтоол
5. Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн “Мэдээ, тайлангийн маягт, зааварт өөрчлөлт оруулах тухай” А/33 дугаар тушаал
6. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай” 64 дүгээр тогтоол
 - Төв комиссын бүрэлдэхүүн
 - Үзлэг, тооллого явуулах журам
 - Маягт, хүснэгтийг ашиглах заавар
 - Хяналтын хуудас, тооллогын тэмдэглэл
 - Тооллогын ТӨ, ТӨХ маягтууд, нөхөх заавар
 - Ангиллын код (үйл ажиллагаа, хөрөнгө, байршил)

Төрийн өмчийн бүртгэл, эзэмшил, ашиглалт, хөдөлгөөн зохицуулалттай холбоотой журам, зааврын эмхэтгэл, гарын авлага:

Засгийн газар, Сангийн сайдын шийдвэр:

7. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоол
8. Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 207 дугаар тушаалын 6, 7 дугаар хавсралт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэр:

9. “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ болон үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүнгийн тухай” 2019 оны 20 дугаар тэмдэглэл.....
10. 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн “Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний тухай” А-1/272 дугаар албан бичиг.....
11. 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн “Зөвлөмж хүргүүлэх тухай” А-1/727 дугаар албан бичиг.....
12. 2020 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх, шийдвэр хэрэгжүүлэх тухай” А-1/1307 дугаар албан бичиг.....
13. 2020 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн “Чиглэл өгөх тухай” А-1/510 дугаар албан бичиг
14. “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам батлах тухай” 2020 оны 715 дугаар тогтоол
15. “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 2019 оны 268 дугаар тогтоол.....
16. “Мэдээ, тайлангийн маягт батлах тухай” 2019 оны 269 дүгээр тогтоол...
17. “Журам шинэчлэн батлах тухай” 2019 оны 271 дүгээр тогтоол (Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам)
18. “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай” 2020 оны 49 дүгээр тогтоол
19. “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 50 дугаар тогтоол.....
20. “Сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг батлах тухай” 2020 оны 51 дүгээр тогтоол.....
21. “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам батлах тухай” 2022 оны 65 дугаар тогтоол.....
22. “Өмч эзэмшлийн гэрээний дүнгээрх зөвлөмж хүргүүлэх тухай” 2022 оны А-1/120 дугаар албан бичиг.....
23. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх нэмэлт зөвлөмж

ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэлээр хяналт тавих, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах зорилтыг дэвшүүлсэн.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд

төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, төрийн өмчит хуулийн этгээдэд компанийн засаглалыг хөгжүүлэх, төрийн болон орон нутгийн өмчит 6000 гаруй хуулийн этгээдийн эзэмшилд байгаа хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой бүртгэл, тооллого явуулах, төрийн өмчийн бүрэн бүтэн байдал, төрийн өмчийн эзэмшилт, ашиглалтад хяналт тавих замаар төрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч ажиллаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 9 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогыг 2022 онд явуулахаар шийдвэрлэсэн.

Энэ удаагийн улсын үзлэг, тооллогоор төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, хадгалалт, хамгаалалтад байгаа эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хэмжээг тогтоох, хөрөнгийн чанар байдал, хадгалалт, хамгаалалт, үнэлгээ, бүртгэлд үнэлэлт өгөх, төрийн өмчийн улсын нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, улсын бүртгэлийн мэдээлэлтэй тулган баталгаажуулах, төрийн цахим мэдээллийн нэгдсэн сан, “хур” системийн мэдээллийг ашиглах, мэдээллийн нэгдсэн сангийн суурь програм хангамжийг ашиглах мэдээллийг цахимжуулах, цаашид төрийн мэдээллийн санд холбож, нийтэд нээлттэй, цахим мэдээллийн санг бүрдүүлэх зорилго тавьж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогыг нэгдсэн аргачлалаар зохион байгуулах зорилгоор гарын авлагыг эмхэтгэн барьж байна. Энэхүү гарын авлагад төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллоготой холбоотой шийдвэр, журам, аргачлал, маягтууд болон төрийн өмчийн бүртгэл, эзэмшил, ашиглалт, хөдөлгөөн зохицуулалттай холбоотой асуудлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас батлан гаргасан шийдвэрүүдийг багтаасан болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогыг гарын авлагад багтсан журмын дагуу гүйцэтгэж, дүнг тогтоосон хугацаанд ирүүлэхийг Та бүхнээс хүсье.

Хамтран ажилладаг нийт байгууллага, хамт олон, хэрэглэгч, үйлчлүүлэгч та бүхэнд амжилт, бүтээлийн дээдийг хүсэн ерөөе. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай.

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ЦЭНГЭЛ**

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа эхэлсэн анхны жилийн IY улиралд багтаан 4 жилд 1 удаа Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг явуулдаг.

Төрийн өмчийн хороо байгуулагдан анхны төрийн өмчийн үзлэг, тооллогыг 1997 онд хийж гүйцэтгэснээс хойш 2001, 2004, 2008, 2012, 2016 онд тус тус төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг, тооллогын ажлыг улс орон даяар зохион байгуулж, дүнгээ гарган, үзлэг, тооллогын дүнгээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Засгийн газрын холбогдох шийдвэрийг гаргуулан, хэрэгжүүлж ирсэн.

Хамгийн сүүлд Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогыг явуулах тухай” 439 дүгээр тогтоолын дагуу тооллогын ажлыг Сангийн яам удирдан зохион байгуулж, дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нэгтгэн Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 193 дугаар тогтоолыг батлуулан хэрэгжүүлсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн 6 удаагийн тооллогын дүн



2016 онд явагдсан тооллогоор нийт 6086 (1128-ОН, 4958-ТӨ) хуулийн этгээдэд нийт 30 их наяд төгрөгийн хөрөнгө тоологдсон.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа биет үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг Санхүү, эдийн засгийн сайд (хуучин нэрээр)-ын 2003 оны 342 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу 2004 онд, Сангийн сайдын 2009 оны 135 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу 2009 онд тус тус зохион байгуулсан. Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 193 дугаар тогтоолын дагуу Сангийн сайдын 2018 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж санхүүгийн тайланд тусгах, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг зохион байгуулсан. Үнэлгээний үр дүнг 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусган тайлагнасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогыг 2020 онд явуулахаар Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоол батлагдсан боловч дэлхий нийтэд гарсан цар тахлын улмаас уг тогтоолд 2 удаа өөрчлөлт оруулж 2022 онд явуулахаар шийдвэрлэсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого /цаашид Тооллого гэх/-ын зорилго нь:

- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, хадгалалт, хамгаалалтад байгаа эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хэмжээг тогтоох,

дутагдуулсан, бүртгэлгүй орхисон, маргаантай, ашиглалтгүй хөрөнгийн судалгааг гаргах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;

- Хөрөнгийн чанар байдал, хадгалалт, хамгаалалт, үнэлгээ, бүртгэлд үнэлэлт өгөх;
- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээллийг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрлөөр баталсан маягтаар авч, мэдээллийн цаасан архив (байнга хадгалах) болон цахим мэдээллийн сан бүрдүүлэх;
- Эзэмшиж ашиглаж буй газрын хэмжээ, баталгаажилт, түүний дээрх үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг хянаж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, газрыг бусдад шилжүүлэх, зориулалтыг өөрчлөхөд зөвшөөрөл авч буй байдалд хяналт тавих;
- Засгийн газрын шийдвэр, аргачлалын дагуу хийсэн дахин үнэлгээний дүнгээр гарсан зөрчил дутагдлыг арилгасан байдлыг хянах;
- Тооллогын дүнгээр төрийн болон орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээлэлтэй тулган баталгаажуулах;
- Тооллогод Төрийн цахим мэдээллийн нэгдсэн сан, “хур” системийн мэдээллийг ашиглах, Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн сангийн суурь програм хангамжийг ашиглах мэдээллийг цахимжуулах, цаашид төрийн мэдээллийн санд холбох бэлтгэл ажлыг хангах;
- Тооллогын үр дүнгээр хэрэгцээ шаардлагыг хангахуйц төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэн, төрийн хөрөнгийн бүртгэл, хяналт, норм хэмжээ, зохицуулалтын талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай холбогдох шийдвэрийг боловсруулж, нэгдсэн дүнг Засгийн газарт тайлагнах зэрэг болно.

Энэ удаагийн тооллогын ажлын хүрээнд:

Улсын бүртгэлийн ерөнхий газраас төрийн болон орон нутгийн өмчит хуулийн бүртгэлийн мэдээллийг авч, тооллогод хамрагдах этгээдийн мэдээллийг тулган баталгаажуулах, тооллогын явцад зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах,

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтад байгаа газрын талаарх мэдээллийг Төрийн цахим мэдээллийн сан **e-mongolia (egazar.gov.mn, urban.gov.mn)** системээс авч ашиглах, баталгаажуулах, зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-тай хамтран төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн мэдээллийг нэгтгэн гаргаж уг мэдээллийг тооллогод хамрагдсан дүнтэй тулгах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар цаашид авах арга хэмжээний санал боловсруулах, автотээврийн хэрэгслийн нэр төрөл, тоо, улсын дугаар, эзэмшигч, даатгал, татвар, төлбөр хураамж, торгууль, үзлэг оношилгооны нэгдсэн мэдээллийг тооллогын дүнтэй тулган баталгаажуулах ажил хийгдэнэ.

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭД ХӨРӨНГИЙН
УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГОТОЙ
ХОЛБООТОЙ ШИЙДВЭР, ГАРЫН
АВЛАГА**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 9

Улаанбаатар хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГО ЯВУУЛАХ ТУХАЙ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.5.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангийн дүнгээр тасалбар болгон явуулж, дүнг 2021 оны IV улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгасугай. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 46 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон) 2. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан удирдамж, Үндэсний статистикийн хорооноос баталсан маягт, асуулгын дагуу зохион байгуулж, дүнг 2021 оны III улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 46 дугаар тогтоол, 2021 оны 278 дугаар тогтоолоор тус тус өөрчлөлт орсон)

2. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан удирдамж, Үндэсний статистикийн хорооноос баталсан маягт, асуулгын дагуу зохион байгуулж, дүнг 2022 оны III улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Төрийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулахад шаардагдах 330.0 (гурван зуун гучин) сая төгрөгийг 2022 оны улсын төсвийн төсөлд тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 46 дугаар тогтоол, 2021 оны 278 дугаар тогтоолоор тус тус өөрчлөлт орсон)

4. Орон нутгийн өмчийн үзлэг, тооллого явуулахад шаардагдах зардлыг 2022 оны орон нутгийн төсвийн төсөлд тусгуулан санхүүжүүлэхийг аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. (Энэ заалтад Засгийн газрын 2020 оны 46 дугаар тогтоол, 2021 оны 278 дугаар тогтоолоор тус тус өөрчлөлт орсон)

5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
Эрхлэх газрын дарга

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



21 АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГА НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: nfo@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2020 оны 12 сарын 10-ны өдрийн А-1/2179

**Улсын үзлэг, тооллогын ажлын бэлтгэл
хангах зөвлөмж хүргүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолын дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг 2021 онд зохион байгуулж, дүнг тайлагнана.

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан удирдамж, Үндэсний статистикийн хорооноос баталсан маягт, асуулгын дагуу зохион байгуулж, дүнг 2021 оны III улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан.

Иймд орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг 2021 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган Газар зохион байгуулалт, барилга, хот байгуулалтын газар, хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг байгууллагатай нягт уялдаатай ажиллах шаардлагатай байна.


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллах бөгөөд эхний удаагийн сургалтыг цахим хэлбэрээр явуулахаар бэлтгэж байна.

Дэлхий дахинд гарсан цар тахлын нөхцөл байдалд тохируулан улсын үзлэг, тооллогын ажлыг заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийн тулд бэлтгэлийг зохих түвшинд хангах тухай зөвлөмжийг бэлтгэн хүргүүлж байна. Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөмж хүргүүлэн, тооллогын явцад хяналт тавьж, манай агентлагийн pcsp.gov.mn цахим хуудаснаас холбогдох мэдээллийг цаг алдалгүй авч, хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт хуудастай.

Хувийг: Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар, аймгуудын Орон нутгийн өмчийн газарт.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: nfo@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА АЛБАН
ГАЗАР, ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА
ТӨРИЙН (ОРОН НУТГИЙН) ӨМЧИТ
БОЛОН ТӨРИЙН (ОРОН НУТГИЙН)
ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН
ЭТГЭЭДЭД**

2020 оны 12 сарын 10-ны өдрийн А-1/2179

Улсын үзлэг, тооллогын
ажлын бэлтгэл хангах зөвлөмж,
албан даалгавар хүргүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолын дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг 2021 онд зохион байгуулж, дүнг тайлагнана.


Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангийн дүнгээр тасалбар болгон явуулж, дүнг 2021 оны IY улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг үүрэг болгосон.

Дэлхий дахинд гарсан цар тахлын нөхцөл байдалд тохируулан улсын үзлэг, тооллогын ажлыг заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийн тулд бэлтгэлийг зохих түвшинд хангах талаар зөвлөмж бэлтгэн хүргүүлж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас холбогдох журам, зааврыг батлан, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх бөгөөд манай агентлагийн pcsp.gov.mn цахим хуудаснаас зөвлөмж болон холбогдох мэдээллийг цаг алдалгүй авч, ажлын төлөвлөгөө гарган зөвлөмж, албан даалгаврыг хэрэгжүүлэн хамтран ажиллахыг мэдэгдье.

Хавсралт хуудастай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 сарын 10-ны өдрийн
А-1/2179 дүгээр албан бичгийн хавсралт

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН УЛСЫН ҮЗЛЭГ,
ТООЛЛОГЫН АЖЛЫН БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ,
ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ЗӨВЛӨМЖ,
АЛБАН ДААЛГАВАР**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.4-д заасны дагуу Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа эхэлсэн анхны жилийн IV улиралд багтаан Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогыг явуулдаг.

Төрийн өмчийн хороо байгуулагдан анхны төрийн өмчийн үзлэг, тооллогыг 1997 онд хийж гүйцэтгэснээс хойш 2001, 2004, 2008, 2012, 2016 онд тус тус төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг, тооллогын ажлыг улс орон даяар зохион байгуулж, дүнгээ гарган, үзлэг, тооллогын дүнгээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Засгийн газрын холбогдох шийдвэрийг гаргуулан, хэрэгжүүлж ирсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 193 дугаар тогтоолыг 2016 онд явагдсан тооллогын дүнгээр батлуулан хэрэгжүүлж, 2018-2019 онд газар эзэмших ашиглах эрхийн үнэлгээ, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийж, санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулсан.

Дахин үнэлгээний дүнгээр Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг батлуулан мөрдөж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас дараах тогтоол, албан бичгүүдээр чиглэл, зөвлөмж өгч байсан:

1. 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А-1/272 дугаар албан бичиг;
2. 2020 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А-1/510 дугаар албан бичиг;
3. 2020 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн А-1/1307 дугаар албан бичиг;

Эдгээр албан бичиг¹-ээр өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай.

Улсын үзлэг, тооллогын ажлын хүрээнд дараах зорилго, зорилтыг тавьж байна

1. Улсын үзлэг, тооллогыг хуульд заасан хугацаанд явуулж дүнг нэгтгэн гаргах;
2. Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд, хадгалалт, хамгаалалтад байгаа эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хэмжээг тогтоох (*дутагдуулсан, бүртгэлгүй орхисон, маргаантай, ашиглалтгүй хөрөнгийн болон дуусаагүй барилга, байгууламжийн судалгааг гаргах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах*);
3. Чанар байдал, хадгалалт, хамгаалалт, үнэлгээ, бүртгэлд үнэлэлт өгөх;
4. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээллийг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрлөөр баталсан маягаар авч, мэдээллийн цаасан архив (байнга хадгалах) болон цахим сан бүрдүүлэн шаардлагатай үед авч ашиглах боломжийг бүрдүүлэх;
5. Эзэмшиж ашиглаж буй газрын хэмжээ, баталгаажилт, түүн дээр үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг хянан авч зөрчил дутагдлыг арилгах, газрыг бусдад шилжүүлэх, зориулалтыг өөрчлөхөд зөвшөөрөл авч буй байдалд хяналт тавих;
6. Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаалаар баталсан аргачлалын дагуу үнэлгээ хийх явцад гарсан зөрчил дутагдлыг арилгах ажлыг зохион байгуулах;
7. Төрийн болон орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тоог тодорхой болгож тооллогын дүнгээр Улсын бүртгэл, статистикийн газрын хуулийн этгээдийн мэдээлэлтэй тулган баталгаажуулах;
8. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж төрийн

¹Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын pcsp.gov.mn цахим хуудасны “хууль эрх зүй” цэсний “Төрийн өмч” - “Тооллого-2021” хэсэгт байршуулсан

өмчийн эд хөрөнгийг улсын бүртгэлд хамруулахаар заасан. Иймд хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлыг тооллогын дүнтэй хамтатган хийх;

9. Хуулийн дагуу 4 жилд 1 удаа зохион байгуулж буй энэхүү тооллогын үр дүнгээр төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн зарим тулгамдсан асуудлыг Засгийн газарт тайлагнаж тооллогын мөрөөр төрийн хөрөнгийн бүртгэл, хяналт, норм хэмжээ, зохицуулалтын талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох шийдвэрийг гаргуулах зорилт тавьж байна.

1. Тооллогын хамрах хүрээ, маягт, аргачлал

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогод төрийн болон орон нутгийн өмчит болон тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшилд бүртгэлтэй болон бүртгэлгүй байгаа төрийн өмчийн эд хөрөнгө хамрагдана.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 323 дугаар тогтоол²-ын 1 дүгээр хавсралтаар Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн маягт, түүний нөхөх заавар, 2 дугаар хавсралтаар Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн захиргааны статистикийн маягт, түүний нөхөх зааврыг тус тус баталсан.

Эдгээр маягтуудыг төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд ашиглахаас гадна үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг Аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газар болон аймгуудын Орон нутгийн өмчийн газрын дарга нарт нарт үүрэг болгосон.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн захиргааны статистикийн маягтаар тайлан, мэдээ, мэдээллийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс жил бүр хүлээн авч холбогдох маягыг заасан хугацаанд Үндэсний статистикийн хороонд хүргүүлж байхаар заасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн маягтууд:

1. Хуулийн этгээдийн ерөнхий мэдээлэл (ТӨХ-1)
2. Байгууллагын эзэмшил /ашиглах/ газрын бүртгэл (ТӨХ-2)
3. Барилга байгууламжийн бүртгэл (ТӨХ-3)
4. Барилга байгууламжийн хийц, хэмжээсийн бүртгэл (ТӨХ-3.1)
5. Байгууллагын мэдлийн нийтийн эзэмшлийн байгууламжийн бүртгэл (ТӨХ-4)³
6. Машин тоног төхөөрөмжийн бүртгэл (ТӨХ-5)
7. Тээврийн хэрэгслийн бүртгэл (ТӨХ-6)
8. Тавилга, эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн бүртгэл (ТӨХ-7)
9. Үндсэн сүргийн мал, амьтадын бүртгэл (ТӨХ-8)
10. Худаг, услалтын системийн бүртгэл (ТӨХ-9)
11. Оюуны өмчийн бүртгэл (ТӨХ-10)
12. Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн 20 оны жилийн дэлгэрэнгүй мэдээ (ТӨХ-11)

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн захиргааны статистикийн маягтууд:

1. Дуусаагүй барилга байгууламжийн 20 оны жилийн бүртгэл (ТӨ-1)
2. Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-2)
3. Биет бус хөрөнгийн бүртгэлийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-3)
4. Түрээслүүлсэн үндсэн хөрөнгийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-4)
5. Түүх, соёлын дурсгалт зүйлсийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-5)

²- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын pcsp.gov.mn цахим хуудасны “хууль эрх зүй” цэсний “Төрийн өмч” - “Тооллого-2021” хэсэгт тогтоол болон маягтуудыг байршуулсан

³- нийтийн эзэмшлийн хучилттай болон зүлэгжүүлсэн талбай, мод, бут сөөг, биеийн тамирын талбай, түүний тохижилтын хөрөнгө, автомашины зогсоол, сандал, сүүдрэвч, үерийн далан суваг, явган зам, гэрэлтүүлгийн байгууламж, ургамлын хайс хашлага г.м.

6. Улсын нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болгосон үндсэн хөрөнгийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-6)
7. Гадаад зээлийн эх үүсвэрээр бий болгосон үндсэн хөрөнгийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-7)
8. Гадаадын буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлээр бий болсон үндсэн хөрөнгийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-8.1)
9. Дотоодын буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлээр бий болсон үндсэн хөрөнгийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-8.2)
10. Бүртгэлд тусгаагүй үндсэн хөрөнгийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-9)
11. Дутагдуулсан үндсэн хөрөнгийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-10)
12. Маргаантай үндсэн хөрөнгийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-11)
13. Илүүдэлтэй, ашиглагдаагүй байгаа үндсэн хөрөнгийн бүртгэлийн 20..... оны жилийн мэдээ (ТӨ-12)
14. Улсын чанартай авто замын 20 оны жилийн мэдээ (ТӨ-13.1)
15. Улсын чанартай гүүрний 20 оны жилийн мэдээ (ТӨ-13.2)
16. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-14)
17. Радио долгионы 20 оны жилийн мэдээ (ТӨ-15)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 323 дугаар тогтоолоор баталсан эдгээр маягтуудыг улсын үзлэг, тооллогод ашиглах бөгөөд хуулийн этгээд тус бүр өөрийн эзэмшилд байгаа хөрөнгийн ангилал тус бүрд тохирох маягыг зааврын дагуу бөглөж, бүрдүүлэх бөгөөд дүнг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүнтэй тулган жагсаалтаар гаргаж, ТӨБЗГ, нийслэл, аймгийн Орон нутгийн өмчийн газраас томилогдсон тооллогын комисст хянуулахад бэлтгэсэн байна.

Тооллогын ажлын нарийвчилсан аргачлал, зааврыг ТӨБЗГ-ын шийдвэрээр 2021 онд батлагдах тул тухайн үед нь гарын авлага болгон хүргүүлэх болно.

Илэрч буй зөрчил, дутагдал тэдгээрийг арилгах, залруулах, шийдвэрлүүлэх

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд байгууллагынхаа эзэмшил, ашиглалтад байгаа үл хөдлөх хөрөнгө бүрийн доорх газрыг эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулсан бөгөөд үнэлж, санхүүгийн тайланд тусгасан байх ёстой.

Гэтэл баталгаажуулаагүй (гэрчилгээгүй, гэрээгүй, кадастрын зураггүй), ялангуяа дуусаагүй барилга байгууламжийн доорх газрыг баталгаажуулах асуудлыг орхигдуулсан зөрчил нийтлэг байдаг. Мөн баримт бичгийн бүрдэл дутуу (гэрчилгээ, гэрээ, кадастрын зургийн аль нэг нь байхгүй), тэдгээр баримт бичигт заасан газрын хэмжээ хоорондоо харилцан адилгүй буюу зөрүүтэй (орсон өөрчлөлийг албан ёсоор баталгаажуулаагүй), газрын зориулалт болон хэмжээг зөвшөөрөлгүй өөрчилсөн, байгууллагын мэдлийн газар дээр өөр байгууллагын эзэмшил, өмчлөлийн барилга байгууламж бариулсан зэрэг нийтлэг зөрчил дутагдал байна. Тооллогын ажилтай хамтатган эдгээр зөрчил дутагдлыг илрүүлэх, арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Үл хөдлөх хөрөнгийн (барилгын) хувийн хэргийг бүрэн гүйцэд хөтөлж хэвшээгүй тул хийц, хэмжээ тодорхойгүй, барилгын доторх давхар бүрийн схем зураглал байхгүй тул хэмжээг баталгаажуулсан баримт байхгүй, барилгад хамаарах инженерийн байгууламж (ус, дулаан, цэвэр бохир усны хангамж, ариутгах татуурга, галын дохиолол, зоорины давхар г.м.)-ийн талаарх мэдээлэл дутуу, барилгыг 2 болон түүнээс дээш этгээд хувааж эзэмшиж байгаа тохиолдолд заагийг тодорхойлсон схем зураг үйлдээгүй, хэмжээг баталгаажуулаагүй, барилгын чанар байдлын талаар холбогдох мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт (хэсэгчилсэн), гал, үер, ус, газар хөдлөл, нуралтын талаарх тэмдэглэл баримт хадгалагдаагүй, барилга байгууламжийн фото зураг (4 талаас нь авсан)-ийг

паспортод оруулаагүй зэрэг нийтлэг зөрчил, дутагдал байсаар байна.

Мөн барилга, байгууламжийн түрээсийн гэрээнд заасан хэмжээ, бодит түрээсэлсэн хэмжээ зөрүүтэй, эсхүл түрээсийн гэрээ байгуулж баталгаажуулаагүй, төлбөрийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлээгүй зэрэг зөрчил байсаар байгаар арилгах шаардлагатай.

Автотээврийн хэрэгслийг бүртгэл, ашиглалтад нэлээд зөрчил илэрч байгаагийн дотор улсын дугаар нь өөр байгууллагын нэр дээр байгааг шилжүүлээгүй, худалдсан, данснаас хассан тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг Автотээврийн үндэсний төвийн “улсын бүртгэл”-д өөрчлөлт оруулаагүй, олон жилийн татвар төлөөгүй, үзлэг, оношилгоонд хамрагдаагүй, ашиглалтын шаардлага хангахгүй олон жил болсон зэргийг дурдаж болно. Улсын үзлэг, тооллогын ажлын үеэр автотээврийн хэрэгслийн “улсын бүртгэл”-тэй тулгалт хийх тул дээр дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Төрийн өмчийн хөрөнгөөр бий болсон (ялангуяа 1993 оноос өмнө үүссэн) оюуны өмчийг бүртгэх, баталгаажуулах ажил хангалтгүй байна. Иймд оюуны өмчтэй холбоотой хууль, тогтоомжийг судлан өөрийн байгууллагын үйл ажиллагааны явцад төрийн хөрөнгөөр бий болсон оюуны өмчийн судалгаа, жагсаалтыг бэлтгэх, тухайн бүтээлийн холбогдох баримт, бичвэр, эх ямар байдлаар хадгалагдаж байгаа талаар тайлбар, танилцуулга бэлтгэх, цаашид тухайн оюуны өмч байгууллагын болон төрийн бусад байгууллагад ашиглагдах эсэх талаар нэгдсэн тайлбар дүгнэлтийг бэлтгэсэн байх шаардлагатай.

Бүрдүүлэх баримт материал

1. Дээр дурдсан маягтуудаас тухай байгууллагын эзэмшилд байгаа хөрөнгөд хамаарахыг зааврын дагуу бөглөж, бэлтгэсэн байна.

2. Газар, үл хөдлөх хөрөнгө эзэмшиж буй хуулийн этгээд нэгж талбар тус бүрд байрлах үл хөдлөх хөрөнгө, газрын заагийг тодорхой харуулсан “байршил зүйн зураг- орчны тойм зураг”-ийг заавал хийж, бэлтгэсэн байна. Энэхүү зурагт Газар болон түүн дээрх барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийн бүртгэлийг газрын кадастрын зургаар тодорхойлсон хил, хязгаарын дотор байршуулж, нэршил, хэмжих нэгжийг хүснэгтээр тодорхой илэрхийлсэн байна. Мөн энэхүү зурагт газар дээрх болон доорх инженерийн шугам сүлжээг өнгө ялган илэрхийлж, хэмжээ, зааг, эзэмшлийг тодруулсан байна. (Хөрөнгийн бодит хэмжээг санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгө тус бүрийн тоо хэмжээтэй тулган нягталсан байх шаардлагатай). Энэхүү зураглалд нийтийн эзэмшлийн байгууламжийг мөн багтааж оруулна.

3. Үл хөдлөх хөрөнгийн фото зураг, доторх схем зураг давхар бүрээр, эзэмшлийн зааг, чанар байдал зэрэг бодит байдлыг байгууллагынхаа нөөц бололцоогоор тодорхойлох боломжгүй тохиолдолд мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах нь зүйтэй.

4. Хууль, тогтоомжид эзэмших, ашиглах эрхийг тусгайлан баталгаажуулсан байхыг шаарддаг зарим хөдлөх үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн дагалдах баримт бичгийг бэлтгэнэ. Тухайлбал, хуулийн этгээдийн гэрчилгээ, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ(орон сууц зэрэгт олгосон бол), төмөр замын гэрчилгээ, бууны гэрчилгээ, авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ, татвар төлөгчийн болон бусад холбогдох баримт, оюуны өмч-зохиогчийн эрхийн гэрчилгээ гэх мэт.

Тайлан дүгнэлт, тайлбар бэлтгэх

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд бүр удирдлага (дарга, захирал)-ын тушаалаар тооллогын ажлын бэлтгэлийг хангах, зохион байгуулах ажлыг хийж гүйцэтгэх Ажлын хэсэг (Өмч хамгаалах байнгын зөвлөлийг оролцуулан) байгуулан хариуцуулж, үр дүнг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар, Орон нутгийн өмчийн газраас томилогдсон Ажлын хэсэг, төлөөлөгчид хянуулж шалгуулахад бэлтгэнэ.

Байгууллагын тооллогын (Ажлын хэсэг) тоолбол зохих хөрөнгийн жагсаалтыг бэлтгэн гаргаж, тооллого хийхэд илэрч буй зөрчил дутагдал, тулгарч болох саад бэрхшээл

(алслагдмал байрладаг, хөрөнгийн үнэлгээг салгах боломжгүй, хэмжээг тодорхойлох боломжгүй, маргаантай, санхүүгийн тайланд туссан хөрөнгө бодит байдалтай зөрүүтэй г.м) зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч, асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар “нэгдсэн тайлан, дүгнэлт”-д тусгана.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар, Орон нутгийн өмчийн газрууд тооллогын ажилд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллах тул холбогдох мэдээллийг www.pcsp.gov.mn цахим хуудаснаас авч санал болон бусад шаардлагатай мэдээллийг тухай бүр toolloqo@pcsp.gov.mn хаягаар хүргүүлнэ.

Байгууллагын тооллогын комиссын гишүүд хөрөнгө нэг бүрийг нүдээр үзэж тоолох (2020 оны жилийн эцсийн тооллоготой хамтатган хийж болно) бөгөөд Ажлын хэсэг (Өмч хамгаалах байнгын зөвлөл)-ийн тодорхойлсон хэмжээ, зааг, чанар байдлын дүгнэлтийг тайланд тусгана.

Энэхүү зөвлөмжийг орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэх, тооллогын ажлын явцад хяналт тавих ажлыг Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар болон аймгийн Орон нутгийн өмчийн газрууд хэрэгжүүлнэ.

Зохион байгуулалтын хувьд аймаг, орон нутагт байгаа төрийн өмчит хуулийн этгээд тухайн аймгийн Орон нутгийн өмчийн газраас холбогдох лавлагаа, зөвлөмж авч ажиллах нь зүйтэй.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

-----oO-----

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 323

Улаанбаатар хот

Маягт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5, 69 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/33 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн маягт, түүний нөхөх зааврыг 1 дүгээр, Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн захиргааны статистикийн маягт, түүний нөхөх зааврыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн болон захиргааны статистикийн маягт, түүний нөхөх зааврыг орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан), Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газар болон аймгуудын Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1 . Энэ тогтоолоор баталсан маягтуудыг төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд ашиглаж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

3.2 .Энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн захиргааны статистикийн маягтаар тайлан, мэдээ, мэдээллийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс жил бүр хүлээн авч холбогдох маягтыг заасан хугацаанд Үндэсний статистикийн хороонд хүргүүлж байх зохион байгуулалтын арга хэмжээ авах.

3.3 Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА		З.МЭНДСАЙХАН
ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА		Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн
323 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН
БҮРТГЭЛИЙН МАЯГТ, ТҮҮНИЙ НӨХӨХ ЗААВАР**

1. Хуулийн этгээдийн ерөнхий мэдээлэл (ТӨХ-1)
2. Байгууллагын эзэмшил /ашиглах/ газрын бүртгэл (ТӨХ-2)
3. Барилга байгууламжийн бүртгэл (ТӨХ-3)
4. Барилга байгууламжийн хийц, хэмжээсийн бүртгэл (ТӨХ-3.1)
5. Байгууллагын мэдлийн нийтийн эзэмшлийн байгууламжийн бүртгэл
(ТӨХ-4)
6. Машин тоног төхөөрөмжийн бүртгэл (ТӨХ-5)
7. Тээврийн хэрэгслийн бүртгэл (ТӨХ-6)
8. Тавилга, эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн бүртгэл (ТӨХ-7)
9. Үндсэн сүргийн мал, амьтадын бүртгэл (ТӨХ-8)
10. Худаг, услалтын системийн бүртгэл (ТӨХ-9)
11. Оюуны өмчийн бүртгэл (ТӨХ-10)
12. Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн 20 оны жилийн
дэлгэрэнгүй мэдээ (ТӨХ-11)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн
323 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН
БҮРТГЭЛИЙН МАЯГТ, ТҮҮНИЙ НӨХӨХ ЗААВАР**

1. Дуусаагүй барилга байгууламжийн 20оны жилийн бүртгэл (ТӨ-1)
2. Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн 20.....оны жилийн мэдээ (ТӨ-2)
3. Биет бус хөрөнгийн бүртгэлийн 20..... оны жилийн мэдээ (ТӨ-3)
4. Түрээслүүлсэн үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-4)
5. Түүх, соёлын дурсгалт зүйлсийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-5)
6. Улсын нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болгосон үндсэн хөрөнгийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-6)
7. Гадаад зээлийн эх үүсвэрээр бий болгосон үндсэн хөрөнгийн 20..... оны жилийн мэдээ (ТӨ-7)
8. Гадаадын буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлээр бий болсон үндсэн хөрөнгийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-8.1)
9. Дотоодын буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлээр бий болсон үндсэн хөрөнгийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-8.2)
10. Бүртгэлд тусгаагүй үндсэн хөрөнгийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-9)
11. Дутагдуулсан үндсэн хөрөнгийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-10)
12. Маргаантай үндсэн хөрөнгийн 20....оны жилийн мэдээ (ТӨ-11)
13. Илүүдэлтэй, ашиглагдаагүй байгаа үндсэн хөрөнгийн бүртгэлийн 20 ..оны жилийн мэдээ (ТӨ-12)
14. Улсын чанартай авто замын 20 оны жилийн мэдээ (ТӨ-13.1)
15. Улсын чанартай гүүрний 20... оны жилийн мэдээ (ТӨ-13.2)
16. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 20 оны жилийн мэдээ (ТӨ-14)
17. Радио долгионы 20.....оны жилийн мэдээ (ТӨ-15)

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Мэдээ, тайлангийн маягт, зааварт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4 дэх заалт, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, Үндэсний статистикийн хорооны даргын зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын захиргааны статистикийн болон бүртгэлийн дараах маягтууд, түүний! нөхөх зааврыг хавсралтын дагуу баталж, мөрдүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар /З.Мэндсайхан/-т зөвшөөрсүгэй. Үүнд:

Дуусаагүй барилга байгууламжийн 20... оны жилийн бүртгэл (ТӨ-1)

- Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-2)
- Биет бус хөрөнгийн бүртгэлийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-3)
- Түрээслүүлсэн үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-4)
- Түүх, соёлын дурсгалт зүйлсийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-5)
- Улсын нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болгосон үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-6)
- Гадаад зээлийн эх үүсвэрээр бий болгосон үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-7)
- Гадаадын буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлээр бий болсон үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-8.1)
- Дотоодын буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлээр бий болсон үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-8.2)
- Бүртгэлд тусгаагүй үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-9)
- Дутагдуулсан үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-10)
- Маргаантай үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-11)
- Илүүдэлтэй, ашиглагдаагүй байгаа үндсэн хөрөнгийн бүртгэлийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-12)
- Улсын чанартай авто замын 20... оны жилийн мэдээ (ТӨ-13.1)
- Улсын чанартай гүүрний 20... оны жилийн мэдээ (ТӨ-13.2)
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-14)

- Радио долгионы 20... оны жилийн мэдээ (ТӨ-15)
- Хуулийн этгээдийн ерөнхий мэдээлэл (ТӨХ-1)
- Байгууллагын эзэмшил /ашиглах/ газрын бүртгэл (ТӨХ-2)
- Барилга байгууламжийн бүртгэл (ТӨХ-3)
- Барилга байгууламжийн хийц, хэмжээсийн бүртгэл (ТӨХ-3.1)
- Байгууллагын мэдлийн нийтийн эзэмшлийн байгууламжийн бүртгэл (ТӨХ-4)
- Машин тоног төхөөрөмжийн бүртгэл (ТӨХ-5)
- Тээврийн хэрэгслийн бүртгэл (ТӨХ-6)
- Тавилга, эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн бүртгэл (ТӨХ-7)
- Үндсэн сүргийн мал, амьтдын бүртгэл (ТӨХ-8)
- Худаг, услалтын системийн бүртгэл (ТӨХ-9)
- Оюуны өмчийн бүртгэл (ТӨХ-10)
- Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн 20... оны жилийн дэлгэрэнгүй мэдээ (ТӨХ-11)

2.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Мэдээ, тайлангийн маягт, зааварт өөрчлөлт оруулах тухай” Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар /хуучнаар/-ын даргын 2016 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/231 дугаар тушаалаар зөвшөөрсөн Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн захиргааны статистик мэдээллийн маягт болон Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн маягт, зааврыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэхүү тушаалаар зөвшөөрөгдсөн маягтуудын үзүүлэлтүүдийн дагуу мэдээллийг авч, холбогдох тооцоо, судалгаанд ашиглаж байхыг Үндэсний статистикийн хорооны Эдийн засгийн статистикийн газар /Э.Эрдэнэсан/-т даалгасугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний статистикийн хорооны Дотоод аудит, мониторингийн хэлтэс /Б.Саранчимэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



А.АРИУНЗАЯА

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн
улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 70 дугаар зүйлийн 4, 72 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах Төв комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах журам”-ыг хоёрдугаар, “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогын үр дүнгийн маягт, хүснэгтийг ашиглах заавар”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын Төв комисс /А.Ариунболд/-т дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай. Үүнд:

2.1. Улсын үзлэг, тооллогын ажлын төлөвлөгөө болон дүнгийн нэгтгэлийн маягт, зааврыг батлуулж мөрдүүлэх;

2.2. Улсын үзлэг тооллогод хамруулах хуулийн этгээдийн нэр, тэдгээрийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцооны хувь, регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар болон бусад холбогдох мэдээллийг мэргэжлийн байгууллагын оролцоотой гаргаж тооллогын ажилд ашиглах,

2.3. Холбогдох шийдвэр, журам, аргачлал, заавар, маягтыг багтаасан товхимол, сургалтын материал бэлтгэн хэвлүүлж, тооллогод хамруулах байгууллагад хүргүүлэн сургалт зохион байгуулах;

2.4. Улсын үзлэг, тооллогыг хийж гүйцэтгэх, хяналт тавих ажлын хэсэг, төлөөлөгчдийг томилуулан, ажлын хуваарийг боловсруулж, удирдамжаар ханган ажиллах,

2.5. Гадаад улсад байгаа Монгол Улсын төрийн өмчийн хөрөнгийг улсын үзлэг, тооллогод хамруулан тооллогын дүнгээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай саналыг боловсруулан танилцуулах;

2.6. Улсын үзлэг, тооллогын ажилтай хамтатган төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа ашиглалтгүй болон илүүдэлтэй үндсэн хөрөнгө, ашиглах хугацаа нь дууссан эд хөрөнгийг газар дээр нь үзэж, хяналтын тооллого хийх, цаашид худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах талаар дүгнэлт гарган, холбогдох журмын дагуу шийдвэрлүүлэх;

2.7. Орон нутгийн өмчийн улсын тооллогын ажилд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн нэгдсэн нэг аргачлалаар зохион байгуулж, дүнг 2022 оны 8 дугаар сарын 30-ны дотор хүлээн авч, улсын нэгтгэлд хамруулах;

2.8. Төрийн өмчийн улсын үзлэг тооллогын баримтыг 2022 оны 7 дугаар сард, орон нутгийн өмчийн тооллогын баримтыг 8 дугаар сард тус тус багтаан хянан хүлээж авах, дүнг 11 дүгээр сард багтаан нэгтгэн боловсруулж, IV улиралд багтаан Засгийн газарт танилцуулах.

3. Харьяа байгууллагынхаа төрийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжил, арга зүйн дагуу дотооддоо зохион байгуулж, дүнг 2022 оны 07 дугаар сарын 30-ны дотор Төв комисст нэгтгүүлэхийг Монголбанк, Батлан хамгаалах яам (Төрийн нарийн бичгийн дарга), Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газарт тус тус даалгасугай.

4. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн мэдээллийг нэгтгэн гаргаж Төв комисс болон аймаг, нийслэлийн тооллогын комисст хүргүүлэх, улсын бүртгэл дэх мэдээллийг тооллогод хамрагдсан дүнтэй тулган баталгаажуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар цаашид авах арга хэмжээний санал боловсруулан танилцуулахыг Төв комисс (А.Ариунболд), “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирал (Б.Гүрсоронзон) нарт даалгасугай.

5. Төрийн болон орон нутгийн өмчит (өмчийн оролцоотой) хуулийн этгээдийн дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

5.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу өөрийн байгууллагын (компанийн) эзэмшилд байгаа эд хөрөнгийг тооллогод хамруулах бэлтгэлийг хангаж, комисс томилон, тооллогын ажлыг 2022 оны 06 дугаар сард багтаан хийж гүйцэтгэх;

5.2. Төрийн цахим мэдээллийн сан (e-mongolia)-г ашиглан өөрийн байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаа газар, үл хөдлөх хөрөнгө, автотээврийн хэрэгслийн бүртгэлийг нягтлан шалгаж, бүртгэлд хамруулах, тулган баталгаажуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах;

5.3. Төв комисс, салбар комиссын удирдамж, зааврын дагуу тооллогын дүн, тайланг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар, аймгийн Орон нутгийн өмчийн газрын ажлын хэсэг, төлөөлөгчид хянуулах, хүлээлгэн өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авах.

6. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс(Д.Нарангэрэл), Захиргаа, удирдлагын хэлтэс (Н.Ганболд)-т тус тус даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА *Д.Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 02 дугаар сарын 22-ний өдрийн
64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН
УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ТӨВ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга:	А.АРИУНБОЛД	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Дэд дарга
Комиссын орлогч дарга:	Д.НАРАНГЭРЭЛ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга
Гишүүд:	Б.БАТТҮВШИН	Гадаад хэргийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дэд захирал /зөвшилцсөнөөр/
	Ж.БАНЗРАГЧ	Батлан хамгаалах яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Материал хангамжийн хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/
	А.ЭНХТУУЛ	Сангийн яамны Захиргаа, удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	Ц.ЧОЙЖИЛСҮРЭН	Хил хамгаалах ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ерөнхий нягтлан бодогч, хурандаа /зөвшилцсөнөөр/
	Л.ЛУВСАН	Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/
	М.БАЯРАА	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга
	С.БАЯРСАЙХАН	Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн нягтлан бодогч /зөвшилцсөнөөр/
	Д.ТУНГАЛАГТУУЛ	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Б.МӨНХБААТАР	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Р.ШИРЧИННЯМ	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	М.ЛХАГВАЖАВ	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 02 дугаар сарын 22-ний өдрийн
64 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГО ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг, тооллого /цаашид Тооллого гэх/-ын зорилго нь:

1.1.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, хадгалалт, хамгаалалтад байгаа эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хэмжээг тогтоох, дутагдуулсан, бүртгэлгүй орхисон, маргаантай, ашиглалтгүй хөрөнгийн судалгааг гаргах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;

1.1.2 Хөрөнгийн чанар байдал, хадгалалт, хамгаалалт, үнэлгээ, бүртгэлд үнэлэлт өгөх;

1.1.3 Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээллийг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрлөөр баталсан маягтаар авч, мэдээллийн цаасан архив (байнга хадгалах) болон цахим сан бүрдүүлэх;

1.1.4 Эзэмшиж ашиглаж буй газрын хэмжээ, баталгаажилт, түүний дээрх үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг хянан авч зөрчил дутагдлыг арилгах, газрыг бусдад шилжүүлэх, зориулалтыг өөрчлөхөд зөвшөөрөл авч буй байдалд хяналт тавих;

1.1.5 Засгийн газрын шийдвэр, аргачлалын дагуу хийсэн дахин үнэлгээний дүнгээр гарсан зөрчил дутагдлыг арилгасан байдлыг хянах,

1.1.6 Тооллогын дүнгээр төрийн болон орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээлэлтэй тулган баталгаажуулах;

1.1.7 Тооллогод Төрийн цахим мэдээллийн нэгдсэн сан, “хур” системийн мэдээллийг ашиглах, Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн сангийн суурь программ хангамжийг ашиглах мэдээллийг цахимжуулах, цаашид төрийн мэдээллийн санд холбох бэлтгэл ажлыг хангах;

1.1.8 Тооллогын үр дүнгээр хэрэгцээ шаардлагыг хангахуйц төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэн, төрийн хөрөнгийн бүртгэл, хяналт, норм хэмжээ, зохицуулалтын талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж, нэгдсэн дүнг Засгийн газарт тайлагнах зэрэг болно.

1.2 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9 (2020 оны 46, 2021 оны 278) дугаар тогтоолыг тус тус үндэслэн төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого хийх, орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж, улсын нэгдсэн дүнг гарган тайлагнахад энэхүү журмыг баримтална.

1.3 Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын **хамрах хүрээ**: Энэхүү тооллогод Монгол Улсын нутаг дэвсгэр дээр болон гадаад улс оронд байгаа дараах төрлийн төрийн болон орон нутгийн өөрийн өмчийн хөрөнгө хамрагдана:

1. Төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө,
2. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хөрөнгө (*дүнд зөвхөн төрд ногдох хувь тооцогдоно*)
3. Улсын төсвийн хөрөнгө болон төрийн бусад тусгай сан
4. Төрийн тусгай хэрэгцээний бэлтгэл нөөц
5. Хуульд заасан төрийн болон орон нутгийн өмчийн бусад үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө
6. Аймаг, Нийслэл, сум, дүүргийн өөрийн өмчийн хөрөнгө.

1.4. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийг тооллогод хамруулахад тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдсэн байна. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийт хөрөнгийг бусад төрийн өмчит байгууллагын адил тооллогод хамруулж улсын нэгдсэн дүн гаргахдаа хөрөнгийн дүнг төрийн /орон нутгийн/ өмчийн оролцооны хувь хэмжээгээр дүйцүүлэн тооцно.

1.5 Тооллого явуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72, 73 дугаар зүйлийг удирдлага болгоно.

1.6 Улсын үзлэг, тооллогын явцад хөрөнгийг шууд данснаас хасах, актлах, устгах, шилжүүлэх, худалдахыг хориглоно.

Хоёр. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогын зарчим, удирдлага, зохион байгуулалт

2.1 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэг:

2.1.1 Тооллогыг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах;

2.1.2 Төв комисс, түүний гишүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;

2.1.3 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Төв комиссын шийдвэрийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, батлах;

2.1.4 Төв комиссын хуралдааны бэлтгэл хангах, хуралдааныг зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх;

2.1.5 Тооллогын журам, заавар, маягтууд, сургалтын гарын авлага, материал бусад холбогдох баримт мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын www.pcsp.gov.mn цахим хуудас (“Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого” булан)-нд байршуулах;

2.1.6 Тооллогын ажлын төлөвлөгөөг боловсруулах;

2.1.7 Төрийн болон орон нутгийн өмчийн тооллоготой холбоотой асуулт, санал, хүсэлт, гомдол, мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс toollogo@pcsp.gov.mn хаягаар хүлээн авах;

2.1.8 Тооллогын сургалт, сурталчилгааг зохион байгуулах;

2.1.9 Төрийн өмчийн тооллогыг зохион байгуулах, хяналт тавих, дүнг нягтлан хүлээн авах үүрэг бүхий Комисс, төлөөлөгчдийг томилон ажиллуулах;

2.1.10 Тооллогод ашиглах программ хангамжийн сургалтыг зохион байгуулах, хэвийн ажиллагааг хангах;

2.1.11 Төрийн өмчийн болон аймаг, нийслэлийн тооллогын ажлын үр дүнг нягтлан хүлээн авах, нэгтгэх, Төв комисст танилцуулах;

2.1.12 Тооллогын дүнг нэгтгэж, дүн шинжилгээ хийж, Засгийн газарт танилцуулах;

2.1.1 Хуульд заасан бусад үүрэг.

2.2 Тооллогын Төв комиссын чиг үүрэг:

2.2.1. Төв комисс тооллогын ажлыг удирдан зохион байгуулж арга зүй, зохион байгуулалтын нэгдсэн удирдлагаар хангах;

2.2.2. Төв комисс нь Улсын бүртгэлийн ерөнхий газар, түүний орон нутаг дахь салбар нэгжээс улсын үзлэг, тооллогод хамруулах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр, өмчийн оролцооны хувь, регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар болон бусад холбогдох мэдээллийг авч, тэдгээрийг тооллогод бүрэн хамруулах;

2.2.3. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтад байгаа газрын талаарх мэдээллийг Төрийн цахим мэдээллийн сан e-mongolia (egazar.gov.mn, urban.gov.mn)–аас авч ашиглах талаар заавар зөвлөмж бэлтгэн тооллогын ажилд ашиглуулах;

2.2.4. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-тай хамтран төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн мэдээллийг нэгтгэн гаргаж Төв комисс болон аймаг, нийслэлийн тооллогын комисст хүргүүлэх (салбар нэгжээс гаргах), улсын бүртгэл дэх мэдээллийг тооллогод хамрагдсан дүнтэй тулган баталгаажуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар цаашид авах арга хэмжээний санал боловсруулах;

2.2.5. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд бүрийн эзэмшилд байгаа нийт автотээврийн хэрэгслийн нэр төрөл, тоо, улсын дугаар, эзэмшигч, даатгал, татвар, төлбөр хураамж, торгууль, үзлэг оношилгооны нэгдсэн мэдээллийг жагсаалтаар гаргаж баталгаажуулан тухайн байгууллагад хүргүүлнэ.

2.2.6. Гадаад улсад байгаа Монгол Улсын төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг энэ журмын дагуу хийж гүйцэтгэн дүнг нэгтгэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, тооллогын дүнгээр цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах.

2.3 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, яам, тусгай газрын болон Аймаг, нийслэлийн тооллогын комиссын чиг үүрэг:

2.3.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн өмчийн /цаашид Орон нутгийн өмч гэх/ эд хөрөнгийн тооллогыг тухайн орон нутгийн Засаг дарга (Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар, аймгийн Орон нутгийн өмчийн газар) удирдан зохион байгуулна.

2.3.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Орон нутгийн өмчийн Тооллогын комиссыг Засаг дарга /цаашид орон нутгийн Тооллогын комисс гэх/ томилно. Тооллогын комисс /төлөөлөгч/ нь тооллогын ажлын арга зүйн талаар байгууллагын комисст зааварчилгаа, зөвлөгөө өгч, түүний явц, чанар, үр дүнд хяналт тавьж Төв комиссын удирдлага дор ажиллана.

2.3.3. Монголбанк, Батлан хамгаалах яам, Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар өөрийн харьяа, нэгж байгууллагын тооллогын ажлыг энэхүү журмын дагуу Төв комиссын зааварчилгаа, зөвлөмжийн дагуу дотооддоо зохион байгуулж, дүнг нэгтгэн боловсруулж, Төв комисст хүлээлгэн өгнө. Төв комиссоос эдгээр байгууллагын хөрөнгийн тооллогын ажилд зөвлөн тусалж, хяналтын тооллогыг явуулна.

2.3.4. Тооллогын үеэр газар эзэмших эрх, барилга, байгууламж, тээврийн хэрэгслийг нүд үзэж тоолох бөгөөд бусад хөдлөх үндсэн хөрөнгийг нийт дүнгээр (байгууллагын комиссын дүнд үндэслэн) нь хамруулах бөгөөд, шаардлагатай тохиолдолд нэг бүрчлэн хяналтын болон түүвэр тооллого хийнэ.

2.3.5. Тооллогын комисс нь байгууллагад ажиллахдаа санхүүгийн тайлан, болон үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгөөс гадна улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулсан барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн байгууламж, бусад үндсэн хөрөнгийг тооллогод бүрэн хамруулахад хяналт тавьж ажиллана.

2.3.6. Тооллогын комисс нь маргаантай, бүртгэлгүй, ашиглалтгүй хөрөнгийн талаар байгууллагын санал, дүгнэлтийг хянан үзэж комиссынхоо хурлаар хэлэлцэн Төв комисс болон аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, асуудлыг шийдвэрлүүлэх санал дүгнэлт бэлтгэн танилцуулна.

2.3.7. Орон нутгийн өмчийн маргаантай асуудлыг аймаг, нийслэлийн ИТХ, төрийн өмчийн маргаантай асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эцэслэн шийдвэрлэнэ.

2.3.8. Засгийн газрын шийдвэр, аргачлалын дагуу хийсэн дахин үнэлгээний дүнгээр гарсан зөрчил дутагдлыг арилгасан байдлыг хянан.

2.4. Байгууллагын тооллогын комиссын чиг үүрэг:

2.4.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд нь тооллого эхлэхээс өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан бэлтгэл хангасан байна. Үүний тулд Байгууллагын тооллогын комисс /цаашид байгууллагын комисс гэх/-ыг тухайн байгууллагын даргын шийдвэрээр томилно. Байгууллагын комиссын бүрэлдэхүүнд Өмч хамгаалах байнгын зөвлөл, Техникийн комиссын төлөөллийг оролцуулна.

2.4.2 Байгууллагын комисс нь тооллого эхлэхээс өмнө төрийн цахим мэдээллийн сангаас хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар, зохион байгуулалтын хэлбэр, хувьцаа эзэмшигчийн зэрэг мэдээллийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй тулган баталгаажуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авна.

2.4.3 Байгууллагын комисс тооллогын ажлыг гардан гүйцэтгэх бөгөөд өөрийн байгууллагын эзэмшилд байгаа тоолбол зохих хөрөнгийн жагсаалтыг бэлтгэн гаргаж, эд хөрөнгө нэг бүрийг нүд үзэж тоолно. Тооллогын үр дүнгээр энэхүү журамд заасан маягтуудыг бүрдүүлнэ.

2.4.4 Байгууллагын нягтлан бодогч эд хөрөнгийн тоолбол зохих үлдэгдэл болон тоологдсон хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулна.

2.4.5 Байгууллагын комисс нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасан эрх, үүргийг хэрэгжүүлж, энэхүү журамд заасан маягтуудын эрх бүхий этгээдийн баталсан журам, зааврын дагуу тооллогын баримт материалыг бүрдүүлж, аймаг, нийслэлийн Тооллогын комисстой хамтран ажиллаж, дүнг хянуулна.

2.4.6 Төрийн цахим мэдээллийн санг ашиглан өөрийн байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаа газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг нягтлан шалгаж, тулган баталгаажуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах;

2.4.7 Байгууллагын комисс үзлэг, тооллогод мэргэжлийн байгууллагаас явуулсан хөрөнгийн тусгай, түүвэрчилсэн үзлэг тооллогын дүнтэй танилцаж илэрсэн зөрчил дутагдал, түүнийг арилгасан байдалд хяналт тавьж, хөрөнгийг дансны ангилалд зөв ангилан бүртгэх, шаардлагатай тохиолдолд шилжүүлэн бүртгэх, данснаас хасах зэрэг асуудлыг шийдвэрлүүлэх санал боловсруулна.

2.4.8 Тооллогын үеэр илэрсэн бүртгэлгүй хөрөнгийг төрийн өмч мөн эсэхийг нягтлан, төрийн өмч болох нь нотлогдвол “Бүртгэлд тусгаагүй үндсэн хөрөнгийн мэдээ” буюу “Маягт ТӨ-9”-ыг бүрдүүлж, тайлагнана. Илрүүлсэн бүртгэлгүй хөрөнгийг эзэмшигч байгууллагын данс бүртгэлд тусгуулах асуудлаар дүгнэлт, саналыг тайландаа тодорхой тусгана.

2.4.9 Тооллогоор төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч бодитоор байхгүй байгаа нь илэрвэл тэдгээр хөрөнгийг “Дутагдуулсан үндсэн хөрөнгийн 2021 оны жилийн мэдээ” буюу Маягт-10-ыг бүрдүүлж тайлагнана. Байгууллагын комиссын тайланд дутагдуулсан хөрөнгийн шалтгаан, нөхцөл байдал, дансны үнэлгээ, хариуцах албан тушаалтны талаар дүгнэлт бичиж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулна. Холбогдох баримтыг тооллогын баримтад хуулбарлан хавсаргана.

2.4.10 Төрийн өмчид бүртгэлтэй, бүртгэлгүй байгаагаас үл хамааран тухайн байгууллагад хамаарах өмчлөл, эзэмшлийн асуудлаар аливаа маргаантай хөрөнгийг “Маргаантай үндсэн хөрөнгийн 2021 оны жилийн мэдээ” буюу Маягт ТӨ-11-ийг холбогдох зааврын дагуу бүрдүүлж тайлагнана. Тооллогын комиссын тайланд маргаантай хөрөнгийн шалтгаан, нөхцөл байдал, дансны үнэлгээ, хариуцах албан тушаалтны талаар дүгнэлт бичиж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулна. Холбогдох баримтыг тооллогын баримтад хуулбарлан хавсаргана.

2.4.11 Тухайн байгууллагад тооллогын үеэр ашиглахгүй (ашиглалтын шаардлага хангахгүй, эвдэрсэн г.м), эсвэл илүүдэлтэй байгаа үндсэн хөрөнгийг “Илүүдэлтэй, ашиглагдаагүй байгаа үндсэн хөрөнгийн бүртгэлийн 2021 оны жилийн мэдээ” буюу Маягт ТӨ-12 ийг холбогдох зааврын дагуу бүрдүүлснийг газар дээр нь тулган баталгаажуулна.

2.4.12 Байгууллагын комисс нь Засгийн газар, орон нутгийн захиргааны гэрээ хэлэлцээрийн үр дүнд гадаадын зээл тусламж, хандив, бэлэглэл, төслийн хөрөнгөөр бий болсон байгууллагын дансанд бүртгэлтэй, бүртгэлгүй /илрүүлэн/ хөрөнгийг тооллогод бүрэн хамруулна.

2.4.13 Төрийн /орон нутгийн/ өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн охин компани, хараат компани /хөрөнгө оруулалттай компани/, салбар тус бүр тооллогын энэхүү журмын дагуу бие даан тооллогыг хийж баримт материалаа бүрдүүлэн улсын дүнд нэгтгүүлнэ.

2.4.14 Байгууллагын тооллогын комисс ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийг данснаас хасах, актлан устгах, илүүдэлтэй болон ашиглахгүй хөрөнгийг шилжүүлэх, худалдах асуудлыг судалж, шаардлагатай баримт материалыг бүрдүүлэн холбогдох журмын дагуу шийдвэрлүүлэх санал бэлтгэнэ. Энэ талаар тайланд тусгана.

2.4.15 Тооллогын явцад өмч, хөрөнгийн талаар маргаан гарвал маргалдагч талууд өөрсдийн үндэслэл, тайлбарыг Төв болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Тооллогын комисст ирүүлнэ.

2.4.16 Газар, үл хөдлөх хөрөнгө бүхий төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд өөрийн эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгийн талаарх мэдээллийг газарзүйн нэгдсэн мэдээллийн сангаас авч тооллогын баримтад хавсаргаснаар тооллогод зөрчилгүй хамрагдсанд тооцогдоно. (газар эзэмшил, ашиглалтын талаарх мэдээллийг QR кодоор авна)

2.4.17 Байгууллагын эзэмшилд байгаа автотээврийн хэрэгслийг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ болон түүний тухайн нутаг дэвсгэрт байрлах салбар, нэгжээс ирүүлсэн энэ журмын 2.2.5-т заасан мэдээллийг тулган баталгаажуулж илэрсэн зөрчил дутагдлын талаар тэмдэглэл үйлдэж, түүнийг арилгах талаар санал боловсруулан тооллогын баримтад хавсаргана.

2.4.18 Төрийн өмчийн хороо (хуучнаар)-ны 2009 оны 258 дугаар тогтоолоор баталсан “төрийн өмчийн хөрөнгөөр бий болсон оюуны өмчийг бүртгэх журам”-д заасны дагуу 1993 оноос өмнө төрийн хөрөнгөөр санхүүжүүлэн бий болсон шинжлэх ухаан утга зохиолын бичмэл бүтээл, хөгжмийн урлагийн үгтэй болон үгүй бүтээл, хөгжимт жүжиг тайзны урлагийн төрөлд бүтээл, дуу авиа дүрст бүтээл (кино урлагийн бүтээл) гэх мэт бүтээлийн жагсаалтыг гаргаж бүртгэлгүй, үнэлгээгүй байхаас үл хамааран тооллогод бүрэн хамруулна.

Гурав. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогын мэдээ, тайланг цуглуулах, нэгтгэх

3.1 Тооллогын цахим мэдээллийн сан бүрдүүлэх - Тооллогод хамрагдаж буй хуулийн этгээд нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын www.pcsp.gov.mn цахим хуудасны burtgel.pcsp.gov.mn холбоосонд байршуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын систем”-ийн программ хангамжид өөрийн байгууллагын **нэвтрэх нэр, нууц үгийг** ашиглан хөрөнгийн (**төрийн нууцад хамаарах мэдээллээс бусад**) мэдээллийг бүрэн оруулна. Тус программаас холбогдох хэрэглээний программ руу хөрөнгийн тооллогын холбогдох маягтуудыг хөрвүүлэн хэвлэж, баталгаажуулна.

Тооллогын ажлын цахим мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор программ хангамжийг ашиглах, мэдээлэл оруулах, хөрвүүлэх, хянуулах ажлын талаар Төв комисс, аймаг, нийслэлийн тооллогын комисс сургалт зохион байгуулна.

3.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд нь эд хөрөнгийн тооллогын ажлыг холбогдох журам, зааврын дагуу гүйцэтгэж, тооллогын үндсэн маягтуудыг программ хангамжаас хөрвүүлэн Windows –ын Excel программ дээр “Times New Roman” фонттой, үсгийн хэмжээ 12 байхаар боловсруулж маягт бүрийг байгууллагын захирал /дарга/, ерөнхий нягтлан бодогч нарын гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулан 2 хувь бүрдүүлж аймаг, нийслэлийн Тооллогын комисст 2022 оны 6 дугаар сарын 15-ны дотор хүлээлгэн өгнө.

Байгууллагын хөрөнгийн тооллогын дэвтэрлэсэн хавтсанд дараах баримтыг заавал хуулбарлан хавсаргана:

- ✓ газрын гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг (www.egazar.gov.mn)-ээс авах,
- ✓ газар дээрх барилга байгууламжийн байршил зүйн зураг,
- ✓ барилга байгууламжийн фото зураг,
- ✓ барилгын доторх зохион байгуулалтын схем зураглал
- ✓ Нурсан, эвдэрсэн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгийн талаарх мэргэжлийн байгууллага, комиссын акт, дүгнэлт

3.3 Тооллогын комисс Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн бүрдүүлсэн тооллогын баримт материал (дэвтэрлэсэн)-ыг шалган, “**Хяналтын хуудас**”, “**Тооллогын комиссын тэмдэглэл**”-ээр баталгаажуулан нэг хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Орон нутгийн өмчийн газрын архивд хүлээн авч, үлдэх хувийг байгууллагын архивд үлдээнэ. Шаардлагатай гэж үзвэл тооллогын баримтын 3 дахь хувийг үйлдэж удирдах дээд байгууллагын хэрэгцээнд хүргүүлж болно.

3.4 Монголбанк, Батлан хамгаалах яам, Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар нь өөрийн харьяа тооллогод хамрагдсан нэгж байгууллага тус бүрийн төрийн өмчийн тооллогын баримт материалыг тус бүр 1 хувь бүрдүүлэн, нэгдсэн дүнгийн хамт 2022 оны 7 сарын 30-ны дотор Төв комисст цаасаар болон нэгтгэлийг цахим файлаар хүлээлгэн өгнө.

3.5 Сум дүүргийн өмчийн тооллогын баримтыг Аймаг, нийслэлийн Тооллогын комисс нэгтгэж, Төв комисст ирүүлнэ.

3.6 Аймаг, нийслэлийн Тооллогын комисс нь орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдээс авсан тооллогын материалыг үндэслэн нэгдсэн дүнг Төв комиссоос баталсан нэгтгэлийн хүснэгтүүдээр бэлтгэн гаргаж, тайланг, нэгтгэлийн цахим файлын хамт 2022 оны 8 дугаар сарын 15-ны дотор Төв комисст хүлээлгэн өгнө. Тооллогын комисс төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын мэдээг программ хангамжид бүрэн оруулсан эсэхэд хяналт тавьж, энэ талаар тайлан бэлтгэн Төв комисст ирүүлнэ.

3.7 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас томилогдсон Тооллогын комисс (төлөөлөгч) нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс цаасаар болон цахим файлаар хүлээн авсан хөрөнгийн тооллогын баримт материалыг үндэслэн дүнгээ Төв комиссоос баталсан нэгтгэлийн хүснэгтүүдээр бэлтгэн, илтгэх хуудасны хамт Төв комисст 2022 оны 8 дугаар сарын 30-ны дотор хүлээлгэн өгөх ба тооллогын бүртгэлийн дэвтрийн хуудсыг дугаарлан аймаг, дүүргээр нь архивын нэгж болгон үдэж байгууллагын архивд хүлээлгэн өгнө.

3.8 Төв комисс, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс нь төрийн болон орон нутгийн эд хөрөнгийн тооллогын дүнг нэгтгэн, нэгдсэн тайлан бэлтгэж 2022 оны 10 дугаар сарын 30-ны дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулна.

3.9 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар улсын үзлэг, тооллогын нэгдсэн дүн, тайланг 2022 оны 11 дүгээр сард багтаан гаргаж 2022 оны 12 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулна.

3.10 Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогыг хийгээгүй, тогтоосон хугацаанд санхүүгийн тайлан, тооллогын дэвтэр, маягтыг бөглөж, баталгаажуулан бүрдүүлж ирүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагын дарга, нягтлан бодогч нарт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.1.2, 23.1.3 заалт болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oO-----

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 02 дугаар сарын 22-ний өдрийн
64 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТООЛЛОГЫН ҮР ДҮНГИЙН МАЯГТ, ХҮСНЭГТИЙГ АШИГЛАХ ЗААВАР

Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын явцад мэдээлэл цуглуулах асуулгууд нь маягт хэлбэрээр өгөгдөх бөгөөд тэдгээрийг нэгтгэн дэвтэрлэж гарын авлага болгон байгууллага бүрт хүргүүлнэ.

Энэхүү дэвтэрт тооллогын талаарх шийдвэр болон тооллогын маягтуудаас гадна тэдгээрийг хэрхэн бөглөж тайлагнах талаарх энэхүү заавар багтана.

АСУУЛГА БҮХИЙ МАЯГТУУД

Байгууллагын тооллогын хяналтын хуудас –Байгууллагын Тооллогын комисс маягтуудыг бөглөж тооллого явуулахад бэлэн байх бөгөөд тэдгээрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Орон нутгийн Тооллогын комисс хянаж, Хяналтын хуудсыг бөглөнө.

Үндэсний статистикийн хорооноос зөвшөөрөл олгосны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 323 дугаар тогтоолоор баталсан төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн болон захиргааны статистикийн дараах маягтуудыг тооллогын дүнг тайлагнахад ашиглана. Маягт тус бүрийн доор байгууллагын дарга, нягтлан бодогч нар болон тооллогын комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулна.

Байгууллагын тооллогын комисс тооллого явуулсан тухай тайланг бичгээр бэлтгэн, гарын үсэг зурж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Орон нутгийн өмчийн газрын Тооллогын комиссоор баталгаажуулан тооллогын дэвтэрлэсэн баримтад оруулна. Тооллогын комиссын энэхүү тайлан, хяналтын хуудасны дараа дараах мэдээллийн болон бүртгэлийн маягтуудыг бүрдүүлэн хавсаргана.

Байгууллагын комисс доор заасан маягтуудаас эзэмшиж буй хөрөнгөтэй уялдуулан өөрийн байгууллагад хамаарал бүхий маягтуудыг бөглөнө.

МЭДЭЭЛЛИЙН МАЯГТ

Маягтын дугаар:

1. **ТӨХ -1:**
2. **Хүснэгт№Т-1:**

Маягтын нэр:

Хуулийн этгээдийн ерөнхий мэдээлэл
Барилга байгууламж түрээсэлж ашигладаг байгууллагын судалгаа

ХӨРӨНГИЙН ТООЛЛОГЫН МАЯГТУУД

3. **ТӨХ -2:** Байгууллагын эзэмшил /ашиглах/ газрын бүртгэл
4. **ТӨХ -3:** Барилга, байгууламжийн бүртгэл
5. **ТӨХ -3.1:**(барилга тус бүрээр) барилга байгууламжийн хийц, хэмжээсийн бүртгэл
6. **ТӨХ -4:** Байгууллагын мэдлийн нийтийн эзэмшлийн байгууламжийн бүртгэл
7. **ТӨХ -5:** Машин тоног төхөөрөмжийн бүртгэл
8. **ТӨХ -6:** Тээврийн хэрэгслийн бүртгэл

- 9. **ТӨХ -7:** Тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн бүртгэл
- 10. **ТӨХ -8:** Үндсэн сүргийн мал, амьтадын бүртгэл
- 11. **ТӨХ -9:** Худаг, услалтын системийн бүртгэл
- 12. **ТӨХ -10:** Оюуны өмчийн бүртгэл

ЗАХИРГААНЫ СТАТИСТИКИЙН МАЯГТУУД

- 13. **ТӨ-1:** Дуусаагүй барилга байгууламжийн 2021 оны жилийн бүртгэл
- 14. **ТӨ-3:** Биет бус хөрөнгийн бүртгэлийн 2021 оны жилийн бүртгэл
- 15. **ТӨ-4:** Түрээслүүлсэн хөрөнгийн 2021 оны жилийн мэдээ
- 16. **ТӨ-5:** Үнэт зүйлсийн 2021 оны жилийн мэдээ- бүртгэл
- 17. **ТӨ-13.1:** Улсын (орон нутгийн) чанартай авто замын 2021 оны жилийн мэдээ
- 18. **ТӨ-13.2:** Улсын (орон нутгийн) чанартай гүүрний 2021 оны жилийн мэдээ
- 19. **ТӨ-14:** Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 2021 оны жилийн мэдээ
- 20. **ТӨ-15:** Радио долгионы 2021 оны жилийн мэдээ

ТООЛЛОГЫН ҮР ДҮНГЭЭР ТАЙЛАГНАХ МАЯГТУУД

- 21. **ТӨ-9:** Бүртгэлд тусгаагүй үндсэн хөрөнгийн бүртгэл
- 22. **ТӨ-10:** Дутагдуулсан үндсэн хөрөнгийн бүртгэл
- 23. **ТӨ-11:** Маргаантай үндсэн хөрөнгийн бүртгэл
- 24. **ТӨ-12:** Илүүдэлтэй, ашиглагдаагүй байгаа үндсэн хөрөнгийн бүртгэлийн бүртгэл

Дээрх маягтуудыг 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар, төгрөгөөр бөглөнө.

МАЯГТ, ХҮСНЭГТ АШИГЛАХ ЗААВАР

Маягт тус бүр нь Үндэсний статистикийн хорооноос зөвшөөрсөн “нөхөх заавар”-тай.

Мэдээллийн маягт:

1. ТӨХ -1: Хуулийн этгээдийн ерөнхий мэдээлэл: Энэхүү маягтад байгууллагын албан ёсны нэр, хаяг, регистрийн дугаар, хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр, төрийн болон орон нутгийн өмчийн эзлэх хувь, үйл ажиллагааны чиглэл, хувьцааны тоо зэрэг мэдээллийг агуулна. Энэхүү маягтыг бөглөхдөө тухайн хуулийн этгээд улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэх бөгөөд, гэрчилгээний хуулбарыг тус маягтад хуулбарлан хавсаргана. Гэрчилгээнд бүртгэлтэй мэдээлэл өөрчлөгдсөн, эсвэл хуулийн этгээдийн зохион байгуулалт өөрчлөгдсөн бол цаашид хуулийн этгээдийн бүртгэлийг шинэчлэх асуудлаар саналаа боловсруулан энэ талаар тайланд тодорхой бичиж тэмдэглэнэ.

2. Хүснэгт№Т-1: Барилга байгууламж түрээсэлж ашигладаг байгууллагын судалгаа: Өөрийн байргүй (эсхүл байр дутагдалтай) байгууллагууд бусдаас (төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэний) байранд түрээсийн, ашиглалтын гэрээгээр (гэрээгүй бол шийдвэр) байрладаг бол **Хүснэгт № Т-1**-ийг бөглөж, тооллогын баримтад хавсаргана.

Хөрөнгийн тооллогын маягтууд:

3. ТӨХ -2: Байгууллагын эзэмших /ашиглах/ эрх бүхий газрын бүртгэл:

Энэхүү маягыг Газрын гэрчилгээ, гэрээ, кадастрын зургийг харж бөглөнө. Хуулийн этгээд өөрийн газар эзэмших, ашиглах эрхээ Улсын бүртгэлд бүртгүүлсэн байх ёстой бөгөөд уг маягтын “улсын бүртгэлийн дугаар” гэсэн асуулгад “Г-.....” гэж улсын дугаараа нөхөж бичнэ. Бусад асуулгыг зааврын дагуу нөхнө. Энэхүү маягтад газрын гэрчилгээ, кадастрын зургийг хуулбарлан хавсаргана.

Газрын кадастрын зурагт түшиглэн “**байршил зүйн схем зураг**”-ийг үйлдэх бөгөөд тухайн газар дээрх барилга байгууламж, газар дээрх болон доорх инженерийн шугам сүлжээ, байгууламж, нийтийн эзэмшлийн байгууламж, ногоон байгууламжийг танигдахуйц байдлаар зураглалд оруулж, тайлбар, тэмдэглэгээг хийнэ. Хэрэв газрын гэрчилгээ, кадастрын зураг дахь газрын хэмжээ зөрүүтэй бол энэ талаар тайлбар бичиж тооллогын комиссын актад заавал тусгана.

Энэ маягтад газар зүйн мэдээллийн системээс авсан QR код бүхий баримтыг хавсаргана

Газар, үл хөдлөх хөрөнгөтэй боловч QR кодтой баримт авч чадаагүй бол аймаг, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас авсан тодорхойлолт тайлбарыг хавсаргана

ЖИЧ: Энэ маягтад 2018 оны үнэлгээний журамд орсон газрын байршил, бүсчлэл, зориулалт, суурь үнэлгээ зэрэг зарим асуулга нэмэгдсэн

1. ТӨХ -3: Барилга, байгууламжийн бүртгэл: Тухайн байгууллагын “барилга байгууламж” дансанд бүртгэлтэй хөрөнгийн жагсаалтыг энэ маягтаар гаргах бөгөөд бүртгэлгүй болон дутагдсан хөрөнгө байхгүй бол Санхүүгийн тайланд туссан дүнтэй маягтын дүн таарна. Барилга байгууламжийн бүртгэлийн маягтад барилга тус бүрийг нэг бүрчлэн бүртгэж, нэр, ашиглалтад орсон он, балансын анхны өртөг, хуримтлагдсан элэгдэл, үлдэгдэл үнэ зэрэг мэдээллийг бичнэ.

• Энэ маягтад газар зүйн мэдээллийн системийн urban.gov.mn хаягаас авсан QR код бүхий баримтыг хавсаргана

• Үл хөдлөх хөрөнгөтэй боловч QR кодтой баримт авч чадаагүй бол аймаг, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас авсан тодорхойлолт тайлбарыг хавсаргана.

ЖИЧ: Энэ маягтад нэгдсэн судалгаа гаргах зорилгоор 2018 оны үнэлгээний журамд орсон барилгын хийц, ангилал болон ТӨХ-3.1-д байгаа зэрэг зарим асуулга нэмэгдсэн.

2. ТӨХ-3.1: барилга байгууламжийн хийц, хэмжээсийн бүртгэл:

Энэ маягыг ТӨХ-3-д жагсаасан барилга тус бүрээр энэ маягыг бэлтгэж, фото зургийг наана. Байгууллагад барилга бүрийн хувийн хэргийг хөтөлж байх шаардлагыг Өмч эзэмшлийн гэрээний хүрээнд тавьдаг тул уг хувийн хэргээс энэ маягыг нөхөхөд хялбар байх юм. Энэ маягтад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Орон нутгийн өмчийн газраас томилогдсон Тооллогын комиссын тайлбар тэмдэглэл хийх хэсэгт барилга тус бүрийн талаар шаардлагатай мэдээллийг оруулах бол гараар тэмдэглэн бичнэ.

3. ТӨХ-4: Байгууллагын мэдлийн нийтийн эзэмшлийн байгууламжийн бүртгэл: Тухайн байгууллагын “Нийтийн эзэмшлийн байгууламж”-ийн жагсаалтыг энэ маягтаар гаргах бөгөөд Санхүүгийн тайланд “барилга байгууламж, эсвэл бусад үндсэн хөрөнгө дансанд туссан байдаг тул энэ маягтад тусад нь тайлагнан харуулах юм. Нийтийн эзэмшлийн байгууламж үнэлгээгүй, тэдгээрийг санхүүгийн тайланд тусгаагүй бол бүртгэлгүй хөрөнгийн жагсаалтад оруулж цаашид үнэлж бүртгэх арга

хэмжээ авна. Энэ маягтад оруулсан нийтийн эзэмшлийн байгууламж санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн аль дансанд орж тайлагнагдсан болохыг тооллогын тайланд тайлбарлан бичнэ.

4. ТӨХ-5: Машин тоног төхөөрөмжийн бүртгэл: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй машин тоног төхөөрөмжийг нэр төрлөөр нь жагсаан бүртгэх бөгөөд, зааврын дагуу бөглөнө. Энэ байгууллагын үндсэн хөрөнгийн “машин тоног төхөөрөмж” , “батлан хамгаалах тоног төхөөрөмж” зэрэг дансанд бүртгэлтэй хөрөнгийг хамтатган бүртгэнэ.

5. ТӨХ-6: Тээврийн хэрэгслийн бүртгэл – Энэхүү маягтад автотээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй хөрөнгийг нэг бүрчлэн жагсаах бөгөөд улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг уг маягтад хуулбарлан хавсаргана. Тээврийн хэрэгсэл тухайн хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй байх ёстой бөгөөд өөр этгээдийн нэр дээр бүртгэлтэй бол тооллогын комиссын тайланд энэ талаар заавал тайлбар оруулж, цаашид залруулах арга хэмжээ авна.

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-аас өөрийн байгууллагын эзэмшилд байгаа нийт автотээврийн хэрэгслийн нэр төрөл, тоо, улсын дугаар, эзэмшигч, даатгал, татвар, төлбөр хураамж, торгууль, үзлэг оношилгооны нэгдсэн мэдээллийг жагсаалтаар гаргуулан авч тооллогод хамрагдсан дүнтэй тулган баталгаажуулж, үр дүнг энэ маягтад хавсаргана.

6. ТӨХ-7: Тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн бүртгэл- энэхүү маягтад Санхүүгийн тайланд “тавилга эд хогшил”, “бусад үндсэн хөрөнгө”, “номын фонд” зэргээр тайлагнасан хөдлөх үндсэн хөрөнгийг бүгдийг нь ТӨХ-7-д нэгтгэн тайлагнана. Номыг бөөн дүнгээр нь буюу фондоор нь уг маягтад тайлагнана, ингэхдээ нийт тоо ширхэг, үнийг тусгана. Энэхүү хөрөнгийн бүртгэлд туссан хөрөнгөөс иргэний зориулалтаар ашиглаж буй буу, галт зэвсэг зэрэг тусгайлсан гэрчилгээ, хувийн хэрэг шаардах хөрөнгийн мэдээлэлтэй танилцан бүртгэлийн зөрчил байгаа бол энэ талаар Тооллогын комиссын тайланд тусгана.

7. ТӨХ-8: Үндсэн сүргийн мал, амьтадын бүртгэл - Байгууллагын үндсэн хөрөнгийн болон эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй мал амьтадыг энэ маягтад бүртгэнэ. Харин үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй бол “үндсэн сүргийн”, эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй бол “эргэлтийн сүргийн” гэж тодотгоно.

8. ТӨХ-9: Худаг, услалтын системийн бүртгэл - Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй худаг, услалтын системийг холбогдох маягтад нэрээр нь бүртгэж харуулахаас гадна нэг бүрчлэн энэ маягтад холбогдох зааврын дагуу тайлагнана. Аль дансанд бүртгэлтэй эсэхийг нягталж, тэмдэглэнэ.

9. ТӨХ -10: Оюуны өмчийн бүртгэл – Энэ маягтад байгууллагын биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй болон бүртгэлгүй геологи хайгуулын судалгаа, тооцоолох техникийн программ хангамж, утга зохиол, урлагийн эх бүтээл, патент, лиценз, гудвилл, зохиогчийн эрх, барааны тэмдэг, зохион байгуулалтын зардал зэрэг биет бус хөрөнгийг асуулгын дагуу бүртгэнэ.

10. ТӨ-3: маягтаар байгууллагын санхүүгийн тайлангийн “биет бус хөрөнгө”-ийн дүнтэй тааруулан зааврын дагуу бөглөж, тооллогод хамруулна. (биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй газар эзэмших эрхийн бүртгэлийг ТӨХ-2 маягтаар тусад нь тайлагнана.)

11. **ТӨ-5:** маягтаар байгууллагын санхүүгийн тайлангийн “түүх соёлын дурсгалт зүйлс” дансанд бүртгэлтэй музейн үзмэр, эд өлгийн зүйлийг бүртгэн тайлагнана.

12. Өөрийн байргүй (эсхүл байр дутагдалтай) байгууллагууд бусдаас (төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэний) байранд түрээсийн, ашиглалтын гэрээгээр (гэрээгүй бол шийдвэр) байрладаг бол **Хүснэгт № Т-1**-ийг бөглөж, тооллогын баримтад хавсаргана.

13. **ТӨХ -3, 4, 5, 6, 7, 8** дээрх хөрөнгийн бүртгэлийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдлийн дүн нь 2021 оны Санхүүгийн тайланд туссан холбогдох дансны эцсийн үлдэгдэлтэй таарах ёстой. Тэдгээрээс гадна маягт тус бүр өөрийн гэсэн онцлог нэмэлт мэдээллийг агуулж байгаа.

14. Захиргааны статистикийн маягт буюу бусад ТӨ маягтуудыг зааврын дагуу 2022 оны 3 дугаар сарын 5-ны дотор Орон нутгийн өмчийн алба болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн байх ёстой бөгөөд тооллогын үеэр уг мэдээ тайланг гаргаагүй бол нөхөж бүрдүүлнэ. ТӨ маягтуудыг төрийн өмчийн бүртгэлийн маягтуудын дүн, тайланг 2021 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн хөдлөлийн тайлан, санхүүгийн тайланд орсон дүнтэй тулган шалгахад ашиглана.

15. Тооллогод ашиглах бүх маягтад байгаа хөрөнгө, үйл ажиллагааны төрөл, ангиллын кодыг эрх бүхий байгууллагаас шинэчлэн баталсан шийдвэрийн дагуу нөхнө. Сангийн сайд, ҮСХ-ны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 319/А/160 дугаар тушаалаар батлагдсан "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, ангиллын тодорхойлолт"-ын дагуу үйл ажиллагааны чиглэлийг 5 оронгийн түвшинд, барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга, эд хогшлын зориулалт, ангилал, хийцийн кодыг холбогдох хавсралтаас авч нөхнө.

16. **Тухайн байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг** үндсэн хөрөнгийн тооллогын дүнд хяналт тавих байдлаар ашиглана. – Аудитлагдсан санхүүгийн тайлангаас баланс буюу үлдэгдлийн тэнцэл, орлого үр дүнгийн тайлан, үндсэн хөрөнгийн тодруулгыг хуулбарлан тооллогын материалд хавсаргана. Энэ нь тооллогод хамрагдах ёстой үндсэн хөрөнгийн жагсаалтын үнэн зөвийг болон хөрөнгийн дүнг тулган баталгаажуулахад ашиглагдана.

-----oOo-----

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТООЛЛОГЫН
ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хуулийн этгээдийн /хөрөнгийн/ нэр:

Байршил:

Аймаг, нийслэлийн нэр

Сум, дүүргийн нэр

Өмчлөл:

Төрийн
 Орон нутгийн
/зөвлөх/

Нийслэл, Аймаг, Сум, Дүүрэг
/доогуур зурах/

№	Асуулга	Бүрдүүлсэн маягт, мэдээ	Тоо ширхэг /хуудас/	Тэмдэглэл /зөвхөн ТӨБЗГ, ОНӨА-ны Тооллогын комисс бөглөнө/
Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын материалын маягтуудыг бүрдүүлсэн байдал				
1	Байгууллагын даргын тооллогын комиссын тушаал	Тушаал		
2	Шат шатны тооллогын комиссын тэмдэглэл	Тэмдэглэлийн хуудас		
3	Байгууллагад тооллого явуулсан тухай илтгэх хуудас, тооллогын дүнг баталгаажуулсан дүгнэлт	Бичмэл тайлан, гарын үсэгтэй, тоо, дүнг баталгаажуулах		
4	Хуулийн этгээдийн ерөнхий мэдээлэл	ТӨХ-1		
5	Байгууллагын эзэмшиж/ашиглаж/ буй газрын бүртгэл	ТӨХ-2		
6	Барилга байгууламжийн бүртгэл	ТӨХ-3		
7 барилга, байгууламжийн хийц, хэмжээсийн бүртгэл	ТӨХ-3.1		(Барилга тус бүрд үйлдэж, фото зураг наана)
8	Нийтийн эзэмшлийн байгууламжийн бүртгэл	ТӨХ-4		(Барилгын болон бусад хөрөнгийн дансны алинд бүртгэлтэйг тэмдэглэх)
9	Машин тоног төхөөрөмжийн бүртгэл	ТӨХ-5		
10	Тээврийн хэрэгслийн бүртгэл	ТӨХ-6		
11	Тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн бүртгэл	ТӨХ-7		
12	Үндсэн сүргийн мал, амьтадын бүртгэл	ТӨХ-8		
13	Худаг, услалтын системийн бүртгэл	ТӨХ-9		
14	Оюуны өмчийн бүртгэл	ТӨХ-10		
15	Дуусаагүй барилга	ТӨ-1		
16	Биет бус хөрөнгийн мэдээ	ТӨ-3		
17	Түрээслүүлсэн үндсэн хөрөнгийн мэдээ	ТӨ-4		
18	Түүх, соёлын дурсгалт зүйлсийн мэдээ	ТӨ-5		
19	Улсын/орон нутгийн/ чанартай авто замын мэдээ	ТӨ-13.1		
20	Улсын /орон нутгийн/ чанартай гүүрийн мэдээ	ТӨ-13.2		
21	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээ	ТӨ-14		
22	Радио долгионы мэдээ	ТӨ-15		
Тооллогын үр дүнгийн мэдээлэл				
23	Бүртгэлд тусгаагүй үндсэн хөрөнгийн мэдээ	ТӨ-9		
24	Дутагдуулсан үндсэн хөрөнгийн мэдээ	ТӨ-10		
25	Маргаантай үндсэн хөрөнгийн мэдээ	ТӨ-11		
26	Илүүдэлтэй, ашиглалтгүй байгаа үндсэн хөрөнгийн мэдээ	ТӨ-12		
27	Бусдаас түрээсэлдэг байр талбайн мэдээлэл	маягтаар		
28	Бусад			
Нийт		маягтын тоо хуудас	

Бүрдүүлсэн:

Байгууллагын Тооллогын комисс:

Ахлагч:

Гишүүд:

гарын үсэг

/нэр/

Хянасан:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын /ОНӨГ/-ны Тооллогын комисс:

Ахлагч:

Гишүүд:

гарын үсэг

/нэр/

Тооллогын материал бүрдүүлсэн огноо

ТООЛЛОГЫН КОМИССЫН ТЭМДЭГЛЭЛ

1. Хуулийн этгээдийн Тооллогын комисс:

Огноо:

2. Аймаг, нийслэлийн Тооллогын комисс:

Огноо:

3. Тооллогын Төв комисс:

Огноо:

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЛИЙН
2021 ОНЫ БҮРТГЭЛ**

1.Ерөнхий мэдээлэл

а. Нэрийн хэсэг

Хуулийн этгээдийн нэр:

Регистрийн дугаар:

Улсын бүртгэлийн дугаар:

Байгуулагдсан огноо: _____ / ____ / ____ (он/сар/өдөр)

Хариуцлагын хэлбэр:

Өмчийн хэлбэр: %

Өмч эзэмшигчийн дугаар:

б. Хаягийн хэсэг

	Нэр	Код
Аймаг, нийслэл		
Сум, дүүрэг		
Оршин байгаа хаяг		
Утас		
Факс		
Цахим шуудан		

в. Харьялал

Харьяалах дээд
байгууллагын нэр

Харьяалах дээд байгууллагын
регистрийн дугаар

Салбарын тоо

Охин компаний тоо

2. Үйл ажиллагаа, ажиллагчдын тоо

	мд	Эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл	Код				Ажиллагч- дын жилийн дундаж тоо
			/1 дүгээр хавсралтаас/				
Үндсэн үйл ажиллагаа	1						
Хоёр дахь үйл ажиллагаа	2						
.....	3						
.....	4						
.....	5						
.....	6						
.....	7						
.....	8						
.....	9						
БҮГД	10						

3. Хөрөнгө, хувьцаа

Нийт хөрөнгийн хэмжээ (2021.12.31)	төг.	Нийт хувьцааны тоо	
Үүнээс: төрийн өмчийн хөрөнгийн хэмжээ (Засгийн сан/дүрмийн сан)	төг.	Үүнээс: төрийн эзэмшлийн	
		Нэгж хувьцааны нэрлэсэн үг	төг.

Дарга/захирал / /
Тамга гарын үсэг нэр
Ерөнхий нягтлан бодогч / /
..... гарын үсэг нэр

20 ... оны ... -р сарын ... -ны өдөр

ТӨХ-1: НӨХӨХ ЗААВАР

Маягтын **нэрийн хэсэгт** Хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар, байгуулагдсан огноо, хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэрийг улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн үнэн зөв нөхнө.

Хариуцлагын хэлбэрийн кодыг бөглөхдөө хувьцаат компани -31, хязгаарлагдмал хариуцлагатай компани- 32 төрийн өмчит үйлдвэрийн газар- 40, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар- 50 төсөвт байгууллага- 60, бусад-80 гэсэн кодыг нөхнө.

Өмчийн хэлбэрийг улсын бүртгэлийн гэрчилгээнээс харж бичээд Төрийн өмчийн-11, Төрийн өмчийн оролцоотой-12, Төрийн өмчийн оролцоотой /хамтарсан/-13, Орон нутгийн өмчийн-31, Орон нутгийн өмчийн оролцоотой-32, Орон нутгийн өмчийн оролцоотой /хамтарсан/-33 гэсэн кодыг нөхнө. Хэрэв өмчийн хэлбэрийн код нь 12, 13, 32, 33 бол төрийн болон орон нутгийн өмчийн эзлэх хувийг нөхнө.

Өмч эзэмшигчийн дугаарт тухайн байгууллагын **Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай** байгуулсан өмч эзэмшлийн гэрээний дугаарыг бичнэ.

Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг **төрийн өмчит** хуулийн этгээд гэнэ /Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 13 дугаар зүйлд зааснаар/.

Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хөрөнгийн тодорхой хувийг оруулсан хуулийн этгээдийг **төрийн өмчийн оролцоотой** хуулийн этгээд гэнэ.

Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийн хөрөнгөтэй нийлүүлж хамтран байгуулсан үйлдвэрийг төрийн өмчит этгээдэд хамааруулна.

Хаягийн хэсэгт Хуулийн этгээдийн оршин буй аймаг, нийслэл, сум, дүүргийн нэрийг бичиж, холбогдох кодыг 10 дугаар хавсралтын дагуу нөхөх ба оршин байгаа хаяг дээр төв буюу толгой компанийн дэлгэрэнгүй хаяг, утасны дугаар, факс, цахим шуудангийн хаягийг тодорхой бичнэ.

Харьяаллын талаарх мэдээлэл хэсэгт харьяалах дээд байгууллагын нэр, регистрийн дугаар болон салбар байгууллагын тоо, охин компаний тоог нөхнө.

Харьяалах дээд байгууллага гэж аж ахуйн нэгж, байгууллагын хэтийн болон цаг үеийн бодлого, төлөвлөгөө боловсруулан удирдамж, мэдээлэл, зааварчилгаа, зөвлөмжөөр хангадаг, санхүүгийн хувьд бие даасан хуулийн этгээд юм.

Охин компани гэдэг нь компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан хуулийн этгээдийг хэлнэ. Охин компани нь тусдаа санхүүгийн тайлан гаргахын зэрэгцээ толгой компанитайгаа нэгдсэн тайлан гаргана. /"Компанийн тухай" Монгол улсын хуулийн 2-р бүлгийн 6-р зүйлийн 2, 4-р хэсэгт зааснаар/

Салбар нь толгой компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг тусгай нэгж бөгөөд компанийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь, түүнчлэн төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэж болно. /"Компанийн тухай" Монгол улсын хуулийн 2-р бүлгийн 7-р зүйлийн 1-р хэсэгт зааснаар/

Эрхэлж байгаа үйл ажиллагааны хэсэгт хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийн нэрийг нөхөхдөө эдийн засгийн үйл ажиллагааны стандарт ангиллын дагуу дэлгэрэнгүй тодорхой бичнэ. Жнь: компьютерийн сэлбэг хэрэгслийн жижиглэнгийн худалдаа, талх, нарийн боовны жижиглэнгийн худалдаа гэж тодорхой нөхнө. Сангийн сайд, ҮСХ-ны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 319/А/160 дугаар тушаалаар батлагдсан "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, ангиллын тодорхойлолт"-ын дагуу үйл ажиллагааны чиглэлийг 5 оронгийн түвшинд тодорхойлж 1 дүгээр хавсралтаас харж нөхнө.

Тухайн байгууллага үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын дийлэнх хувийг бүрдүүлэгч үйл ажиллагааг үндсэн үйл ажиллагаа гэж тодорхойлно.

Үйл ажиллагааны чиглэл бүрт ажиллагчдын тоог нөхнө. Ажиллагсдын тоог тухайн жилийн дундаж тоогоор тооцож гаргана. Хөрөнгийн талаарх мэдээлэл хэсэгт аж ахуйн нэгж, байгууллагын тухайн жилийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй бүх хөрөнгийн нийт дүнг санхүүгийн тайланд тусгагдсанаар, түүнээс төрийн өмчийн хөрөнгийн хэмжээг, жилийн эцсийн нийт хувьцааны тоо, түүнээс төрийн өмчийн хувьцааны тоо болон нэгж хувьцааны нэрлэсэн үнийг санхүүгийн тайлангаас нөхнө.

Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ гэж тухайн хувьцааг анх гаргахдаа тогтоосон үнийг хэлнэ.

***Тооллогын програм хангамжид хуулийн этгээдийн талаарх мэдээлийг оруулахдаа дээрх зааврыг анхаарч бүрэн гүйцэд оруулна уу. Програмаас маягтыг татан авч (хөрөөлэн) хэвлэхдээ зөвхөн та бүхний сонгосон мэдээллийг гаргах болно.**

Лавлах:

Маягтын талаарх лавлагааг доорх утсаар авна уу.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Утас: 51-263021, 51-263025, 51-263016

**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭЗЭМШИЖ/АШИГЛАЖ БУЙ ГАЗРЫН
2022 ОНЫ БҮРТГЭЛ**

1.Хаягийн хэсэг

	Нэр	Код
Аймаг, нийслэл		
Сум, дүүрэг		
Хуулийн этгээдийн нэр		
Регистрийн дугаар		
Өмч эзэмшигчийн дугаар		

2. Эзэмшиж/ашиглаж буй газрын үзүүлэлт

Үзүүлэлт	МД	Газар-1	Газар-2	Газар-3	Газар-4
А	Б	1	2	3	4
Газрын улсын бүртгэлийн дугаар	1				
Газар эзэмших/ашиглах эрхийн гэрчилгээ	Дугаар	2			
	Огноо	3			
	Хугацаа	4			
Газар эзэмшүүлэх/ашиглах шийдвэр олгосон байгууллагын	Нэр	5			
	Дугаар	6			
	огноо	7			
Газрыг: эзэмшиж байгаа-1, ашиглаж байгаа-2	8				
Газар эзэмших/ашиглах гэрээний	Дугаар	9			
	Огноо	10			
	Хугацаа	11			
Кадастрын зураг дахь нэгж талбарын дугаар	Шинэ	12			
	Хуучин	13			
Нийт талбай, м ²	14				
Жилийн төлбөр /төг/	15				
Газрын байршил /хаяг/	16				
Газар ашиглалтын байдал /ашиглаж байгаа-1, нөөцөнд	17				
Газрын үнэлгээний зэрэглэл (бус)-ийн дугаар	(Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоос)	18			
Газар ашиглалтын зориулалт		19			
Газар эзэмших/ашиглах гэрчилгээг барьцаалсан бол шийдвэр гаргасан	Нэр	20			
	Дугаар	21			
	Огноо	22			
Газар эзэмших/ашиглах хугацааг сунгасан шийдвэрийн байгууллагын	Дугаар	23			
	Огноо	24			
	Хугацаа	25			
Тухайн зэрэглэлд хамаарах суурь үнэлгээ /төг/ (Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоос)	26				
Газрыг өмчлөх (биет хөрөнгө), эзэмших,ашиглах (биет бус) эрхийн үнэлгээ (төг.)	27				
Эзэмшиж/ашиглаж буй газар дахь барилга, байгууламжийн нэр	28				

Тамга Дарга/захирал /
гарын үсэг нэр

Ерөнхий нягтлан бодогч /
гарын үсэг нэр

20 . . . оны . . .-р сарын . . .-ны өдөр

ТӨХ-2: НӨХӨХ ЗААВАР

Маягтын хаягийн хэсэгт Хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр, кодыг 10 дугаар хавсралтын дагуу нөхнө. Өмч эзэмшигчийн дугаарт тухайн байгууллагын **Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай** байгуулсан өмч эзэмшлийн гэрээний дугаарыг бичнэ.

Газар эзэмшил/ашиглалтын хэсэгт тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил/ашиглалтад байгаа газрын холбогдох үзүүлэлтийг нөхнө. Газар эзэмшиж байгаа бол асуултанд байгаа эзэмших гэдэг үгийн, харин ашиглаж байгаа бол ашиглах гэдэг үгийн доогуур зурна.

Газар эзэмших гэдэг нь газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг; **газар ашиглах** гэдэг нь хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг тус тус хэлнэ.

1-р мөрөнд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон газрын улсын бүртгэлийн дугаарыг нөхнө.

2, 3, 4-р мөрөнд газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар болон түүнийг олгосон огноо, хугацааг он/сар/өдөр гэсэн дарааллын дагуу нөхнө. Газар эзэмших эрхийн гэрчилгээ гэдэг нь "Газрын тухай" Монгол Улсын хуулийн дагуу Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийг баталгаажуулсан баримт бичиг юм.

5, 6, 7-р мөрөнд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тухайн аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх шийдвэр гаргасан байгууллагын нэр, дугаар, огноог он/сар/өдөр гэсэн дарааллаар нөхнө.

8-р мөрөнд газрын эзэмшил/ашиглалтын хэлбэрээс тохирох кодыг нөхнө. Эзэмшиж байгаа бол 1, ашиглаж байгаа байгаа бол 2-гэж нөхнө.

9, 10, 11-р мөрөнд газар эзэмшил, өмчлөлийн гэрээний дугаар, огноо, эзэмших/өмчлөх хугацааг нөхнө.

12, 13-р мөрөнд газрын кадастрын зураг дахь шинэ хуучин нэгж талбарын дугаарыг нөхнө. /Хэрэв шинэ нэгж талбарын дугаараа мэдэхгүй бол egazar.gov.mn цахим системээс харж болно./

14-р мөрөнд газрын хэмжээг буюу талбайг м.кв-аар нөхнө

15-р мөрөнд газар эзэмшил/ашиглалтын 1 жилийн хугацааны төлбөрийн хэмжээг төгрөгөөр нөхнө.

16-р мөрөнд эзэмшиж/ашиглаж байгаа газрын хаягийг дэлгэрэнгүй нөхнө.

17-р мөрөнд газар ашиглалтын байдлын тохирох кодыг нөхнө.

18-р мөрөнд тухайн газрын байршлаас хамааруулан үнэлгээний зэрэглэл(бүс)-ийн дугаарыг тодруулж нөхнө. (Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол).

19-р мөрөнд Газар ашиглалтын зориулалтыг Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолд заасан аль нэг ангилалд хамруулан нөхнө.

20, 21, 22-р мөрөнд хэрэв газар барьцаалах шийдвэртэй бол тухайн шийдвэрийг олгосон байгууллагын нэр, гэрчилгээний дугаар, олгосон огноог нөхнө.

23, 24, 25-р мөрөнд хэрэв тухайн газрыг эзэмших/ашиглах хугацааг сунгасан бол газар эзэмшил/ашиглалтын хугацаа сунгасан шийдвэрийн дугаар, огноо, хугацааг нөхнө. Хугацааг жилээр нөхнө.

26-р мөрөнд тухайн газрын үнэлгээний зэрэглэл, зориулалтад харгалзах **суурь үнэлгээг** Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын холбогдох хавсралтаас авч 1 м.кв газрын үнэлгээг **төгрөгт** шилжүүлсэн дүнгээр нөхнө.

27-р мөрөнд Газрыг өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн үнэлгээг санхүүгийн тайлангийн биет бус хөрөнгийн дансанд бүртгэсэн үнэлгээгээр төгрөгөөр бичнэ

28-р мөрөнд Тухайн газарт байршдаг барилга, байгууламжийн нэрийг бичнэ.

**Тооллогын програм хангамжид газрын талаарх мэдээлийг оруулахдаа дээрх зааврыг анхаарч бүрэн гүйцэд оруулна уу. Програмаас маягыг хөрвүүлэхдээ зөвхөн та бүхний оруулсан болон сонгосон мэдээллийг гаргах болно.*

Лавлах: Маягтын талаарх лавлагааг доорх утсаар авна уу.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Утас: 51-263021, 51-263025, 51-263016

Үндэсний статистикийн хорооны зөвшөөрснөөр
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 7 дугаар сарын 06-ны
өдрийн 323 дугаар тогтоолоор батлав.

ТӨХ-3

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН 2021 ОНЫ БҮРТГЭЛ

1. Хаягийн хэсэг

Нэр		Код
Аймаг, нийслэл		
Сум, дүүрэг		
Хуулийн этгээдийн нэр		
Регистрийн дугаар		
Өмч эзэмшигчийн дугаар		

2. Барилга, байгууламж

№	Барилга, байгууламжийн нэр	Байршил	Зориулалт	Ангиллын код	Байгууллагын хөрөнгийн бүртгэлийн дугаар	Барилга байгууламжийн төрөл /Код: 1-11/	Хүчин чөдал				Барилга байгууламжийн бүтээцийн ангилал	Ашиглал- тад орсон огноо	Ашиглал- тын нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагд- сан элэгдэл	/төгрөгөөр/	
							Үзүүлэлт хэмжээ	Хийцийн ангилал /Код/	Хэмжих нэгж	Биет хэмжээ							
A	Б	В	Г	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	
1																	
2																	
3																	
4																	
5																	
6																	
7																	
8																	
9																	
10																	
	Дүн																

Дарга / захирал

/

..... /
гарын үсэг

Тамга

Ерөнхий нягтлан бодогч

/

..... /
гарын үсэг

20 ... оны ...-р сарын ...-ны өдөр

ТӨХ-3: НӨХӨХ ЗААВАР

Маягтын хаягийн хэсэгт төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаар, аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр, холбогдох кодыг нөхнө. Өмч эзэмшигчийн дугаарт тухайн байгууллагын **Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай** байгуулсан өмч эзэмшлийн гэрээний дугаарыг бичнэ.

Маягтын барилга, байгууламжийн талаарх мэдээллийн хэсэгт тухайн байгууллагын барилга, байгууламж тус бүрийг нэг бүрчлэн бүртгэж, нэр, зориулалт, төрөл, хүчин чадал, ашиглалтад орсон огноо, ашиглах нийт хугацаа, балансын үнэ, хуримтлагдсан нийт элэгдэл, үлдэгдэл өртөг зэрэг мэдээллийг барилга, байгууламжийн хувийн хэргийг үндэслэн нөхнө.

Барилга гэж хүмүүсийн байгалийн гамшиг болон бусад гадаад орчноос тусгаарлах, хамгаалах, суурьшин амьдрах, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, бараа таваар хураах, хадгалах болон бусад зориулалтаар ашиглаж болохуйц бүх төрлийн барилга, байгууламжийг ойлгоно. Барилгын хийцийн ашиглалтын хугацаа нь ялгаатай байдлаар нь дээвэр, их бие, сантехник гэж салган бүртгэж болно.

84	Ховд	1	Жаргалант
84	Ховд	4	Алтай
84	Ховд	7	Булган
84	Ховд	10	Буянт
84	Ховд	13	Дарви
84	Ховд	16	Дөргөн
84	Ховд	19	Дуут
84	Ховд	22	Зэрэг
84	Ховд	25	Манхан
84	Ховд	28	Мөнххайрхан
84	Ховд	31	Мөст

84	Ховд	34	Мянгад
84	Ховд	37	Үенч
84	Ховд	40	Ховд
84	Ховд	43	Цэцэг
84	Ховд	46	Чандмана
84	Ховд	49	Эрдэнэбүрэн
85	Увс	1	Улаангом
85	Увс	4	Баруунтуруун
85	Увс	7	Бөхмөрөн
85	Увс	10	Давст
85	Увс	13	Завхан
85	Увс	16	Зүүнговь
85	Увс	19	Зүүнхангай
85	Увс	22	Малчин
85	Увс	25	Наранбулаг
85	Увс	28	Өлгий
85	Увс	31	Өмнөговь
85	Увс	34	Өндөрхангай
85	Увс	37	Сагил
85	Увс	40	Тариалан
85	Увс	43	Түргэн
85	Увс	46	Тэс
85	Увс	49	Ховд
85	Увс	52	Хяргас
85	Увс	55	Цагаанхайрхан
99	Яам, газар	91	Үндэсний статистикийн хороо
99	Яам, газар	93	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
99	Яам, газар	94	Онцгой байдлын ерөнхий газар
99	Яам, газар	95	Тагнуулын ерөнхий газар
99	Яам, газар	96	Цагдаагийн ерөнхий газар
99	Яам, газар	97	Хууль зүй дотоод хэргийн яам
99	Яам, газар	98	Гадаад хэргийн яам
99	Яам, газар	99	Батлан хамгаалах яам

**ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, ЭЗЭМШИЛ, АШИГЛАЛТ,
ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ЖУРАМ,
ЗААВРЫН ЭМХЭТГЭЛ, ГАРЫН АВЛАГА**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлээгүй, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлээгүй хуулийн этгээдийн удирдлагад зохих журмын дагуу хариуцлага тооцохыг төсвийн ерөнхийлөн захирагч нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т тус тус даалгасугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшлийн газар дээр барилга байгууламжийг зөвшөөрөлгүй бариулсан Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын хэлтэс, Архангай аймгийн Онцгой байдлын хэлтэс, "Биокомбинат" төрийн өмчит үйлдвэрийн газрын удирдлагад зохих журмын дагуу хариуцлага тооцох, дахин энэ төрлийн зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээ авахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай үнэлэгдсэн барилга байгууламжийн үнэлгээ, төсвийн зардал, чанар байдлыг нягтлан үзэж, шаардлагатай тохиолдолд залруулах, зөрчил гаргасан албан тушаалтанд зохих журмын дагуу хариуцлага тооцохыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

4. Үнэлгээнд хамрагдаагүй газар эзэмших, ашиглах эрх, дахин үнэлгээ хийгдээгүй үл хөдлөх хөрөнгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлалын дагуу үнэлж, 2020 оны санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгасугай.

5. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг тухайн хуулийн этгээдэд 2020 онд багтаан олгож дуусгахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

6. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд олгосон газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, төрийн өмчийн бүртгэлд тусгаж байхыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан), Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай.

7. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшилд байгаа барилга байгууламжийн доорх газар эзэмших, ашиглах

эрхийг иргэн, хувийн хэвшлийн хуулийн этгээдийн нэр дээр олгосныг цуцалж, тухайн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр дээр баталгаажуулах, газар эзэмшилтэй холбоотой зөрчлийг арилгах арга хэмжээг 2020 онд багтаан авч хэрэгжүүлэх, цаашид төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлсэн газраас хувийн хэвшлийн хуулийн этгээд, иргэнд эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байх, барилга барих, эхлүүлэх зөвшөөрөл олгохгүй байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

8. Төрийн өмчит хуулийн этгээдэд олгосон газар эзэмших эрхийн зориулалтыг өөрчлөх, төрийн өмчит хуулийн этгээд хооронд хуваах, шилжүүлэн эзэмшүүлэх асуудлыг тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн хамт шийдвэрлэх саналыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлж байхыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгасугай.

9. Ард иргэдийн тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор төрийн өмчийн хөрөнгөөр тохижуулсан нийтийн эзэмшлийн зам, талбай, ногоон байгууламж, инженерийн шугам сүлжээний доорх газрыг холбогдох төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр дээр бүртгэх асуудлыг судлан танилцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар (Ц.Ганхүү)-т тус тус даалгасугай.

10. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сангийн програм хангамжийг боловсруулах, нэгдсэн мэдээллийн сан бий болгох, төрийн бусад мэдээллийн сантай холбох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг эрхлэх
газрын дарга

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэг болон Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолыг үндэслэн Тушаах нь:

1. “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ыг 1-р хавсралтаар, “Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ”-г 2-р хавсралтаар, “Инженерийн байгууламжийн нэгж хүчин чадлын үнэлгээ”-г 3-р хавсралтаар, “Барилга байгууламжийн үнэлгээг нутаг дэвсгэрийн бүсчлэлээр тооцох итгэлцүүр”-ийг 4-р хавсралтаар, “Нийтийн эзэмшлийн байгууламжийн нэгж хүчин чадлын үнэлгээ”-г 5-р хавсралтаар, “Хөрөнгийн үнэлгээнд баримтлах үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийн ашиглалтын норматив хугацаа”-г 6-р хавсралтаар, “Барилга байгууламжийн хийц хэсгийн элементээрх задаргаа”-г 7-р хавсралтаар, “Гадаад улс орон дахь дипломат төлөөлөгчийн газруудын 1 м.кв газрын нэгжийн жишиг үнэ”-ийг 8-р хавсралтаар, “Дахин үнэлгээний хураангуй тайлан”-г 9-р хавсралтаар, “Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нягтлан шалгалтын тайлан”-г 10-р хавсралтаар тус тус баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийх бэлтгэл хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, энэ талаар арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Ч.Чимидсүрэн/-т даалгасугай.



Ч.ХҮРЭЛБААТАР

Сангийн сайдын 2018 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 207 тоот тушаалын
Хавсралт 6

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНД БАРИМТЛАХ ҮЛ ХӨДЛӨХ БА ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН НОРМАТИВ ХУГАЦАА

№	Үндсэн хөрөнгийн төрөл, зүйл	Элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жил	
		Сайн	Дундаж
Нэг. Барилга байгууламж			
1.1. Орон сууцны болон оффисийн зориулалттай барилга			
1	Төмөр бетон суурь, араг бүтээц, цутгамал ханатай, оффисийн болон орон сууцны барилга	90	80
2	Төмөр бетон суурь, араг бүтээц, блокон болон тоосгон ханатай оффисийн болон орон сууцны барилга	70	60
3	Төмөр бетон суурь, төмөр араг бүтээц, шилэн фасадтай барилга	70	65
4	Угсармал хавтгалжин барилга	70	60
5	Бетон суурьтай, тоосго, блокон ханатай, угсармал болон бетон хучилттай барилга	60	50
6	Бетон суурьтай, тоосго, блокон ханатай, модон хучилттай барилга	50	45
7	Холимог бүтэцтэй болон дүнзэн байшин	40	35
8	Төмөр бетон суурьтай, сендвичэн оффисын барилга	35	30
9	Зуслангийн модон байшин, угсармал болон бусад хөнгөвчилсэн хийцийн модон байшин	30	20
1.2. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, олон нийтийн зориулалттай барилга			
10	Төмөр бетон суурь, карказтай, блокон болон тоосгон ханатай үйлдвэрлэл, үйлчилгээ, олон нийтийн барилга	70	60
11	Төмөр бетон суурьтай блокон болон тоосгон өрлөгтэй үйлдвэрлэл, үйлчилгээний барилга	60	55
12	Төмөр бетон суурьтай, төмөр араг бүтээц, сендвичэн ханатай үйлдвэрлэл, үйлчилгээний барилга	50	30
13	Бетон суурьтай, тоосго, блокон ханатай, угсармал болон бетон хучилттай барилга	60	50
14	Бетон суурьтай, тоосго, блокон ханатай, модон хучилттай барилга	50	45
15	Төмөр бетон бууу цутгамал суурьтай тоосго, блокон агуулах, гаражийн зориулалттай барилга	60	50
16	Том хавтгаалжин ханатай үйлдвэрийн барилга	60	50
17	Бетон суурьтай сендвичэн агуулах, гаражийн зориулалттай барилга	40	30
18	Холимог хийцтэй агуулах, гаражийн зориулалттай барилга	45	40
19	Банз, шургааг, наамал модон, шитэн ханатай байшин	40	30
20	Бетон суурьтай, тоосго, чулуу, блокон ханатай худаг, уурын зуухны зориулалттай барилга	55	45
1.3. Нийтийн эзэмшлийн талбайн байгууламж			
21	Сандал, сүүдрэвч, хогийн сав		10
22	Автобус, троллейбусны буудал		10
23	Өнгөт хавтан, чулуун талбай, явган хүний зам		25
24	Явган хайс, хашлага		8
25	Тоглоомын болон биеийн тамирын талбай		10
26	Угсармал, цутгамал төмөр бетон далан, үерийн далан		60
27	Гадна реклам чимэглэл, тэмдэг		5
28	Гадна гэрэлтүүлгийн төхөөрөмж		10

1.4. Улс, орон нутгийн чанартай зам, замын байгууламж			
29	Асфальт бетон хучилттай зам		13
30	Цемент бетон хучилттай зам		25
31	Хөнгөвчилсөн хучилттай зам		8
32	Хайрган зам		10
33	Сайжруулсан хөрсөн зам		4
34	Төмөр бетон гүүр		75
35	Модон гүүр		20
1.5. Бусад байгууламж			
36	Төмөр, төмөр бетон тулгууртай 0,4-20 кВ хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/		30
37	Модон тулгууртай 0,4-20 кВ хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/		15
38	Төмөр, төмөр бетон тулгууртай 35-220, 330 кВ хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/		50
39	Модон тулгууртай 35-220, 330 кВ хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/		30
40	Цахилгаан дамжуулах кабель шугамын байгууламж /ЦДКаШ/		40
41	Цэвэр ус татах, бохир ус зайлуулах байгууламж		20
42	Цахилгаан станц болон уурын зуухны яндан /чулуун, төмөр бетон/		50
43	Цахилгаан станц болон уурын зуухны яндан /төмөр/		25
44	Бетон зуурмагийн узель, бетон цутгалтын силос, нүүрсний бункер		30
45	Үр тариа хадгалах силос		30
46	Зоорь		20
47	Модон араг бүтээцтэй, плёнкон хучилттай, энгийн зориулалттай хүлэмж		8
47	Модон болон төмөр араг бүтээцтэй, плёнкон хучилттай үйлдвэрийн аргаар баригдсан хүлэмж		25
48	Төмөр араг бүтээцтэй, шилэн болон плёнкон хучилттай хүлэмж		30
48	Төмөр бетон суурьтай, төмөр болон цутгамал хашаа		30
49	Хад чулуун хашаа болон гинжин, төмөр хашаа		25
50	Модон хашаа		15
51	Малын хашаа, хороо		15
52	Худаг, ус хангамжийн цооног		20
53	Худаг, ус хангамжийн цооног, цамхаг /төмөр/		20
54	Худаг, ус хангамжийн цооног, цамхаг /тоосго/		40
55	Услалтын систем /байгууламжаар/		25
56	Шатахуун түгээх станцын түгээгүүр, бусад байгууламж		20
57	Газрын тосны хайгуул, олборлолтын талбайд ашигладаг нүүдлийн сууц		5
58	Гэр		15
59	Контейнер /төмөр чингэлэг/		20
Хоёр. Машин, тоног төхөөрөмж		Сайн	Дундаж
2.1. Барилгын материалын үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж			
60	Дугуй болон хонгил зуух, тээрэм, хайлах, цутгах, төмөр эдлэл хийх тоног төхөөрөмж, хатаагуур, түүний тоноглол	15	10
61	Эргэх зуух, металл боловсруулах суурь машин, хайлах, цутгах, тоосгоны шавар боловсруулах болон механизмын засварын үйлдвэрийн технологийн тоног төхөөрөмж, гидро карьер, цахилгаан зуух, керамик эдлэхүүний бүх төрлийн тунгаагч, арматур сунгах, таслах, нугалах болон эрдэс хөвөн эдлэхүүний тоног төхөөрөмж	27	25
62	Бетон эдлэл хэвлэх болон зуурмагийн узелийн бүх төхөөрөмж, бетон зуурагч, карьерын тэжээгүүр, бутлах, ялгах, шигших тоног төхөөрөмж, тоосго, хавтанцар үйлдвэрлэх шахуурга	10	8
63	Доргиурт ширээ	6	4

64	Угааж цэвэрлэх, тослох, цэнэглэх, задалж угсрах зэрэг зориулалтын тоног төхөөрөмж	7	5
2.2. Эрчим хүч, уул уурхайн үйлдвэрийн тоног төхөөрөмж			
65	Дулааны шугам, далд уурхайн төмөр, төмөр бетон бэхэлгээ, уурхайн бусад байгууламж	40	35
66	Бүх төрлийн зуух, турбин, 35 кв хүртэл хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам, дэд өртөө, 5-аас дээш шоо метр багтаамжийн шанагатай экскаватор, илчит тэрэг, цахилгаан зүтгүүр	20	15
67	Минутад 500 хүртэл болон 501-1000 эргэх хурдтай дизель генератор, өрмийн машин, бульдозер, автогрейдер, 32-оос дээш шоо метр багтаамжтай думпкар, төрөл бүрийн бутлагч, шигшүүр, конвейер, төрөл бүрийн насос, нар, салхины цахилгаан үүсгүүр	10	8
68	Авто самосвал, дизель генератор, 32 шоо метр хүртэл багтаамжтай думпкар, эрдэс түүхий эд боловсруулах төхөөрөмжүүд, туузан дамжуулагч	9	7
2.3. Ноос боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж			
69	Хялгас ялгах, самнах, ноос сэмлэх, сэгсрэх, зулхай шивэх, эсгий гутал хийх тоног төхөөрөмж	12	10
70	Зүү, кардаар самнах, ээрэх, эрчлэх, давхарлан ороох, ноос, утас хатаах, эсгий, эсгий гутал агшаах, нягтруулах, эсгий гутал уллах, хэвлэх, ноос нэхэх, дугуй сүлжих, нэхмэл эдлэл хийх тоног төхөөрөмж, нэхмэлийн болон туузлах, хивс нэхэх машин, бохир ноос угаах, хатаах агрегат, босоо шахуургат пресс, ноос зөөвөрлөх хийн төхөөрөмж, чийгшүүлэх тоноглол, ноос боловсруулах үйлдвэрийн бусад туслах машин	10	8
71	Сүлжих машин төхөөрөмж	10	8
72	Ноос баглах зориулалт бүхий хэвтээ шахуургат пресс, даахь ураг машин	10	8
2.4. Арьс, шир боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж			
73	Арьсанд механик боловсруулалт хийх, арьс хатаах төхөөрөмж, арьс будах агрегат	10	8
74	Арьс махлах, хуваах, шахах, хусах, сунгах, индүүдэх төхөөрөмж, арьс шир боловсруулахад хэрэглэгдэх барабан, баркас	10	8
75	Нойтон боловсруулалтын туслах төхөөрөмж	10	8
2.5. Оёдлын үйлдвэрийн тоног төхөөрөмж			
76	Бүх төрлийн оёдлын машин, эсгүүр, нэхий, арьс ширний машин, гутлын ул, эсгий үйлдвэрлэх төхөөрөмж, гутал уллах, хэвлэх машин, гутлын хэвлүүр, цавуу, химийн уусмал найруулах төхөөрөмж	10	8
77	Оёдлын үйлдвэрийн гүйцэтгэн боловсруулах ажлын машин, тоног төхөөрөмж	10	8
78	Дамжлага дундын бусад тоног төхөөрөмж	10	8
2.6. Мод боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж			
79	Хатаалгын камер, тунель, кабин, өнгөлгөөний суурь машин, фанерь хуулганы, шүдэнзний, цаас, картоны үйлдвэрийн машин, мод, гуалин буулгах, ялгах төхөөрөмж, модон хийц боловсруулах суурь машин, зоргодос гаргах машин, хавтангийн үйлдвэрийн тоног төхөөрөмж	10	8
80	Халуун, хүйтэн шахуурган хавчаар, хавтан хийц боловсруулах суурь машин, хавтангийн үйлдвэрийн барабан, хатаагуур, дагалдах төхөөрөмж	9	7
81	Хөрөө рам, дагалдах тоноглол	8	5
82	Мод цагаалж ачих трактор, мод тээврийн автомашин, чиргүүл	8	5
83	Дотоод шаталтат хөдөлгүүрт хөрөө	8	5
2.7. Шил, шаазангийн үйлдвэрийн тоног төхөөрөмж			
84	Түүхий эд шатаах, хатаах зуух, шаазан шатаах зуух	12	10

85	Түүхий эд бутлах, тээрэмдэх, шигших төхөөрөмж, шаазан эдлэлийн масс бэлтгэх машин, шилэн эдлэлд гүйцэтгэн боловсруулалт хийх төхөөрөмж	10	8
86	Шил шарах, уяраах зуух, шилэн эдлэл шахаж хэвлэх автомат	8	7
87	Аяга хэвлэх машин, аяга шатаах шугам, шил хайлуулах зуух, шаазан бүтээгдэхүүн пааландаж угаах шугам	8	6
2.8. Хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмж			
88	Хөргөлт, мал нядалгааны болон саван, жимс, ногооны консерв, талх, нарийн боов, гурил, жигнэмэг, архи, дарс үйлдвэрлэх, өлөн гэдэс боловсруулах тоног төхөөрөмж	10	8
89	Хиам, консерв, гоймон, пүнтүүз, чихэр, сүү, пиво, амтат ус, квас, спирт үйлдвэрлэх, хаягдал, яс боловсруулах машин, тоног төхөөрөмж	10	8
90	Давс боловсруулах, загас олборлох төхөөрөмж	7	5
2.9. Хэвлэлийн үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж			
91	Өндөр хэвлэлийн ротац, том болон дунд форматын хэвлэлийн хавтгай машин, үсэг цутгах, мөрөөр цутгах, цаас нугалах, үдэх болон цуглуулгын машин, цаас хөвж огтлох, хавтас хийх машин	10	8
92	Офсет хэвлэлийн бүх төрлийн машин, тоног төхөөрөмж, мөрөөр өрж цутгах машин, өндөр хэвлэлийн бага форматын хавтгай тигель машин, товхимлын агрегатмашин, цавуун бэхэлгээ хийх, бүх төрлийн огтолгооны машин, блок боловсруулах болон дэвтэрлэгээний иж бүрэн агрегат	10	8
2.10. Хөдөө аж ахуй машин, тоног төхөөрөмж			
93	Зөгийн аж ахуйн тоног төхөөрөмж	14	12
94	Бороожуулагч машин, агрегат, дугуйт болон гинжит трактор, үр тарианы комбайн, тариа цэвэрлэх, хатаах, няцлах, бутлах, шигших, дугаарлах, ачих, буулгах төхөөрөмж, гурил, тэжээлийн үйлдвэрийн бусад тоног төхөөрөмж, усны бүх төрлийн зөөврийн шахуурга, шувуу нядлах, шувууны мах боловсруулах төхөөрөмж	12	10
95	Өөрөө явагч механизм, төрөл бүрийн хөрс сийрүүлэгч, анжис, хөдөө аж ахуйн чиргүүл, дүүжин машин, мал, гахай, ан амьтдын аж ахуйн зориулалттай тоног төхөөрөмж, инкубатор, шувууны суудлын задгай төхөөрөмж, торон хайс, үр тариа холих, жорлох болон цехийн дотоод тээврийн тоног төхөөрөмж	9	7
96	Үр тариа хальслах, өнгөлөх тоног төхөөрөмж	7	5
97	Шувууны байрны салхивчийн төхөөрөмж	6	4
2.11. Зам, гүүрийн болон барилгын машин, тоног төхөөрөмж			
98	Асфальт холигч, 15 шоо метрээс илүү багтаамжтай шанага бүхий скрепер, зам гүүрийн төхөөрөмжөөр тоноглогдсон бусад машин	12	10
99	Аэродром, бетон хучилттай замд зориулсан иж бүрэн машин, 90-ээс дээш морины хүчтэй грейдер, скрепер, хайрга, дайрга тараах, хөрс холих, жижиглэх машин, асфальт дэвсэгч, 5-15 шоо метр багтаамжтай скрепер, өөрөө явагч индүү	10	8
100	Бульдозер	10	8
101	0,5-20, түүнээс дээш шоо метрийн шанагатай экскаватор	10	8
102	Автокран	12	10
103	Цамхагт өргөгч болон хийн дугуйт кран	12	10
104	Чулуу бутлах төхөөрөмж	12	10
105	Замын лабораторийн тоног төхөөрөмж	12	10
106	Суурин болон өөрөө явагч бетон зуурагч	12	10
107	Битумын агуулах	17	15
108	Битум зөөгч болон тараагч машин	12	10
2.12. Геологийн машин, тоног төхөөрөмж			
109	Бүх төрлийн оптик хэрэгсэл, лабораторийн цахилгаан техник, дээж бутлах, боловсруулах техник, жин хэмжүүр	8	5

110	Улирлын ажиллагаатай явуулын өрмийн суурь машин, өрөмдлөгийн тоног төхөөрөмж	8	5
111	Цохилтот болон хийн өрөмдлөгийн суурь машин, соронзон хайгуул, хүндийн хүч, чичирхийлэл, цооногийн судалгааны багаж, цахилгаан хайгуулын болон цацраг хэмжүүрийн багаж	8	5
112	Суурин өрмийн суурь машин	7	5
113	Шатаалгын бүх төрлийн цахилгаан зуух	7	5
2.13. Төмөр замын тээврийн хэрэгсэл			
114	Төмөр замын ул шороо, төмөр бетон замын доогуурхи гарцны хиймэл төхөөрөмж, ачаа зөөж буулгах битүү тавцан	100	70
115	Ачаа зөөж буулгах задгай тавцан		40
116	Зорчигчийн тавцан		70
117	Төмөр замын дээд цогцос		20
118	Салаа төмөр замын дээд цогцос		25
119	Бүх төрлийн вагон, илчит тэрэг, цистерн, зорчигчийн тавцан, вагон угаах тавцан, гүүрэн кран, зам тавигч төхөөрөмжтэй балласжуулагч, моторт тавцан, зам цэвэрлэгч, шалгагч хэлбэлзэл шингээгчийг турших машин, сонгох холбооны зогсоогуур	27	25
120	Илчит тэрэг, Зорчигчийн вагон		25
121	Ачааны болон зорчигчийн вагоны хос дугуй		14
122	Ачааны битүү вагон		38
123	Ачааны тавцант вагон		40
124	Ачааны хагас вагон, Цистерн, ачааны бусад зориулалтын вагон		35
125	Вагон кузов засварлах машин, дрезина, хос дугуйн голын хүзүү зүлгэх, дугуй зорох, вагон засварлах машин, цахилгаан домкрат, дугуйн өнхрөх гадаргууг зорох, зүтгүүрийн дугуй зорох машин, замын хориг хашаа, сонгох холбооны дундаж цэг шилжүүлэх байгууламж, зам хэмжигч	16	14
126	25 тоннын хос дугуйт домкрат, 15 тоннын шингэний домкрат, төмөр замаар явдаг кран, үе угсрах машин	13	11
127	Замаас авагддаг дрезина, өртөөний ажиллагааг хянах телевизийн систем, зөөврийн радио холбоо, автомат хадгаламж	10	7
128	Шуруп эрэгдэгч, замын боолт болон шуруп чангалагч, үе угсрах тавцан, дэр модны цахилгаан чигжүүр, зам төмөр тайрагч, түлхэгч, зүлгэгч механизм, цасны хаалт, радио холбооны төхөөрөмж	10	5
129	Вагоны кузов угаах машин	10	5
130	Вагон пүүлэх хэмжих хэрэгсэл	12	10
131	Тээвэрт хэрэглэгдэж байгаа чингэлэг	12	10
2.14. Холбооны тоног төхөөрөмж			
132	Холбооны бүх төрлийн цамхаг, агаарын баганат болон кабель шугам, түүний суваг, тэдгээрийн бусад байгууламж	30	28
133	Радио, телевиз, телефон, телеграфын нягтруулга, холболт, дамжуулалтын төхөөрөмж, лабораторийн хэмжих хэрэгсэл, шуудангийн цахилгаан тоног төхөөрөмж	9	7
134	Холбооны хэрэглэгчийн энгийн техник хэрэгсэл, зай тэжээлийн байгууламж, суурин аккумулятор, гар станц, бүх төрлийн гагнуурын аппарат	7	5
135	Холбооны шилэн кабель	30	25
2.15. Худалдаа, нийтийн хоолны тоног төхөөрөмж			
136	Бага хүч чадлын болон суурин хөргөлтийн төхөөрөмж	15	13
137	Кассын автомат, хагас автомат аппарат, ачаа өргөх, буулгах, зөөх төхөөрөмж, дулаан, механик, жин хэмжүүрийн болон бусад төхөөрөмж	10	8
138	Ахуйн хэрэглээний хөргөгч, хөлдөөгч	8	6

2.16. Шатахууны тоног төхөөрөмж			
139	Агуулах сав /ган резервуар/	25	20
140	Түгээгүүр, насос, ачих, буулгах төхөөрөмж	10	8
2.17. Нийтийн аж ахуй, үйлчилгээний тоног төхөөрөмж			
141	Халаалтын болон хэрэглээний усны шугам, агаарын шугам, шугамын /өргөлтийн/ насос	25	21
142	Оёдол, угаалга, хими цэвэрлэгээний машин, халаах зуух, зүлэг, хяргах микротрактор	10	8
143	Гүний болон бохирын бүх төрлийн насос, бохирын станцын агааржуулагч	8	6
2.18. Тооцоолон бодох техник, дохиолол хамгааллын хэрэгсэл, кино студийн тоног төхөөрөмж			
144	Тооцоолон бодох техник хэрэгсэл	7	5
145	Дохиолол хамгааллын техник хэрэгсэл	12	10
146	Кино студи, кино театрын тоног төхөөрөмж, тасалгааны агааржуулагч	12	10
147	Мэдээлэл технологийн тоног төхөөрөмж	6	4
148	Хөгжмийн хэрэгсэл, дуу авиа, радио, телевиз	7	5
149	Бие бялдаржуулах болон биеийн тамирын техник хэрэгсэл	10	8
150	Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмжүүд	10	8
151	Ариутгал, халдваргүйтгэлийн тоног төхөөрөмж	12	10
152	Лабораторийн болон мэс засал, сэхээн амьдруулах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж	8	5
153	Хэмжих хэрэгслийн тоног төхөөрөмжүүд	8	5
154	Геологи хайгуул, ашиглалтын талбайд ашигладаг хэмжих, тохируулах багаж хэрэгсэл	8	5
155	Геологийн кадастрын зураг хэвлэх тоног төхөөрөмж	8	5
Гурав. Тавилга эд хогшил			
156	Тавилга эд хогшил	12	10
Дөрөв. Авто болон агаарын тээврийн хэрэгсэл			
157	Ачааны, суудлын автомашин, эмнэлгийн болон тусгай тоноглолтой тээврийн хэрэгсэл	10	8
158	Автобус, троллейбус, чиргүүл	10	8
159	Агаарын тээврийн хэрэгсэл /онгоц, нисдэг тэрэг/	25	22
160	Ачааны болон суудлын усан онгоц /металл/	15	13
161	Чиргүүл, төрөл бүрийн завь	9	7
162	Уулын мод зөөдөг машин механизм	8	5

Сангийн сайдын 2018 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 207 тоот тушаалын
Хавсралт 7

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХИЙЦ ХЭСГИЙН ЭЛЕМЕНТЭЭРХ ЗАДАРГАА
(ИХ ЗАСВАРЫН ЗАРДЛЫГ КАПИТАЛЖУУЛАХ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН БҮРТГЭЛД ТУСГАХАД
БАРИМТЛАХ)**

А. Барилга

№	Барилгын нэр	Үндсэн хийц	Дээвэр	Сан-техник	Цахилгаан
Нэг. Олон нийтийн барилга	Цэцэрлэгийн барилга	79.97	5.67	8.73	5.63
	Сургуулийн барилга	82.70	2.95	5.85	8.50
	Спорт заалны барилга	81.47	9.70	5.10	3.74
	Өрхийн эмнэлэг, хороо, цагдаагийн хэсгийн барилга	84.60	2.75	5.45	7.20
	Захиргаа аж ахуйн барилга	84.18	5.10	5.40	5.33
	Худалдаа үйлчилгээний барилга	84.20	8.10	3.70	4.00
	Эрүүл мэндийн төв	87.95	1.90	4.30	5.85
	Эмнэлэг	87.50	2.00	4.62	5.88
	Ахмадын хөгжлийн төв	85.45	6.35	6.30	5.05
	Хөгжимт жүжгийн театр	94.70	2.30	1.60	1.40
	Банк	86.25	4.90	4.35	4.50
	Усан бассейн	83.90	10.40	2.80	2.90
	Соёлын төв	85.55	5.35	5.00	4.10
	Удирдлагын ордон	86.05	1.10	6.10	6.75
Халуун ус	79.67	7.00	10.20	3.13	
Хоёр. Үйлдвэр	Засварын цех	76.50	7.90	11.30	4.30
	Хөнгөн үйлдвэр	86.80	7.40	2.80	3.00
	Тэжээлийн үйлдвэр	87.80	6.90	3.00	2.30
	Барилгын материалын үйлдвэр	73.70	11.70	5.90	8.70
	Авто машины гараж	91.35	5.85	1.50	1.30
	Агуулах /сендвич/	84.00	12.40	1.80	1.80
	Агуулах /капитал/	80.50	8.50	5.30	5.70
Гурав. Орон сууц	Дотуур байр	88.15	5.00	4.60	2.25
	Нийтийн хоол	85.70	3.30	5.10	5.90
	Орон сууц	82.78	1.92	11.00	4.30

Б. Инженерийн байгууламж

1. Дулааны шугам сүлжээ

№	Үе шатны ажлын нэр	100м-сувагт эзлэх хувь /Ф300мм хүртэлх/					Том хүчин чадалтай	
		2 хос дулааны	3 хос /цэвэр устай/	5 хос /халаалтын/	зөвхөн шугам солих	ил шугам	ил шугам	далд шугам
1	Газрын ажил	4%	5%	6%	0.3%	-	-	3%
2	Сувгийн ажил /тулгуур	35%	48%	44%	4%	40%	40%	30%
3	Шугамын угсралтын ажил	54%	32%	33%	96%	60%	60%	60%
4	Худгийн ажил	7%	11%	17%	-	0%		7%

2. Цэвэр усны шугам сүлжээ

№	Үе шатны ажлын нэр	100 м-т эзлэх хувь			
		Ган /Ф500мм хүртэл/	Ган /Ф600мм дээш/	Полиэтилен /PE/	Ширэм
1	Газрын ажил	34%	10%	22%	33%
2	Шугамын угсралтын ажил	59%	87%	72%	62%
3	Худгийн ажил	8%	3%	6%	5%

3. Бохирын шугам сүлжээ

№	Үе шатны ажлын нэр	100 м-т эзлэх хувь		
		бетон	хуванцар	ширэм
1	Газрын ажил	35%	37%	33%
2	Шугамын угсралтын ажил	37%	45%	62%
3	Худгийн ажил	28%	18%	5%

4. Холбооны барилга байгууламж

№	Үе шатны ажлын нэр	100м-т эзлэх хувь
1	Газрын ажил	29%
2	Сувагчлал байгуулах	24%
3	Кабель	21%
4	Залгаа болон муфт	2%
5	Төгсгөлийн төхөөрөмж	4%
6	Худаг суурилуулах	20%

5. Холбооны цамхаг

№	Үе шатны ажлын нэр	100м-т эзлэх хувь
1	Суурийн ажил	20%
2	Цамхгийг объектод угсрах ажил	53%
3	Бусад ажил	11%
4	Газрын ажил	16%

6. Эрчим хүчний барилга байгууламж

№	Барилга байгууламжийн төрөл	1 ком-д эзлэх хувь	
		Барилга угсралт	Тоног төхөөрөмж
1	РП-17 хаалттай хуваарилах байгууламж /16 ячейк, 1 шинийн гүүр, реле, склада панель	17%	83%
2	10КВ-ийн хуваарилах байгууламж /20 ячейктай/	30%	70%
3	10/0.4кВ-ийн Хаалттай дэд станц	30%	70%

7. Ус, Дулаан дамжуулах төв

№	Үе шатны ажлын нэр	1 ком-д эзлэх хувь
1	Газрын ажил	1.2%
2	Каркасны ажил	20.3%
3	Хана, хамар ханын ажил	8.5%
4	Шалны ажил	1.5%
5	Дээврийн ажил	4.7%
6	Заслын ажил	3.1%
7	Бусад ажил	1.9%
8	Дулаан механик	50.8%
9	Халаалтын ажил	3.3%
10	Салхивчийн ажил	0.2%
11	Ариутгах татуургын ажил	0.6%
12	Усан хангамжийн ажил	1.7%
13	Дотор гэрэлтүүлэгчийн ажил	2.1%

8. Туннелийн барилга

№	Үе шатны ажлын нэр	100м-т эзлэх хувь
1	Газрын ажил	1.5%
2	Төмөр бетон хонгилын ажил	61.3%
3	ОЦ 1-10 гол шугамын ажил	12.3%
4	Дулааны худаг 3ш	2.8%
5	Агаар сорох систем 2ш	1.2%
6	Гадна цэвэр усны шугамын ажил	4.4%
7	Гадна бохир усны шугамын ажил	0.0%
8	ЦТП-ийн хаалтын ажил	5.8%
9	Хүчит төхөөрөмжийн ажил	2.6%
10	Автомат удирдлагын ажил	2.4%
11	Холбоо дохиоллын ажил	5.7%

9. Цэвэрлэх байгууламж

№	Үе шатны ажлын нэр	1 ком-д эзлэх хувь
1	Барилга	26%
2	Хуванцар савны т/б хийц	4%
3	Халаалт салхивч	3%
4	Цэвэр бохир ус	0.5%
5	Гэрэлтүүлэг	6%
6	Элсний талбай	0.5%
7	Лагийн талбай	1%
8	Биоцөөрөм	9%
9	Эрлифт	1%
10	Агааржуулалт	1%
11	Шугам сүлжээ	3%
12	Гадна бохир ус	21%
13	Тоног төхөөрөмж	24%

10. Усан сан

№	Үе шатны ажлын нэр	1 ком-д эзлэх хувь
1	Газрын ажил	5%
2	Усан сангийн угсралтын ажил	40%
3	Технологийн хэсэг	1%
4	Халаалтын байр	16%
5	Манаачийн байр	6%
6	Гадны тохижилтын ажил	1%
7	Хашааны ажил	10.90%
8	Гадна цахилгааны ажил	8.70%
9	Дотор цахилгааны ажил	1.50%
10	Дотор халаалт, салхивчийн ажил	0.90%
11	Дулааны узелийн ажил	8.90%
12	Модон жорлон барих ажил	0.40%

11. Насосны станц

№	Үе шатны ажлын нэр	1 ком-д эзлэх хувь
1	Газрын ажил	0.4%
2	Суурийн ажил	6.6%
3	Хана, хамар ханын ажил	4.1%
4	Хучилтын ажил	4.4%
5	Хаалга, цонхны ажил	1.4%
6	Шалны ажил	4.5%
7	Дээврийн ажил	3.2%
8	Дотор заслын ажил	1.5%
9	Гадна заслын ажил	5.9%
10	Бусад ажил	2.0%
11	Цахилгаан хангамжийн ажил	3.1%
12	Халаалт салхивчийн ажил	2.0%
13	Галын усны насос	23.3%
14	Цэвэр усны насос	36.3%
15	Холбоо дохиоллын ажил	1.4%

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэлд:

1. ХЭЛЭЛЦСЭН нь:

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ болон үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүнгийн тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээнд нийт 12676 нэгж талбарын 45,465.3 га газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх хамрагдаж нийт 3,594.1 тэрбум төгрөгөөр үнэлэгдэн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 3591.2 тэрбум төгрөгөөр бүртгэгдсэн байна. Үүнд: төрийн өмчит хуулийн этгээдийн 3932 нэгж талбарын 34,933.6 га газар хамрагдаж, нийт 2,315.8 тэрбум төгрөг, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 8744 нэгж талбарын 10,531.7 га газар хамрагдаж 1,278.26 тэрбум төгрөгөөр тус тус үнэлэгдсэн байна.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн 6012 хуулийн этгээдийн нийт 79,445 ширхэг барилга байгууламж 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн “барилга, байгууламж”-ийн дансанд 14,617.68 тэрбум төгрөгөөр бүртгэгдсэн. Үүнээс төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа 20,211 ширхэг барилга, байгууламж 7,773.1 тэрбум төгрөгөөр үнэлэгдэн санхүүгийн тайланд туссан байна. Харин орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа 59,234 ширхэг барилга, байгууламжийн дахин үнэлгээний дүн нь 5,120.5 тэрбум төгрөг байна.

Дахин үнэлгээгээр барилга, байгууламжийн дүн нийт 4,640.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс 3,449.0 тэрбум төгрөгийн нэмэгдэл нь төрийн өмчит хуулийн этгээдийнх (төрийн нууцад хамаарах дүнг хассанаар) бол 1,191.99 тэрбум төгрөг нь орон нутгийн өмчит хуулийн этгээдэд ногдож байна.

3. Гадаад улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газруудын эзэмшилд байгаа 214 ширхэг барилга, байгууламж хамрагдаж 69.5 сая ам.доллар буюу 137 тэрбум төгрөгийн үнэлгээтэй байсан бөгөөд дахин үнэлгээнд хамрагдсанаар нийт 133,6 сая ам.доллар буюу 296.0 тэрбум төгрөгөөр санхүүгийн тайланд туссан. Гадаад улс дахь Монгол Улсын 23 дипломат төлөөлөгчийн газрын эзэмшилд байгаа 33 нэгж талбарын 99999.06 м.кв талбай бүхий газар хамрагдаж, нийт 22.5 сая ам.доллар буюу 59.8 тэрбум төгрөгөөр үнэлэгдсэн. Газрын үнэлгээг Гадаад харилцааны сайдын балансад валютын холбогдох ханшаар тооцож, нийт 57.4 тэрбум төгрөгөөр тусгасан байна.

Газрын үнэлгээний дүнг санхүүгийн тайланд тусгахдаа өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн байдлаар шалтгаалан 12 дипломат төлөөлөгчийн газрын газар өмчлөх эрхийн үнэлгээ болох 13,4 сая ам.доллар буюу 33.3 тэрбум төгрөгөөр эргэлтийн бус хөрөнгийн “газар” дансанд, 11 дипломат төлөөлөгчийн газрын газар

эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ болох 9,1 сая ам.доллар буюу 24.0 тэрбум төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийн “биет бус хөрөнгө”-газар эзэмших эрх дансанд бүртгэсэн байна.

4. Үнэлгээгээр гарсан зөрчил: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, зөрчлийг арилгах талаар 2017 оны 12 дугаар сард үнэлгээний бэлтгэл ажлын зөвлөмж гаргаж төрийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагад хүргүүлсэн. Гэвч зарим байгууллага газар эзэмших эрхээ хууль тогтоомжийн дагуу баталгаажуулаагүйн улмаас үнэлгээнд хамрагдах боломжгүй болсон байна. Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлээгүй, эзэмшил газраа үнэлээгүй, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа барилга байгууламж, бусдын газар дээр байрладаг, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшлийн газар дээр төрийн бус хуулийн этгээд, иргэний барилга байгууламжийг зөвшөөрөлгүй барьсан, нийтийн эзэмшлийн зам, талбай, ногоон байгууламж, инженерийн шугам сүлжээний доорх газрыг баталгаажуулаагүй, аргачлалын дагуу үнэлэх боломжтой барилга байгууламжийг үнэлээгүй, үнэлгээг санхүүгийн тайланд тусгаагүй, санхүүгийн тайланд буруу тусгасан зэрэг зөрчлүүд илэрлээ. Мөн дахин үнэлгээний үр дүнд үнэ цэнийн бууралттай үнэлэгдсэн барилга байгууламжууд бүртгэгдсэн байна. Эдгээр зөрчил дутагдлуудыг арилгуулж, дүнг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгах шаардлагатай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүнтэй танилцаад “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг дэмжиж, Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР





ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: nfo@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2020 оны 04 сарын 28-ны өдрийн А-1/727

Зөвлөмж хүргүүлэх тухай

Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн НББОУС-д нийцүүлэн хөрөнгийн орчин, өмчлөл, хийц, бүтээц ашиглалтын байдлыг харгалзан төрөл тус бүрээр үнэ цэнийг тодорхойлж үндсэн хөрөнгөд бүртгэх асуудалд зөрчил, дутагдал илэрч байна.

Сангийн сайдын 2018 оны аргачлал батлах тухай 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын 7 дугаар хавсралтад “Барилга байгууламжийн хийц хэсгийн элементээрх задаргаа” их засварын зардлыг капиталжуулах, элэгдлийг тооцох, санхүүгийн тайланд тусгах зорилгоор батлагдсан.

Иймд танай байгууллага өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгө (барилга, байгууламж)-ийг дээр дурдсаны дагуу төрөл тус бүрээр, хэмжих нэгж, хийц бүтээцээр нь зөв ангилан бүртгэж их засварын зардлыг тухайн хийц хэсэгт нь капиталжуулах, их засварын үр дүнд буулгаж нураасан, ашиглалтаас хассан хийц хэсэг, элементэд ногдох үнээр данснаас хасалт хийх асуудлыг тухай бүр тодорхойлон шийдвэрлүүлж байх шаардлагатай байна.

Сангийн сайдын тушаалын дагуу барилга, байгууламжийн задаргааг Нягтлан бодох бүртгэлд ашиглахгүй байгаагаас дээвэр, сантехникийн зэрэг хэсэгчилсэн их засвар хийсний дараа хуулж буулгасан хуучин хэсгийн үнэлгээ дансанд бүртгэлтэй хэвээр үлдэх, элемент бүрийн ашиглалтын хугацааг өөр өөр байх шаардлагатай үл харгалзан барилгыг бүхэлд нь нэг хугацаанд тогтоож элэгдүүлэх, элементийн задаргааг нягтлан бодох бүртгэлд ашиглах зорилгоор програм хангамжид зохих өөрчлөлтийг хийлгээгүй зэрэг зөрчил дутагдлыг арилгаж, хөрөнгийн бүртгэлийг сайжруулах асуудлыг тодорхой арга хэмжээ авч байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох өөрчлөлтийг хийж, хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Мөн ашиглалтаар тогтоосон хугацаа дууссан боловч ашиглалтын шаардлага хангаж буй үндсэн хөрөнгийн цаашид ашиглах хугацааг сунгах, бодит үнэ цэнийг шинэчлэн тогтоох асуудлыг тухай бүр судлан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” тухай журмын дагуу холбогдох баримтыг бүрдүүлэн ирүүлж, шийдвэрлүүлж байх нь зүйтэй.

ДАРГА



З.МЭНДСАЙХАН



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: nfo@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2020 оны 02 сарын 20-ны өдрийн А-1/272

**Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг
хангах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдаанаар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ, үл хөдлөх эд хөрөнгийн дахин үнэлгээний улсын нэгдсэн дүнг хэлэлцэн 10, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого явуулах тухай асуудлаар 9 дүгээр тогтоолыг тус тус баталсан.

Иймд дээрх тогтоолуудын хэрэгжилтийг хангахын тулд манай байгууллагатай хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг хүсье:

1. Газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлээгүй, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлээгүй орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад зохих журмын дагуу хариуцлага тооцох, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас өгөх аргачлал, зааврын дагуу үнэлгээг дахин хийж, 2020 оны санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулах,

2. Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай үнэлэгдсэн барилга байгууламжийн үнэлгээ, төсвийн зардал, чанар байдлыг нягтлан үзэж, шаардлагатай тохиолдолд залруулах, зөрчил гаргасан албан тушаалтанд зохих журмын дагуу хариуцлага тооцох,

3. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх (баталгаажуулаагүй)-ийг тухайн хуулийн этгээдэд 2020 онд багтаан олгож дуусгах,

4. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшилд байгаа барилга байгууламжийн доорх газар эзэмших, ашиглах эрхийг иргэн, хувийн хэвшлийн хуулийн этгээдийн нэр дээр олгосныг цуцалж, тухайн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр дээр баталгаажуулах, газар эзэмшилтэй холбоотой зөрчлийг арилгах арга хэмжээг 2020 онд багтаан авч хэрэгжүүлэх,

5. Цаашид төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлсэн газраас хувийн хэвшлийн хуулийн этгээд, иргэнд эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байх, барилга барих, эхлүүлэх зөвшөөрөл олгохгүй байх,

6. Ард иргэдийн тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор төрийн өмчийн хөрөнгөөр тохижуулсан нийтийн эзэмшлийн зам, талбай, ногоон байгууламж, инженерийн шугам сүлжээний доорх газрыг холбогдох төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр дээр бүртгэх асуудлыг судлан Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газартай хамтран Засгийн газарт танилцуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх,

7. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг төрийн өмчийн нэгэн адил нэгдсэн маягт, асуулга, аргачлал, заавраар явуулах тул шаардагдах зардлыг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж, бэлтгэл ажлыг ханган ажиллах.

Засгийн газрын 2013 оны 38, 2020 оны 10 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчит хуулийн этгээдэд олгосон газар эзэмших эрхийн зориулалтыг өөрчлөх, төрийн өмчит хуулийн этгээд хооронд хуваах, шилжүүлэн эзэмшүүлэх асуудлыг тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн хамт шийдвэрлэх саналыг тухай бүр боловсруулан, шийдвэрээ хүргүүлж байх болно.

Мөн үнэлгээнд хамрагдаагүй газар эзэмших, ашиглах эрх, дахин үнэлгээ хийгдээгүй үл хөдлөх хөрөнгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлалын дагуу үнэлж, 2020 оны санхүүгийн тайланд тусгах асуудлаар аргачлал, заавар боловсруулан төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажилтай хамтатган зохион байгуулна.

Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлсэн тайлан, биелэлт, явцын талаарх мэдээллийг 2020 оны 6 дугаар сар, 10 дугаар сард тус тус ирүүлэхийг хүсье.

Хувийг: Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар, аймгийн Орон нутгийн өмчийн газарт.

ДАРГА



З.МЭНДСАЙХАН



ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: nfo@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2020 оны 02 сарын 20-ны өдрийн А-1/272

Чиглэл хүргүүлэх, шийдвэр
хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын 4 дэх заалтад үнэлгээнд хамрагдаагүй газар эзэмших, ашиглах эрх, дахин үнэлгээ хийгдээгүй үл хөдлөх хөрөнгийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлалын дагуу үнэлж, 2020 оны санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулахыг Сангийн сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан билээ.

Сангийн сайдын 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 7/4446 дугаар албан бичигт газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээнд Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн "Аргачлал батлах тухай" 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалыг ашиглах чиглэл ирүүлсэн байна.

Иймд Засгийн газрын шийдвэрээр 2018 онд хийгдсэн дахин үнэлгээний ажлын явцад дахин үнэлгээ хийгдээгүй үл хөдлөх хөрөнгө, үнэлгээ хийгдээгүй орхисон газар эзэмших, ашиглах эрх, мөн 2018 оноос 2020 онд шинээр олж авсан газар эзэмших, ашиглах эрхийг дээр дурдсан аргачлалын дагуу нөхөн үнэлж, нягтлан шалгалтын үнэлгээчнээр баталгаажуулан, дүнг 2020 оны санхүүгийн тайланд тусгах нь зүйтэй.

Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг хэрэгжилтийг ханган, биелэлтийг 2020 онд багтаан ирүүлэхийг мэдэгдье.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ



21 АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: nfo@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2020 оны 04 сарын 01-ны өдрийн А-1/510

Чиглэл өгөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байгаа тээврийн хэрэгсэл нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.3 дахь заалтад дурдсан баримт, мэдээллийг бүрдүүлэн холбогдох хуулийн хүрээнд төлбөр, татвар хураамжийг цаг тухайд нь төлсөн байх ёстой.

Иймд тээврийн хэрэгсэлтэй холбоотой материалын бүрдлийг бүрэн хангаж шийдвэр гаргаж байх, шийдвэрийн биелэлтийг хүлээн авахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 8.5, 8.6 дахь заалтын дагуу акталсан, шилжүүлсэн, худалдсан тээврийн хэрэгслийн улсын дугаарыг “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийн хамт ирүүлнэ гэсэн заалтыг шийдвэрт тусгаж байх нь зүйтэй байна.

Үндсэн хөрөнгөөс хасах шийдвэр гарч хэрэгжсэн боловч “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын улсын нэгдсэн мэдээллийн системээс хасалт хийлгээгүй байгаа тээврийн хэрэгслийн төлбөр тооцоог тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч хариуцах бөгөөд ийнхүү гаргасан зөрчил дутагдал нь татвар, төлбөрөөс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй юм.

ДАРГА



З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 715

Улаанбаатар хот

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний маягт, дүгнэх аргачлал батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 5, 69 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчит хуулийн этгээдтэй байгуулах "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний маягт"-ыг 1 дүгээр, "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх аргачлал"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төрийн өмчит хуулийн этгээдтэй "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г байгуулан, жил бүр дүгнэж, дүнг нэгтгэн тайлагнаж байхыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

3. Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г байгуулж, биелэлтийг заасан хугацаанд батлагдсан аргачлалын дагуу бэлтгэн дүгнүүлж ажиллахыг Төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт даалгасугай.

4. Монголбанк, Батлан хамгаалах яам, Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газарт өөрийн бие даасан салбар нэгжийн удирдлагатай "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ" байгуулан дүгнэж, тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт жил бүрийн 3 дугаар улиралд багтаан ирүүлж байхыг зөвшөөрсүгэй.

5. Орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх ажилд энэ тогтоолоор баталсан маягт, аргачлалыг жишиг болгон ашиглахыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт зөвлөсүгэй.

6.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

7.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 10 дугаар 10-ны өдрийн 400 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 28- ны өдрийн
715 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МАЯГТ-Г-01

БАТЛАВ:
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА
..... /...../

“ТӨРИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ”

20..... оны дугаар сарын Дугаар: Улаанбаатар хот
.....-ны өдөр

Энэхүү гэрээг нэг талаас төрийн өөрийн өмчийн өмчлөгч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (цаашид “ТӨБЗГ” гэх), түүнийг төлөөлж тус газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга (албан хаагчийн нэр), нөгөө талаас өмч эзэмшигч хуулийн этгээд..... (цаашид “өмч эзэмшигч” гэх), түүнийг төлөөлж тус байгууллагын дарга /захирал/ (албан хаагчийн нэр) нар (цаашид хамтад нь “талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний зорилго нь төрийн өмчит хуулийн этгээдийн /цаашид “өмч эзэмшигч” гэх/ эзэмшиж байгаа хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн болон өөрийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байдалд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны актын хүрээнд хяналт тавих, өмчийн мэдээллийн сан бүрдүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбогдон үүсэх талуудын харилцааг зохицуулах, эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.2. Гэрээний зүйл: Өмч эзэмшигчийн 20.... оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдсан төгрөгийн дор дурдсан “эргэлтийн бус хөрөнгө” байна.

Д/д	Эргэлтийн бус хөрөнгийн дансны нэр	Хөрөнгийн нэр төрөл (нийт тоо)	Дансны үлдэгдэл, (төгрөгөөр) /20....оны 12 сарын 31
1	Барилга, байгууламж		
2	Тээврийн хэрэгсэл		
3	Машин тоног төхөөрөмж		
4	Компьютер, дагалдах хэрэгсэл		
5	Тавилга, эд хогшил		
6	Бусад үндсэн хөрөнгө		
7	Биет бус хөрөнгө		
8	Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө		
9	...		
	Нийт дүн		

Өмч эзэмшигч байгууллагын Эргэлтийн бус хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээллийг эрх бүхий байгууллагаас баталсан төрийн өмчийн мэдээлэл, бүртгэл, статистикийн холбогдох маягтаар гарган улсын үзлэг, тооллогын дүнд тулгуурлах бөгөөд жил бүрийн хөдөлгөөний энэхүү гэрээг дүгнэхэд бүрдүүлэх баримтаар баталгаажуулна.

1.3. Гэрээний хугацаа: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас энэхүү гэрээг албан ёсоор баталгаажуулсан өдрөөс буюу 20... оны.... сарын-ний өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатай байна.

1.4. Гэрээг дүгнэх: Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээний биелэлтийг хамтран дүгнэж 2 хувь акт үйлдэнэ.

1.5. Гэрээний хугацааг сунгах: Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг анх байгуулсан нөхцөлөөр 1 хүртэл жилийн хугацаагаар сунгана. Гэрээний сунгалтыг энэхүү *гэрээний хавсралт (Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний сунгалт)*-ын дагуу тухай бүр хийж баталгаажуулан гэрээнд хавсаргана.

Хоёр. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах

2.1. Өмч эзэмшигч нь өмч хамгаалах Байнгын зөвлөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу байгуулж, дүгнэлтийг гаргаж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлсэн байна.

2.2. Өмч хамгаалах Байнгын зөвлөл нь эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан, осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах болон үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх талаар санал дүгнэлт гаргаж ажиллан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ.

2.3. Өмч эзэмшигч нь төрийн өмчийн эд хөрөнгийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж, захиргааны актыг мөрдөнө.

2.4. Өмч эзэмшигч нь хөрөнгө худалдан авахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, заавар, аргачлалыг мөрдөж ажиллана.

2.5. Өмч эзэмшигч нь байгууллагын үндсэн хөрөнгө, санхүүгийн тайлан болон түүнд холбогдох бусад мэдээллийг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүрэн оруулж, өөрчлөлтийг тухай бүр тусгаж мэдээллийн санг баяжуулж, шинэчилсэн байна.

2.6. Өмч эзэмшигч нь өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа газрын хэмжээ, зориулалтыг өөрчлөх, газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж санхүүгийн тайланд тусгахдаа саналаа боловсруулан Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (салбар нэгж) болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж холбогдох зөвшөөрөл авсан байна.

2.7. Төрийн өмч хөрөнгийг өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас эвдэж гэмтээсэн, ашиглах боломжгүй болгосон, үрэгдүүлсэн, дутагдуулсан ажилтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулан учирсан хохирлыг нөхөн төлүүлж энэ тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт албан ёсоор мэдэгдэж байна.

Гурав. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрх, үүрэг

3.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь дараах эрх эдэлнэ:

3.1.1. төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтад бүртгэлээр хяналт тавих, хяналт шалгалт хийх;

3.1.2. төрийн өмчийг ашиглах, захиран зарцуулахтай холбоотой иргэн, хуулийн этгээдийн өргөдөл гомдол, хүсэлт мэдээллийг шалгах, шаардлагатай тохиолдолд албан тушаалтан, бусад этгээдээс тайлбар, тодорхойлолт авах;

3.1.3. төрийн өмч хөрөнгийн бүртгэл, эзэмшилт ашиглалттай холбоотой шаардлагатай бичиг баримт, мэдээ судалгаа, тайлан мэдээг өмч эзэмшигчээс гаргуулах;

3.1.4. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр бичиг баримт, мэдээ судалгаа, тайлан мэдээг гаргаж өгөөгүй, хугацаа хожимдуулсан болон буруу, дутуу гаргасан бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

3.1.5. өмч эзэмшигч төрийн өмчид тавих хяналтыг сулруулж, үрэгдүүлсэн, үрэгдүүлэх нөхцөл бүрдүүлсэн тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх эсхүл саналаа эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

3.1.6. хууль тогтоомж, энэхүү гэрээнд заасан бусад эрх.

3.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь дараах үүрэг хүлээнэ:

3.2.1. Өмч эзэмшигчийн санал хүсэлтийн дагуу хууль тогтоомж, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь шаардлагатай баримт материал, мэдээллээр хангах;

3.2.2. төрийн өмч хөрөнгийн харилцаатай холбоотой шийдвэрийг өмч эзэмшигчид хүргүүлэх;

3.2.3. өмч эзэмшигчийн үндсэн хөрөнгөд их засвар, хөрөнгө оруулалт хийх, үндсэн хөрөнгө (хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт) олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, түрээслүүлэх, акталж данснаас хасах талаар ирүүлсэн саналыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж, холбогдох шийдвэр гаргах, хариу өгөх;

3.2.4. Иргэн, хуулийн этгээдээс хувийн хөрөнгө оруулалтаар төрийн өмчийн барилга, байгууламж, хөрөнгийн хийц, хэсэг, төлөвлөлтөд өөрчлөлт оруулах, их засвар өргөтгөл, шинэчлэл хийх санал, хүсэлт гаргасан тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас заавал зөвшөөрөл авна. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зөвшөөрөл олгохоос өмнө хэрэгцээ, шаардлага, зориулалт, хэмжээ, онцлогийг харгалзан, тооцоо, зураг төсөв, хийх ажлын нэр төрөл, жагсаалтыг гаргаж үнэ, өртөг, түүний төлбөрийг тооцох асуудлыг хянан судалж, дүгнэлт гарган газрын Хуралдаанаар хэлэлцүүлнэ. Хөрөнгө оруулалт, их засвар хийх зөвшөөрөл олгосон нь тухайн хөрөнгөд хувь эзэмших давуу эрхийг үүсгэхгүй.

3.2.5. өмч хөрөнгийн харилцааны талаарх тогтоол шийдвэрийн хэрэгжилт, биелэлт, дуудлагын худалдаа зохион байгуулсан байдалд нь хяналт тавих;

3.2.6. төрийн өөрийн өмчийг хөлслүүлэх, түрээслүүлэхэд холбогдох журмын дагуу хяналт тавьж, түрээсийн гэрээг хянан баталгаажуулах, түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх;

3.2.7. өмч эзэмшигчийг татан буулгах, өөрчлөн зохион байгуулахад өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх;

3.2.8. хууль тогтоомж, энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүрэг.

Дөрөв. Өмч эзэмшигчийн эрх, үүрэг

4.1. Өмч эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

4.1.1. өөрийн эзэмшиж байгаа хөрөнгийг үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;

4.1.2. өөрт шаардлагатай хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олж авах;

4.1.3. илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу түрээслүүлэх;

4.1.4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

4.1.5.үндсэн хөрөнгийн үнэлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийлгэх;

4.1.6.хууль тогтоомж, энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүрэг.

4.2.Өмч эзэмшигч нь дараах үүрэг хүлээнэ:

4.2.1.өөрийн болон улсын төсвийн хөрөнгийг Төсвийн тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад журам, эрх зүйн акт, шийдвэрт заасны дагуу зарцуулж, тайлагнах;

4.2.2.үндсэн хөрөнгөд их засвар, хөрөнгө оруулалт хийх, үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, түрээслүүлэх, акталж данснаас хасах саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж зөвшөөрөл авах;

4.2.3.төрийн өмчит компани, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь үндсэн хөрөнгөд их засвар, хөрөнгө оруулалт хийх, үндсэн хөрөнгө олж авах саналыг тусгасан хуулийн этгээдээс дагаж мөрдөх жил бүрийн төлөвлөлт (зорилтот түвшин)-ийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж зөвшөөрөл авах;

4.2.4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийн биелэлт, мэдээ тайланг тогтоосон хугацаанд тайлагнах;

4.2.5.эд хөрөнгийн дотоодын тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан журам, хугацааны дагуу явуулах, түүний үнэн зөвийг болон эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын өмнө бүрэн хариуцах;

4.2.6.санхүүгийн анхан шатны бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, олон улсын стандартын дагуу хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах;

4.2.7.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шаардсан төрийн өмч хөрөнгийн бүртгэл, эзэмшилт ашиглалттай холбоотой бичиг баримт, мэдээ судалгаа, тайланг гаргаж өгөх, хөрөнгийн бүртгэлийн анхан шатны маягыг аргачлалын дагуу хөтөлж заасан хугацаанд ирүүлэх;

4.2.8.түрээсийн орлогын 40 /дөчин/ хувийг улсын төсөвт төвлөрүүлэх;

4.2.9.төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага нь төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд хөрөнгийн хөдлөл өөрчлөлт болон хавсралт, мэдээллийг тусгаж баяжуулах талаар зохих арга хэмжээ авах, системд нэвтрэх байгууллагын эрх бүхий этгээд өөрчлөгдсөн тохиолдолд мэдээллийн санг тухай бүр актаар хүлээлцэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт мэдэгдэх.

4.2.10.хууль тогтоомж, энэхүү гэрээнд заасан бусад үүрэг.

Тав. Талуудын хүлээх хариуцлага

5.1.Талууд нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн, зохих ёсоор биелүүлээгүйгээс нөгөө талд учирсан хохирлыг бүрэн хариуцна.

5.2.Талууд нь гэрээний үүргийн биелэлтийг нөгөө талаас шаардах эрхтэй.

5.3.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу буруутай этгээд нь хариуцлага хүлээнэ.

5.4.Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч өөрчлөгдсөн нь хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Зургаа. Бусад

6.1.Гэрээнд талууд гарын үсэг зурж тамга, тэмдэг дарснаар гэрээ хүчин төгөлдөр болж, гэрээний хугацаа дууссанаар дуусгавар болно.

6.2.Гэрээ нь хавсралт, холбогдох бичиг баримтын хамт нийт
(.....) хуудас бөгөөд Монгол хэл дээр 2 (хоёр) хувь үйлдэж, тал тус бүр 1
(нэг) хувийг хадгална. Гэрээний эх хувь нь хууль зүйн адил хүчинтэй байна.

6.3.Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

6.4.Өмч эзэмшигчийг хувьчилсан, татан буулгасан, өөрчлөн зохион байгуулсан тохиолдолд гэрээг цуцлагдсанд тооцох бөгөөд үндсэн хөрөнгийн тооллого явуулж холбогдох арга хэмжээ авна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Төрийн өмчийн өмчлөгчийг төлөөлж:

Өмч эзэмшигчийг төлөөлж:

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын
хэлтсийн дарга

Хуулийн этгээдийн дарга
(захирал)

.....
/овог нэр/

.....
/овог нэр/

.....
/гарын үсэг/

.....
/гарын үсэг/

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын
хэлтсийн (ахлах) мэргэжилтэн

Байгууллагын ерөнхий нягтлан
бодогч (нягтлан бодогч)

.....
/овог нэр/

.....
/овог нэр/

.....
/гарын үсэг/

.....
/гарын үсэг/

Хаяг:

Хаяг:

Утас:

Утас:

Мэйл хаяг:

Мэйл хаяг:

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний маягтын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ

20..... оны дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

Төрийн өөрийн өмчийн өмчлөгч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, түүнийг төлөөлж тус газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга (албан хаагчийн нэр), нөгөө талаас өмч эзэмшигч хуулийн этгээд , түүнийг төлөөлж тус байгууллагын дарга /захирал/ (албан хаагчийн нэр) нарын хооронд 20..... оны дугаар сарын ...-ны өдөр байгуулсан **№**..... дугаар бүхий төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөлөөр, гэрээ дууссан өдрөөс 1 (нэг) жилээр сунгав.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Төрийн өмчийн өмчлөгчийг төлөөлж: Өмч эзэмшигчийг төлөөлж:

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын
хэлтсийн дарга

Хуулийн этгээдийн дарга
(захирал)

.....
/овог нэр/

.....
/овог нэр/

.....
/гарын үсэг/

.....
/гарын үсэг/

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын
хэлтсийн (ахлах) мэргэжилтэн

Хуулийн этгээдийн ерөнхий нягтлан
бодогч (нягтлан бодогч)

.....
/овог нэр/

.....
/овог нэр/

.....
/гарын үсэг/

.....
/гарын үсэг/

Хаяг:

Хаяг:

Утас:

Утас:

Мэйл хаяг:

Мэйл хаяг:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
715 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭГ ДҮГНЭХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хянах зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдтэй байгуулсан Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэнэ.

1.2. “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г цахимаар болон цаасан хэлбэрээр дүгнэж болно.

Хоёр. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ дүгнэх

3.1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг жил бүр дүгнэнэ.

3.2.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга, мэргэжилтэн нар дүгнэнэ. Шаардлагатай тохиолдолд Ажлын хэсгийг томилно.

3.3.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэхэд дараах үндсэн шалгуур үзүүлэлтээр тооцно.

Д/д	Үндсэн шалгуур үзүүлэлт	Авбал зохих дээд оноо	
		Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй
1	Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал	30	25
2	Хөрөнгийн хөдөлгөөн, бүртгэл, мэдээ тайлан, шийдвэрийн хэрэгжилт, тайлагналтын байдал	40	40
3	Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн системийн байдал	10	10
4	Газар эзэмших, ашиглах эрхийн байдал	10	0
5	Гэрээний харилцааг зохицуулах журмын хэрэгжилт, бэлтгэл хангасан байдал	10	10
НИЙТ ОНОО		тоогоор	100
		хувиар	100%
		85	100%

3.4. Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга, мэргэжилтэн нар “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ дүгнэх шалгуур үзүүлэлт”-д заасан түлхүүр

үзүүлэлт тус бүрээр тухайн жилд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны онцлог, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан дүгнэж, дүнг нэгтгэн тооцно.

3.4.1 Гэрээний үндсэн шалгуур үзүүлэлтийн 2 буюу “Хөрөнгийн хөдөлгөөн, бүртгэл, мэдээ тайлан, шийдвэрийн хэрэгжилт, тайлагналтын байдал”-ыг дүгнэхэд эд хөрөнгийг холбогдох хууль, тогтоомж, журамд заасны дагуу зөвшөөрөл аваагүй данснаас хассан, бэлтгэсэн тохиолдолд оноог шууд хасаж дүгнэнэ.

3.5.Шалгуур үзүүлэлтийн нийт дүнгээс 96-100 хувь авсан бол “Сайн”, 76-95 хувь авсан бол “Хангалттай”, 75 болон түүнээс доош хувийн оноо авсан бол “Хангалтгүй” гэж тус тус үнэлэх бөгөөд энэхүү аргачлалаар баталсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний ... оны биелэлтийн дүнг баталгаажуулах хуудас”-аар 2 тал гарын үсэг зурж, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга хянаж, дүнг баталгаажуулна.

Үнэлгээ	Онооны интервал (%)
“Сайн”	96-100 хувь
“Хангалттай”	76-95 хувь
“Хангалтгүй”	75 болон түүнээс доош хувь

3.6.“Сайн” үнэлгээтэй дүгнэгдсэн хуулийн этгээдээс энэхүү журмын хэрэгжилтийг бүрэн хангаж, төрийн өмчийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж үр дүнтэй ажилласан төрийн өмчит хуулийн этгээд (ажилтан)-ийг шагнаж урамшуулж, “Хангалтгүй” үнэлгээтэй дүгнэгдсэн төрийн өмчит хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

3.7.Төрийн өмчит хуулийн этгээд нь тухайн жилийн төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэхэд дор дурдсан мэдээллийг бүрдүүлсэн байна. Үүнд:

3.7.1.төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий мэдээлэл, үндсэн хөрөнгө, түүний хавсралт мэдээлэл, санхүүгийн тайлан, хөрөнгийн хөдөлгөөн болон бусад мэдээллийг бүрэн тусгаж баталгаажуулсан байх;

3.7.2.үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тухайн жилийн дэлгэрэнгүй тайлан (Маягт 11, ТӨ-2) холбогдох шийдвэрийн хамт ;

3.7.3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон бусад эрх бүхий байгууллагын үндсэн хөрөнгийн зохицуулалттай холбоотой тогтоол, шийдвэр түүний хэрэгжилт, биелэлтийг тайлагнасан албан бичиг, дуудлагын худалдаа зохион байгуулсан баримт;

3.7.4.төрийн өмчит хуулийн этгээдийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан;

3.7.5.төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн дотоодын тооллогын тайлан, маргаантай, дутагдсан, илүүдэлтэй хөрөнгийн мэдээ;

3.7.6.төрийн өмчийн захиргааны статистик (жил бүрийн 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор) мэдээ болон бусад судалгаа, мэдээ тайлан;

3.7.7.нэмэгдсэн газар эзэмших (ашиглах) эрхийн гэрээ, гэрчилгээ, кадастрын зураг, тээврийн хэрэгсэл, барилгын хувийн хэрэг болон хөрөнгийн үнэлгээ, түүнийг бүртгэлд тусгасан тухай холбогдох шийдвэрийн баримт;

3.7.8.гэрээний дүнгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгасан тухай тайлбар, жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан (үндсэн хөрөнгийн тодруулга, аудитын тайлан, зөвлөмжийн хамт);

3.7.9.түрээсийн гэрээ, түүний хавсралт, сунгалт, түрээсийн орлогын 40 /дөчин/ хувийг улсын төсөвт төвлөрүүлсэн болон түрээсийн төлбөрийн тооцоо нийлсэн баримт;

3.8.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ дүгнэхдээ төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын байдалтай газар дээр нь танилцаж, шаардлагатай тохиолдолд түүвэрчилсэн тооллого, шалгалт хийж болно.

3.9.Төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ баталгаажуулах дүнгийн хуудас дээр гэрээ байгуулсан 2 тал гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулна.

3.10.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг анх байгуулсан нөхцөлөөр 1 (нэг) жилийн хугацаагаар 2 /хоёр/-оос–илүүгүй удаа сунгана.

Дөрөв. Бусад

4.1.Төрийн өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан нэгж нь төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулж, жилд 1 /нэг/ удаа дүгнэнэ. Гэрээний дүнгийн нэгтгэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэж, гарах шийдвэрийн төслийн саналын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлнэ.

4.2.Гэрээний биелэлтийн дүнгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар өгч болох бөгөөд гарсан шийдвэрийг хуулийн этгээд мөрдөж ажиллана.

4.3.Төрийн өмч эзэмшигч байгууллага нь энэхүү журмыг зөрчсөн, гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, төрийн өмчид тавих хяналтыг сулруулж эд хөрөнгө үрэгдүүлсэн, үрэгдүүлэх нөхцөл бүрдүүлсэн, өмч хөрөнгийг зохих газрын зөвшөөрөлгүй олж авсан, худалдсан, данс бүртгэлээс хассан, хандивласан, барьцаалсан, түрээслүүлсэн зэрэг тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх, байцаагчийн акт тавих (удирдлагыг өөрчлөх) зэрэг арга хэмжээний саналыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

4.4. Шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

-----oO-----

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ дүгнэх аргачлалын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Д/д	Үндсэн шалгуур үзүүлэлт	Түлхүүр үзүүлэлт	Үнэлгээний дээд оноо		
			Үл хөдлөх хөрөнгөтэй	Үл хөдлөх хөрөнгөгүй	
1	Хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдал	1.1	хөрөнгийн дотоодын тооллогыг хуулийн дагуу зохион байгуулж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тайлагналт (маргаантай, дутагдсан, илүүдэлтэй хөрөнгө/-ын байдал)	5	5
		1.2	өмч хамгаалах Байнгын зөвлөлийн журмын хэрэгжилт, тухайн жилийн ажлын төлөвлөгөө, биелэлт, шинээр санаачилсан болон хийсэн ажлын тайлан, агуулахын эмх цэцгийн байдал	10	10
		1.3	төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, үр ашиг дээшилсэн байдал, барилгын хувийн хэрэг, хөрөнгийн техникийн паспорт хөтлөлтийн байдал	10	10
		1.4	төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын дагуу гэрээ байгуулж түрээсэлсэн, түрээсийн нийт орлогын 30 хувийг улсын төсөвт хугацаанд нь төвлөрүүлсэн, барьцаа хөрөнгө болон улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын тооцоо нийлсэн байдал	5	0
2	Хөрөнгийн хөдөлгөөн, бүртгэл, мэдээ тайлан, шийдвэрийн хэрэгжилт, тайлагналтын байдал	2.1	холбогдох хууль тогтоомж, журам, эрх зүйн актын дагуу хөрөнгө олж авах, бүртгэх, ақталж данснаас хасах, шилжүүлэх, дансны залруулга хийхэд (баримтын бүрдэл хангаж) зөвшөөрөл авч данс бүртгэлд тусгасан болон дуудлагын худагдааг зохион байгуулсан байдал	10	10
		2.2	улсын төсвийн хөрөнгө оруулалт, батлагдсан эх үүсвэрээр бэлтгэсэн болон хандив, тусламж, бэлэглэл, төслийн шугамаар бий болсон хөдлөх (зөвшөөрөл авах шаардлагагүй) хөрөнгийг тухай бүрд, байгууллагын нийтийн эзэмшлийн хөрөнгийг иж бүрэн данс бүртгэлд тус тус тусгасан байдал	5	5
		2.3	эд хөрөнгийн зохицуулалттай холбоотой тогтоол, шийдвэр, аудитын зөвлөмжийн хэрэгжилт, биелэлт (заасан хугацаанд хүргүүлсэн байдал) тайлагналтын байдал	10	10
		2.4	үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, стандарт, бодлогын бичиг баримтын дагуу хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгасан, хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдэл тооцсон, үнэлсэн, хөрөнгийг монгол хэлээр зөв оновчтой нэршлээр бүртгэсэн зэрэг данс бүртгэл хөтлөлт болон холбогдох хууль, эрх зүйн актыг дагаж мөрдөж тайлагнадаг байдал	10	10
		2.5	тухайн жилд төрийн өмчийн эд хөрөнгийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, судалгаа, мэдээ тайлан гаргах ажлыг зохион байгуулсан, цаг хугацаанд нь тайлагнасан байдал	5	5
3	Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн системийн байдал	3.1	"Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгө болон бүртгэл, статистикийн бусад мэдээлэл, тэдгээрийн хөдлөл өөрчлөлт, холбогдох хавсралт баримтыг иж бүрэн тусгаж, баталгаажуулсан, системд нэвтрэх эрх бүхий этгээд өөрчлөгдөхөд актаар хүлээлцсэн байдал	10	10
		4.1	Газар эзэмших, ашиглах эрхийн баталгаажуулалт, бичиг баримтын бүрдэл, үнэлсэн, данс бүртгэлд тусгасан байдал	5	0
4	Газар эзэмших, ашиглах эрхийн байдал	4.2	Газар эзэмших эрхийн хөдлөл өөрчлөлт (газрын хэмжээ, зориулалтад өөрчлөлт оруулахад зөвшөөрөл авсан эсэх) бүрэн бүтэн байдал, ашиглалт, зөрчил, маргаан шийдвэрлэлтийн байдал	5	0
5	Гэрээний харилцааг зохицуулах журмын хэрэгжилт, бэлтгэл хангасан байдал	5.1	Гэрээний биелэлт, гэрээг хавтаст: гэрээ, хавсралтын хамт, гэрээний сунгалтын хуудас, биелэлтийн дүн баталгаажуулах хуудас, ӨХБЗ-ийн ажлын тайлан, бусад)-ний бүрдэл, гэрээ дүгнүүлсэн, бэлтгэл хангасан байдал	10	10
			НИЙТ ОНОО	100	85
			100%	100%	100%

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ дүгнэх аргачлалын хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ 20.. ОНЫ
БИЕЛЭЛТИЙН ДҮНГ БАТАЛГААЖУУЛАХ ХУУДАС**

Байршил: Аймаг, нийслэлийн нэр: Улаанбаатар

Төрийн өмчит хуулийн этгээдийн нэр:

ДҮН:

20.... оны.....дугаар сарын.....ны өдөр

Үнэлгээ	Онооны интервал (хувиар)	Авсан оноо					Гэрээний биелэлт (хувиар)		
		үндсэн шалгуур таван үзүүлэлт бүрээр (үл хөдлөхтэй/хөдлөхгүй)					нийт	дүн	баталгаажуулсан үнэлгээ
		1	2	3	4	5			
Авбал зохих оноо:		30/25	40/40	10/10	10/0	10/10	100/85	100%	
Сайн	91-100 %								
Хангалттай	76-90 %								
Хангалтгүй	75% ба түүнээс доош								

ХЯНАСАН:

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга

..... /..... /овог нэр/
/гарын үсэг/ тамга

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

Хуулийн этгээдийн дарга (захирал)

..... /..... /овог нэр/
/гарын үсэг/ тамга

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн /ахлах/ Хуулийн этгээдийн /ерөнхий/ нягтлан бодогч мэргэжилтэн

..... /..... /овог нэр/
/гарын үсэг/

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 268

Улаанбаатар хот

Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дуудлагын худалдаагаар худалдах хөдлөх үндсэн хөрөнгийн худалдахаар санал болгох доод үнэ 10,000,000.00 (арван сая) хүртэл төгрөг бол дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 25 хувиар, 10,000,001.00 (арван сая нэг) төгрөгөөс 100,000,000.0 (нэг зуун сая) хүртэл төгрөг бол дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 20 хувиар, 100,000,001.0 (нэг зуун сая нэг) төгрөгөөс 1,000,000,000.00 (нэг тэрбум) хүртэл төгрөг бол дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 15 хувиар, 1,000,000,001.00 (нэг тэрбум нэг) төгрөг болон түүнээс дээш бол дэнчингийн хэмжээг худалдах доод үнийн 10 хувиар тус тус тогтоосугай.

2. Дуудлагын худалдаагаар худалдах төрийн өмчийн хөдлөх үндсэн хөрөнгийн худалдахаар санал болгох доод үнэ 1,000,000.00 (нэг сая) хүртэл төгрөг бол үнэ хаялцах доод хязгаар 50,000.00 (тавин мянган) төгрөгөөр, 1,000,001.00 (нэг сая нэг) төгрөгөөс 10,000,000.0 (арван сая) хүртэл төгрөг бол үнэ хаялцах доод хязгаар 100,000.00 (нэг зуун мянган) төгрөг, 10,000,001.0 (арван сая нэг) төгрөгөөс дээш бол үнэ хаялцах доод хязгаар 200,000.00, (хоёр зуун мянган) төгрөгөөр, дээд хязгаарыг худалдах доод үнэтэй уялдуулан дэнчингийн хэмжээ хүртэл байхаар тус тус тогтоосугай.

3. Төсөвт байгууллагын дансанд бүртгэлтэй, төрийн өмчийн хөдлөх үндсэн хөрөнгийн дуудлагын худалдаанаас олсон орлогоос тухайн дуудлагын худалдааг зохион байгуулахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр улсын төсөвт төвлөрүүлэхээр тогтсугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа) -т үүрэг болгосугай:

4.1. Төрийн өмчийн үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах шийдвэр гаргахаас өмнө тухайн хөрөнгийн эрхийн болон эзэмшил, ашиглалт, төлбөр тооцооны зөрчлийг арилгасан байх;

4.2. Төрийн өмчийн хөдлөх үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах асуудлын материалыг төрийн өмчит хуулийн этгээдээс тухайн жилийн 1 дүгээр улиралд багтаан хүлээн авч, судлан боловсруулж, худалдахаар санал болгох доод үнийг тухайн төрийн өмчит хуулийн этгээдийн санал, дүгнэлтэд тулгуурлан тогтоох саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж байх;

4.3. Худалдахаар шийдвэрлэсэн хөдлөх үндсэн хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг (төрийн өмчийн төлөөлөгч,

дуудлагын худалдааны хөтлөгч, тэмдэглэл хөтлөгчийн бүрэлдэхүүнтэй)-ийг байгуулах, удирдамжаар хангах, дуудлагын худалдааг холбогдох хууль тогтоомж, энэхүү тогтоолд нийцүүлэн зохион байгуулах, хяналт тавих, орлогыг холбогдох дансанд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах;

4.4. Төрийн өмчийн хөдлөх үндсэн хөрөнгийн дуудлагын худалдаагаар санал болгосон үнэд хүрэх санал гараагүй буюу дуудлага худалдаанд хэн ч оролцоогүй бол хоёр дахь дуудлага худалдааг эхний дуудлага худалдаа явуулснаас хойш 30 хоногийн дотор тогтоосон доод үнийг өөрчлөлгүйгээр дахин зарлан явуулах, мөн зарагдаагүй тохиолдолд худалдах доод үнийг шинэчлэн тогтоож гурав дахь дуудлагын худалдааг зарлах, эсхүл өмч эзэмшигч хуулийн этгээдийн акталж данснаас хасах саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

4.5. Төрийн өмчит компани болон аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын хөдлөх үндсэн хөрөнгийн дуудлагын худалдааны орлогыг шинээр эд хөрөнгө худалдан авах, сэргээн засварлах, шинэчлэх зорилгоор тухайн байгууллагын дансанд төвлөрүүлэх эсэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

4.6. Төрийн өмчит хуулийн этгээдийн зохион байгуулсан дуудлагын худалдааны үр дүнгээр худалдах, худалдан авах гэрээ байгуулах, гэрээний үүргийн биелэлт болон дуудлагын худалдааны орлогыг тухай бүр, бүрэн хэмжээгээр улсын төсөвт төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллах, төрийн өмчийн өмчлөх эрхийг шилжүүлэх асуудлаар лавлагаа өгөх.

5. Энэ тогтоолыг төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т тус тус үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 128 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 269

Улаанбаатар хот

Мэдээ, тайлангийн маягт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 29 дүгээр зүйлийн 1, 69 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн “Нээлттэй дуудлагын худалдааны зар мэдээ”-г 1 дүгээр, “Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтийн маягт”-ыг 2 дугаар, “Дуудлагын худалдааны тэмдэглэл”-ийн тайланг 3 дугаар, ялагчтай байгуулсан “Худалдах, худалдан авах гэрээ”-ний маягтыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлага худалдааны талаар гарсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийн биелэлтийг заасан хугацаанд тайлагнахдаа энэ тогтоолын 1,2,3 дугаар хавсралтаар тус тус баталсан мэдээ, тайлангийн маягт болон хөрөнгийн үнийг улсын төсөвт төвлөрүүлснийг нотлох баримтын эх хувийг дуудлагын худалдаа явуулсан тухай бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж байхыг Төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт даалгасугай.

3. Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны ялагчтай байгуулах худалдах, худалдан авах гэрээг энэ тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан маягтаар байгуулахыг (төрийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт) зөвлөсүгэй.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн
269 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ЗАР МЭДЭЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 20... оны дүгээр тогтоолын дагуу (худалдах хөрөнгийн нэр) хөрөнгийг нээлттэй/хаалттай дуудлага худалдаагаар худалдана.

1. Дуудлагын худалдааны ерөнхий мэдээлэл

Дуудлагын худалдааны хэлбэр	нээлттэй/хаалттай
Гэрээний зүйл	Худалдах хөрөнгийн гарал үүсэл, ашигласан хугацаа, марк, техникийн үзүүлэлт, улсын бүртгэлийн дугаар, төлөв байдал, товч танилцуулга
Дуудлагын худалдаа болох хугацаа	20.. оныдугаар сарын ... -ны өдрийн цагг
Дуудлагын худалдаа болох газар	
Худалдах доод үнэ	Дуудлагаар худалдах хөрөнгийн нэр, худалдах доод үнэ (тоогоор)..... (үсгээр) төгрөг
Дуудлагын худалдаанд тавих дэнчингийн хэмжээ	Худалдах доод үнийн.....хувь буюу..... (тоогоор)(үсгээр) төгрөг
Ялсан этгээдийг тогтоох журам	Үнэ хаялцан ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд байна
Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл	Гэрээг ажлын 3 хоногийн дотор байгуулна. Худалдан авагч нь дуудлага худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор төлнө.
Дэнчинг байршуулах данс	Хүлээн авагч хуулийн этгээд:..... дансны дугаар:..... дансны нэр:.....

2. Дуудлагын худалдаанд хүсэлт ирүүлэх, оролцогчийг бүртгэх

Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтийн маягтыг зөв, цэвэр бөглөж, дэнчин төлснийг нотлох баримт, иргэний үнэмлэх (хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээ)-ний хуулбарын хамт 20... оны дугаар сарын ... -ны өдрийн цаг хүртэл хуулийн этгээдийн (хаягийг тодорхой тусгана) байрны өрөөнд хүлээн авна. Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авч бүртгэх, үнэ хаялцуулах ажиллагаанд оролцуулах боломжгүйг анхаарна уу.

3. Худалдах хөрөнгийн талаар мэдээлэл авах

Дуудлагаар худалдах хөрөнгийг өмч эзэмшигчхуулийн этгээдийн..... хаягаар очиж үзэж болох бөгөөд хөрөнгийн талаарх мэдээллийг утсаар авна уу.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн
269 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ДУУДЛАГЫН ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

1. Дуудлагын худалдаагаар худалдах эд хөрөнгийн эзэмшигч
.....(хуулийн этгээдийн нэр)
.....
.....(хөрөнгийн нэр):
2. Оролцогчийн эцгийн нэр, нэр:
3. Оролцогчийн регистрийн дугаар:
4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эцгийн нэр, нэр:
5. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн регистрийн дугаар:
6. Дэнчингийн хэмжээ:(тоогоор),
..... (үсгээр)
7. Дэнчинг тушаасан: 20.... оны сар.....өдөр, цаг
8. Оролцогчийн оршин суугаа хаяг:
9. Харилцах утас:
10. Бөглөсөн: 20.... оны сар.....өдөр, цаг
11. Дуудлагын худалдааны нөхцөл болон
.....
(эд хөрөнгийн нэр) эд хөрөнгөтэй танилцсан: Гарын үсэг:

*Дуудлагын худалдаанд оролцох бүрт энэ хүснэгтийг бөглөж, дэнчинг төлсөн баримтын 1 хувь, оролцогчийн иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргаж, дугтуйлж бүртгүүлнэ.

*Хүсэлтэд бичигдсэн мэдээллийн үнэн зөв байдлыг оролцогч бүрэн хариуцах ба алдаатай, буруу бөглөсөн бол дуудлагын худалдаанд оролцох боломжгүйг анхаарна уу.

-----oOo-----

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн
269 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

20.... оны.....сарын -ны өдөр

1. Өмч эзэмшигч байгууллагын нэр:

.....

2. Дуудлагын худалдаагаар худалдах эд хөрөнгийн нэр, марк, дугаар, тоо хэмжээ:

.....
.....
.....

3. Дуудлагын худалдааны зар гаргасан сонины нэр, дугаар, он, сар, өдөр:

.....№, 20.... оны сар өдөр

4. Дуудлагын худалдаа явагдсан газар, он, сар, өдөр, цаг минут:

20.... оны сар өдөр,цаг... мин

5. Дуудлагын худалдааны доод үнэ: (тоогоор),

..... (үсгээр) төгрөг

6. Дэнчингийн хэмжээ: (тоогоор)

..... (үсгээр) төгрөг

*Тусгай тэмдэглэл^{IV}:

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

7. Дуудлагын худалдаанд оролцогчийн нэр:

Оролцогчийн нэр	Пайзны дугаар	Оролцогчийн нэр	Пайзны дугаар
1.	6.
2.	7.
3.	8.
4.	9.
5.	10.

^{IV} - энэ хэсэгт дуудлага худалдаа эхлэхэд оролцогчдоос асуусан асуулт, түүний хариулт, тодруулга, маргаан гарвал түүний тухай мэдээллийг бичнэ

8. Ажиглагчийн нэр:
1.
 2.
 3.

9. Нэмэлт тэмдэглэл:

*Явцын тусгай тэмдэглэл⁵:

10. Дуудлагын худалдааг зохион байгуулж явуулсан:
1. Төрийн өмчийн төлөөлөгч:

 2. Хөтлөгч:

 3. Тэмдэглэл хөтлөгч:

Хөтлөгч дуудлагын худалдааны журмыг танилцуулж, дуудлагын худалдаа эхэлснийг зарлав. Өсгөн нэмэгдүүлэх үнийн доод хязгаар (.....) төгрөг, дээд хязгаар (.....) төгрөг болохыг танилцуулав.

Дуудлагын худалдаа дараах байдалтай явагдав.

№	Пайзны дугаар	Үнийн санал

№	Пайзны дугаар	Үнийн санал

№	Пайзны дугаар	Үнийн санал

⁵ - энэ хэсэгт дуудлага худалдааны явцад оролцогчдоос асуусан асуулт, түүний хариулт, тодруулга, маргаан гарвал түүний тухай болон явцын үеийн бусад мэдээллийг бичнэ

Дуудлагын худалдааны эцсийн үнэ: (тоогоор)
..... (үсгээр) төгрөг.
Удаах оролцогчийн эцсийн үнийн санал: (тоогоор)
..... (үсгээр) төгрөг

Явцын тусгай тэмдэглэл ⁶:

.....
.....
.....
.....
.....
.....

Дуудлагын худалдааны ялагчийн эцгийн нэр, нэр:

.....

Оршин суугаа хаяг, харилцах утас:

.....

Удаах оролцогчийн эцгийн нэр, нэр:

.....

Оршин суугаа хаяг, харилцах утас:

.....

Дуудлагын худалдааны тэмдэглэлтэй танилцсан:

Төрийн өмчийн төлөөлөгч: / нэр/

Хөтлөгч: / нэр/

Тэмдэглэл хөтлөгч: / нэр/

Дуудлагын худалдаанд оролцогч:

1. / нэр/

2. / нэр/

3. / нэр/

4. / нэр/

5. / нэр/

гарын үсэг

-----oOo-----

⁶ - энэ хэсэгт дуудлага худалдааг явуулж дуусган, ялагч тодорсон тухай болон дуудлага худалдаанд оролцогчдоос болон тэдэнд хандаж гаргасан асуулт, бусад мэдээллийн талаар бичнэ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн
269 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт

“ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ”-НИЙ МАЯГТ

20... оны -р сарын -ны өдөр Дугаар:
(хот, аймаг, сум)

Энэхүү гэрээг нэг талаас
/ТӨБЗГ, эсхүл өмч эзэмшигч хуулийн этгээд/, түүнийг төлөөлж
(цаашид “худалдагч” гэх), нөгөө талаас дуудлага
худалдааны ялагч болсон иргэн /эсхүл хуулийн этгээд/
..... (нэр) (регистр,
улсын бүртгэлийн дугаар) (цаашид “худалдан авагч”, хамтад нь “талууд” гэх) нар дараах
нөхцөлөөр харилцан тохиролцож Иргэний хуулийн 197 дугаар зүйлийн 197.2 дахь хэсэгт
заасан дуудлагын худалдааны журмыг үндэслэн байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гэрээний зорилго: Худалдагч гэрээнд заасан эрхийн зөрчилгүй
..... /эд хөрөнгийн нэр, марк, төрөл/ (цаашид “эд хөрөнгө гэх”
гэх)-ыг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, худалдан авагч нь дуудлагын худалдааны
журам, гэрээнд дурдсан нөхцөлөөр үнийг төлөхтэй холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх
үүрэг, хариуцлагыг зохицуулахад оршино.

1.2. Гэрээний зүйл: Худалдах, худалдан авах эд хөрөнгө нь
хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй улсад онд
үйлдвэрлэсэн
/нийт жил ашигласан/, “..... ” маркийн, өнгөтэй,
.....
.. байна. Энд худалдах үеийн хөрөнгийн бодит байдал, техникийн болон шаардлагатай
үзүүлэлтийг нэмж оруулна. **Шаардлагатай бол гэрээний зүйлийн үзүүлэлтийг тусгаасан
хавсралт үйлдэнэ.*

1.3. Энэ гэрээ нь албан ёсоор байгуулагдсан өдрөөс эхлэн гэрээгээр хүлээсэн үүрэг
бүрэн биелэх хүртэл хугацаанд үйлчилнэ.

Хоёр. Эд хөрөнгийг шилжүүлэх

2.1. Худалдан авагч эд хөрөнгийн
төлбөрийг гэрээнд заасны дагуу бүрэн төлснөөр өмчлөх эрхтэй болно.

2.2. Гэрээний зүйл нь эрхийн зөрчилгүй байна. Эрхийн зөрчилгүй гэдэгт гуравдагч
этгээд өөрийн эдлэх эрхийн талаар ямарваа нэгэн гомдлын шаардлага гаргахгүй байхыг
ойлгоно.

2.3. Худалдагч худалдсан **эд хөрөнгийн холбогдох баримт бичгийг** төлбөр бүрэн
төлөгдөж, гэрээнд заасан холбогдох дансанд орсноос хойш **ажлын 5 өдрийн дотор** эрх
бүхий байгууллагын зөвшөөрлийг авч шилжүүлнэ. **Эд хөрөнгийг эрх шилжүүлэх
зөвшөөрөл гармагц хүлээлгэн өгнө. Хөрөнгө хүлээлцсэн Актыг 2 хувь үйлдэж талууд
тус бүр 1 хувийг авна.**

2.4. Дуудлагаар худалдсан эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлэхтэй холбогдон
гарах үйлчилгээний хураамж болон бусад зардлыг худалдан авагч хариуцна.

2.5. Худалдсан эд хөрөнгийг худалдан авагчид хүлээлгэн өгөхөөс өмнөх хугацааны

татвар, хураамж, даатгалтай холбоотой зардлыг худалдагч бүрэн хариуцна.

Гурав. Төлбөр тооцоо

3.1. Энэхүү гэрээний 1.2-т заасан эд хөрөнгийн нийт үнэ
(тоогоор),.....
.....(үсгээр) төгрөг болно. Энэ нь эцсийн үнэ байна.

3.2. Энэхүү гэрээний 3.1-д заасан үнэ нь дуудлагын худалдаанд оролцож ялсан үнэ болно.

3.3. Эд хөрөнгийн зах зээлийн үнэ, валютын ханш өөрчлөгдөх нь энэхүү гэрээний 3.1-д заасан үнийг өөрчлөх үндэслэл болохгүй.

3.4. Худалдан авагч нь дэнчин болгон нийт (тоогоор),
..... (үсгээр) төгрөгийг
тушаасан бөгөөд дэнчин нь энэхүү гэрээний 3.1-д заасан үнэд тооцогдоно.

3.5. Худалдан авагч нь гэрээ албан ёсоор байгуулагдсанаас хойш 14 хоногийн дотор үлдэгдэл төлбөр болох (тоогоор),
..... (үсгээр)
төгрөгийг худалдагч (хуулийн
этгээдийн нэр)-ийн,(банк, дансны нэр),
..... тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг

4.1. Худалдагчийн эрх, үүрэг:

а) Худалдагч нь худалдан авагчид эрхийн доголдолгүй эд хөрөнгийг гэрээнд заасны дагуу хүлээлгэн өгөх үүрэгтэй.

б) Эд хөрөнгийн үнийг гэрээнд заасан хугацаанд төлөхийг худалдан авагчаас шаардах эрхтэй.

в) Худалдан авагч худалдан авсан эд хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол дэнчинг улсын орлогод авч, гэрээг дангаар цуцлах эрхтэй.

г) Гэрээний үүргээ бүрэн, зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй.

4.2. Худалдан авагчийн эрх, үүрэг:

а) Гэрээнд заасны дагуу эрхийн доголдолгүй эд хөрөнгийг актаар хүлээн авах эрхтэй.

б) Эд хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.

в) Худалдан авсан эд хөрөнгийн үнийг бүрэн төлснөөр эд хөрөнгө, өмчлөх эрхийг шилжүүлэн авах болон холбогдох баримтыг шаардах эрхтэй.

г) Эд хөрөнгийг хүлээлцэхээр тогтоосон хугацаанд хүлээн аваагүй тохиолдолд тухайн эд хөрөнгийг хадгалах, хамгаалах, арчлахтай холбогдон гарах зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

д) Гэрээний үүргээ бүрэн, зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй.

Тав. Талуудын хариуцлага

5.1. Энэ гэрээний нөхцөлийг зөрчсөн буруутай тал түүнээс болж нөгөө талд учирсан бүх хохирол, алдагдлыг үл маргалдах журмаар төлнө.

5.2. Худалдан авагч эд хөрөнгийн үнийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол худалдаж авах эрхээ алдана.

5.3. Худалдан авагч эд хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол дэнчинг нэхэмжлэх эрхээ алдах ба энэхүү гэрээг худалдагчийн санаачилгаар цуцлах үндэслэл болно.

5.4.Худалдан авагч нь тогтоосон хугацаанд эд хөрөнгийг хүлээн аваагүй тохиолдолд эд хөрөнгө хүлээлцэхээр тогтоосон өдрөөс хойшхи гэмтэл, доголдлыг худалдагч хариуцахгүй болно.

Зургаа. Маргааныг шийдвэрлэх

6.1. Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн маргааныг харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

6.2. Хэрэв харилцан тохиролцох боломжгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

Долоо. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл

7.1.Талууд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн эрсдэлийг бие даан хариуцах бөгөөд үүнтэй холбоотой аливаа асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

7.2.Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл (үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, цэргийн эргэлт, террорист үйлдэл, иргэдийн үймээн, бослого, нийтийн эмх замбараагүй байдал)-ийн улмаас биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөлийг арилах хүртэл хойшлуулж болно.

7.3.Энэхүү гэрээний үүргийн биелэлтэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нөгөө талдаа яаралтай мэдэгдэнэ.

7.4.Шаардлагатай бол төрийн эрх бүхий байгууллагын баримт нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл мөн байсан болон түүний үргэлжилсэн хугацааны нотолгоо болно.

Найм. Бусад нөхцөл

8.1.Энэ гэрээ нь хавсралтын хамт нийт.....(.....) хуудас, үндсэн эхийг монгол хэл дээр 2 хувь үйлдэж, тал тус бүр 1 хувийг хадгална. Гэрээний эх хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

8.2.Талууд энэ гэрээнд дурдаагүй бусад асуудлыг шийдвэрлэхэд холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

.....

/ТӨБЗГ, эсхүл өмч эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж буй этгээдийн нэр/

.....

(Гарын үсэг)

Регистрийн дугаар:

Хаяг:.....

Утас:

Факс:

И-мэйл хаяг:

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

.....

(Иргэн эсхүл хуулийн этгээдийн нэр/

.....

(Гарын үсэг)

Регистрийн дугаар:

Хаяг:.....

Утас:

Факс:

И-мэйл хаяг:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 271

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 5, 8 дахь хэсэг, 25 дугаар зүйл, 69 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Журам батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад үүрэг болгосугай:

2.1. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнээ нөхсөн, сэргээн засварлаж цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон тавилга эд хогшил, компьютер, түүний дагалдах хэрэгсэл, програм хангамжийг акталж, данснаас хасах асуудлыг судлан, тухай бүр акталж, данснаас хасах зөвшөөрөл олгож байх;

2.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч үндсэн хөрөнгийн шинжийг агуулаагүй, элэгдэл байгуулахад тохиромжгүй хөрөнгийг эргэлтийн хөрөнгийн дансанд шилжүүлэх, эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэх, үндсэн хөрөнгийн дансны ангилал хооронд шилжүүлэх асуудлыг судлан, тухай бүр зөвшөөрөл олгож байх;

2.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага хооронд хөдлөх үндсэн хөрөнгө шилжүүлэх хүсэлтийг судлан үзэж тухай бүр нь зөвшөөрөл олгож байх;

2.4. Төсөвт байгууллага нь нэмэлт төсөв, давсан орлого, холбогдох төсөл арга хэмжээний хүрээнд компьютер, дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшил, програм хангамж худалдан авах тохиолдолд төсөв зарцуулах эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн зөвшөөрөл олгож байх;

2.5. Энэ тогтоолыг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэх, төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх саналыг хянан судалж, журамд заасан нөхцөл, шаардлагад нийцэж байгаа тохиолдолд шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах.

3. “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг мөрдөж ажиллахыг төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагуудад даалгасугай.

4. “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг жишиг болгон ашиглахыг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагуудад зөвлөсүгэй.

5. Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт зөвлөсүгэй.

6. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хууль зүйн хэлтэс (А.Ариунболд)-т даалгасугай.

7. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 86 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ГАНБАТ

А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 06 дугаар сарын 18-ний өдрийн
271 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ, БҮРТГЭХ, ДАНСНААС ХАСАХ, ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь төр өөрийн өмчийн хөрөнгөөр дангаараа байгуулсан төрийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгөд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө (цаашид “эд хөрөнгө” гэх) олж авах, бүртгэх, худалдах, данснаас хасах, шилжүүлэх болон холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтийг тооцож, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ.

1.3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, актлах талаар ирүүлсэн саналыг хянан үзээд энэ журамд заасны дагуу шийдвэрлэж, шийдвэрийг тухайн байгууллагад хүргүүлнэ.

1.4. Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх барих байгууллага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаар эд хөрөнгө олж авах, бүртгэх, балансаас балансад шилжүүлэх, худалдах, актлах тухай асуудлыг хэлэлцэхэд энэхүү журмыг удирдлага болгоно.

1.5. Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөл үйл ажиллагаандаа энэхүү журмыг баримтлан ажиллана.

1.6. Хөрөнгө худалдах, хувьчлах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ.

Хоёр. Төрийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэхэд бүрдүүлэх материал

2.1. Төрийн өмчит хуулийн этгээд нь энэ журмын 1.2-т заасан асуудлыг шийдвэрлүүлэхдээ дор дурдсан бичиг баримтаас тухайн харилцаанд хамааралтай баримт, материалыг бүрдүүлнэ:

2.1.1. Компанийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөлийн, шаардлагатай бол Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, бусад төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд харьяа Төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөл;

2.1.2. худалдан авах санхүүжилтийн эх үүсвэрийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэр;

2.1.3. хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл, дүгнэлт;

2.1.4. холбогдох мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт;

2.1.5. эдийн засгийн тооцоо, үндэслэл, зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа, худалдан авах дээд, худалдах доод үнийн санал;

2.1.6. балансаас балансад шилжүүлэх бол өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрөл болон шилжүүлэн авах хуулийн этгээдийн хүсэлт;

2.1.7. ашиглалтын хугацаа дуусаагүй, үлдэгдэл өртөгтэй боловч ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн эвдрэл, гэмтлийн шалтгааныг тогтоосон дүгнэлт, хохирол барагдуулсныг нотлох баримт, сэргээн засварлаж ашиглахад шаардагдах эдийн засгийн тооцоо үндэслэл;

2.1.8. Үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг худалдах, үнийг шинэчлэн тогтоох зорилгоор тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр хийлгэсэн хөрөнгийн үнэлгээний тайлан;

2.1.9. үндсэн хөрөнгөд бүртгэлтэй номыг устгах талаар гаргасан холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт;

2.1.10. үндсэн хөрөнгөд бүртгэлтэй буу, галт зэвсгийн талаар Цагдаагийн байгууллагын албан бичиг, дүгнэлт;

2.1.11. түүх, соёлын дурсгалт зүйлсийн талаарх аливаа шийдвэрийг гаргахад соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын санал;

2.1.12. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн биет болон биет бус үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоосон хэсгийг хуулбарлан, “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулан ирүүлэх.

2.1.13. бусад шаардлагатай баримт материал.

2.2. Үл хөдлөх хөрөнгийн хувьд энэхүү журмын 2.1-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ:

2.2.1. Үл хөдлөх хөрөнгө байрлаж буй газрын эзэмших (ашиглах) эрхийн санхүүгийн тайланд бүртгэсэн үнэлгээ, гэрчилгээ, газар эзэмшүүлэх (ашиглуулах) гэрээ, кадастрын зургийн хуулбар,

2.2.2. Үл хөдлөх хөрөнгөд хийсэн их болон урсгал засварын зардал, тухайн эд хөрөнгөтэй холбоотой бусдын өмнө хүлээсэн хариуцлагын (зээл, өрийн барьцаа, баталгаа гэх мэт) болон ашиглалтын талаарх мэдээлэл,

2.2.3. барилгын паспортын хуулбар, орчны тойм зураг, байгуулалтын зураг /план/, гадна, дотор талын өнгөт фото зураг, инженерийн шугам сүлжээний техникийн зургийн хуулбар, бусад баримт бичиг.

2.2.4. Үл хөдлөх хөрөнгийг бусад этгээдтэй хамтран эзэмшиж, өмчилдөг тохиолдолд тухайн барилгыг бүхэлд нь зураглан, хөршүүдтэй хамтран баталсан заагийн актын хуулбар.

2.2.5. Үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх, худалдах бол түүнд ногдох газрын хэмжээ, үнэлгээ, гэрчилгээ, кадастрын зураг (салгаж хийлгэсэн)

2.2.6. төрийн өмчит болон төрийн өмчин оролцоотой хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газрын нэгж талбарыг хуваах, нэгтгэх, шилжүүлэх зэргээр өөрчлөлт орж байгаа нөхцөлд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан зөвшөөрөл, холбогдох дүгнэлт;

2.2.7. Газрын тухай хуулийн 39.1.3-д заасны дагуу тухайн байгууллагын газар эзэмших эрхийг дуусгавар болгосон тухай Засаг даргын шийдвэр, холбогдох материал;

2.3. Тээврийн хэрэгслийн хувьд энэхүү журмын 2.1-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ:

2.3.1. тээврийн хэрэгслийн гэрчилгээ, техник ашиглалтын дэвтэр, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр төлөгчийн гэрчилгээний хуулбар;

2.3.2. техникийн үзүүлэлт, 3 талаас нь авсан өнгөт фото зураг;

2.3.3. төслийн шугамаар ашиглагдаж байсан бол гаалийн татвар төлөлтийн мэдээлэл, холбогдох баримт;

2.3.4. ашиглалтын сүүлийн 3 жилийн сэргээн босголтын зардлын дүн;

2.3.5. Тээврийн хэрэгслийн хувийн хэргийн Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөрийг төлсөн болон техникийн үзлэгт орсон талаарх эрх бүхий этгээдийн хийсэн тэмдэглэл, газрын үсэг, тамга бүхий хэсгийн хуулбар;

2.3.6. ашиглалтад орсон он, балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл болон бусад мэдээллийг холбогдох байгууллагаас баталсан төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн “Тээврийн хэрэгслийн маягт”-ын дагуу.

2.4. Механизм, тоног төхөөрөмжийн хувьд энэхүү журмын 2.1, 2.3-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ:

2.4.1. механизм, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспортын хуулбар;

2.4.2. барилга байгууламжид суурилагдсан бол энэ тухай мэдээлэл;

2.4.3. бусад шаардлагатай баримт материал.

2.5. Биет бус хөрөнгийн хувьд энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ:

2.5.1. Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй “газар эзэмших эрх”-ийн асуудлыг шийдвэрлүүлэхэд газар эзэмших/ ашиглах эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, тухайн газар дээр барилга, байгууламжийн жагсаалт, газар шилжүүлэх болсон үндэслэл, шалтгааны тайлбар;

2.5.2. Тусгай зөвшөөрөл, патент, лиценз бүхий биет бус хөрөнгийн эрхийн бичгийн хуулбар, актлах, устгах, шилжүүлэх болсон үндэслэл

2.5.3. Програм хангамжийн нэр, үнэ, элэгдэл, хорогдол, лиценз эзэмшигч болон ашиглалтын талаарх мэдээллийг жагсаалтаар.

Гурав. Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах

3.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв, эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу болон Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу, үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болгох, эсхүл иргэн, хуулийн этгээдээс үнэ төлбөргүй шилжүүлж авах, түүнчлэн хандив, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах журмаар олж авна.

3.2. Төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газар, их дээд сургууль болон төсвөөс санхүүжилт авдаггүй бусад төрийн өмчит хуулийн этгээд нь хуульд өөрөөр заагаагүй бол өөрийн чиг үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай, дараагийн жилд хэрэгжүүлэх их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө, жагсаалтыг бэлтгэн саналаа жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж батлуулна.

3.3. Төрийн өмчит хуулийн этгээдэд эд хөрөнгө худалдан авах зөвшөөрөл олгох, үнийн дээд хязгаарыг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан эх үүсвэрийг баримтална.

3.4. Төрийн өмчит хуулийн этгээд тээврийн хэрэгсэл худалдан авах тухай бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авна. Ийнхүү зөвшөөрөл олгохдоо эрх бүхий байгууллагаас тогтоосон тоо, төрлийг харгалзан үзнэ.

3.5. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагаа, чиг үүрэгт өөрчлөлт орсон, ажлын цар хүрээ нэмэгдсэн, багассан, бүтцийн өөрчлөлт хийснээс шалтгаалан суудлын автомашин нэмж авах, цөөрүүлэх зайлшгүй шаардлага гарвал автомашины тоо, төрөл тогтоосон шийдвэрт өөрчлөлт оруулах тухай саналаа Төрийн өмчийн бодлого,

зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ.

3.6. Эрчим хүч, уул уурхай, авто замын салбарын төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд онцгой байдал үүссэний улмаас хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах шаардлагаар эд хөрөнгө худалдан авах тохиолдолд тодорхой үндэслэл, хөрөнгийн эх үүсвэрийн саналаа бэлтгэн холбогдох төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж зохих зөвшөөрөл авна.

3.7. Төрийн өмчит хуулийн этгээд автомашин шинээр худалдан авах санал ирүүлэхдээ илүүдэлтэй эсхүл ашиглалтын шаардлага хангахгүй автомашиныг худалдах, шилжүүлэх, актлах асуудлыг хамтад нь тавьж шийдвэрлүүлнэ.

3.8. Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Төрийн өмчийн эд хөрөнгийг бүртгэх

4.1. Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана.

4.1.1. Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэсэн болон хандив, тусламж, бэлэглэл, төслийн шугамаар бий болсон хөдлөх хөрөнгийг бүртгэлд тусгахад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авах шаардлагагүй.

4.1.2. Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэж буй үл хөдлөх хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт хариуцсан хэлтэс, нэгжээс хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гүйцэтгэл, хөрөнгийн жагсаалт, холбогдох бусад баримтыг аль нэг, эсвэл хэд хэдэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж бүртгэлд тусгах, эзэмшигчийг тогтоох асуудлыг шийдвэрлүүлнэ.

4.1.3. Энэ журмын 4.1.1-д заасан хөрөнгийг хүлээн авч буй хуулийн этгээд тухайн иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлийг албан ёсоор авч үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгана.

4.1.4. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ.

4.1.5. Зээлийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн хувьд уг зээлийн эргэн төлөлтийг хариуцах этгээдийг Сангийн яам болон холбогдох гэрээ хэлэлцээрээр тогтоосны үндсэн дээр бүртгэлд тусгах, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ.

4.2. Төсөвт хуулийн этгээд нь Төсвийн тухай хуулийн батлагдсан урсгал төсөв, нэмэлт төсөв, хэмнэсэн төсөв болон давсан орлогоос үндсэн хөрөнгө бэлтгэх бол хэрэгцээ, шаардлагаа тодорхойлж, зайлшгүй хэрэгцээтэй хөрөнгийн жагсаалт, тоо хэмжээ, худалдан авах үнийн дээд хязгаарын саналыг дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагч дэмжсэн тохиолдолд Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зөвшөөрөл олгоно.

4.3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд Төсвийн тухай хуулийн болон төрийн өмчид хамаарах хандив, бэлэглэл, тусламжийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг эзэмшүүлэх эсэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар шийдвэрлэх бөгөөд тухайн хуулийн этгээдийн эзэмшигчдийн өмч болон холбогдох бусад дансанд бүртгэх зөвшөөрөл олгоно.

4.4. Улсын төсвийн тухай хуулийн дагуу хийсэн хөрөнгө оруулалт, төсөл аэга хэмжээ болон төрийн өмчид хамаарах хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн эцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана.

4.5. Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан барилга, байгууламжийг барьж дуусах хүртэл захиалагч байгууллага нь “бусад эргэлтийн хөрөнгө” дансанд бүртгэн санхүүгийн тайландаа тусгана.

Улсын комисс барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн захиалагч байгууллага болон Төсвийн ерөнхийлөн захирагчаас тухайн үл хөдлөх хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлснээр эзэмшигч байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэнэ.

4.6. Үндсэн хөрөнгийн дансанд Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын “хүлээн зөвшөөрөлтийн зарчим” хангагдсан, үндсэн хөрөнгийн шинжийг хадгалсан хөрөнгийг бүртгэнэ.

4.7. Улсын төсөв, хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг тухайн төрийн өмчит байгууллага ашиглаж байгаа боловч данс бүртгэлд тусгаагүй бол түүнийг зөрчил гэж үзэх бөгөөд тэдгээр хөрөнгийг данс бүртгэлд тусгах асуудлыг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад нэн даруй тавьж шийдвэрлүүлнэ.

4.8. Төсөвт байгууллагын зөвшөөрөлгүй бэлтгэсэн үндсэн хөрөнгийг хураан авч хэрэгцээ, шаардлагатай байгууллагад шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэж болно.

4.9. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ.

4.10. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр төрийн өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг хүлээн авч, төрийн өмчид бүртгэхдээ дараах материалыг бүрдүүлснээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар шийдвэрлүүлнэ:

4.10.1. шилжүүлэх хөрөнгийн үнэ өртөг, тоо хэмжээ, нэр төрөл, байршил, чанар байдлыг тодорхой тусгасан хөрөнгө шилжүүлэх тухай аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр;

4.10.2. орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлэх хөрөнгийг хүлээн авч, данс бүртгэлдээ тусгах төрийн өмчит хуулийн этгээдийн зөвшөөрөл, өмч эзэмшигч орон нутгийн өмчит байгууллагын санал.

4.10.3. Үл хөдлөх хөрөнгө шилжүүлэх тохиолдолд тухайн үл хөдлөх хөрөнгийн доорх газар “газар эзэмших эрх” (биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй)-ийн үнэлгээ, эрхийн

гэрчилгээ, кадастрын зураг болон уг эрхийг төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд шилжүүлэх асуудлаар аймаг, нийслэлийн Засаг даргын санал, зөвшөөрөл.

Тав. Төрийн өмчийн эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх

5.1. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.

5.2. Төрийн өмчит хуулийн этгээд нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрт зааснаар хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж, санхүүгийн тайланд хөдлөл өөрчлөлтийг тусгана.

5.3. Үл хөдлөх хөрөнгө болон их хэмжээний хөдлөх үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж болно.

5.4. Эд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдон гарах зардлыг хөрөнгө шилжүүлж авсан байгууллага хариуцна.

5.5. Үл хөдлөх хөрөнгө шилжүүлэн өгсөн этгээд өөрийн эзэмшилд байгаа эзэмших, ашиглах эрхтэй газраас, шилжүүлэх үл хөдлөх хөрөнгөд ногдох газар хэсгийг хэмжиж, зураглал хийлгэн, хөрөнгө хүлээн авах хуулийн этгээдтэй хамтран Газар, барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрлийг авна. Уг зөвшөөрлийг үндэслэн газрын гэрчилгээ, кадастрын зураг, гэрээнд өөрчлөлт оруулж, шилжүүлэн авсан хуулийн этгээд өөрийн нэр дээр газар эзэмших эрхийн шилжүүлэх (гэрчилгээ гаргуулах) арга хэмжээ авна.

5.6. Элэгдэл, хорогдлын шимтгэлээр өртгөө нөхсөн хөрөнгийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэхдээ энэ журмын 7.1,-д заасны дагуу тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.

Зургаа. Төрийн өмчийн эд хөрөнгийг акталж, данснаас хасах

6.1. Төрийн өмчит хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах саналаа энэ журамд заасан баримт материалын хамт хагас жилд 1 удаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ.

6.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна:

6.2.1. элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон,

6.2.2. ашиглалтын хугацаа нь дуусаагүй боловч ашиглах явцад хэн нэгний буруутай үйлдлээс болж эвдэрч гэмтэн цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулан буруутай этгээдээр хохирлыг барагдуулсан тохиолдолд;

6.2.3. техник, технологийн болон хэрэглээний хоцрогдолд орж, зайлшгүй шинэчлэх

шаардлагатай болсон;

6.2.4.балансын үнээ бүрэн нөхөөгүй боловч байгалийн гэнэтийн аюул, техникийн осолд өртсөнөөс цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь мэргэжлийн байгууллагаар тогтоогдсон;

6.2.5.ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс засвар шинэтгэл хийж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тооцоогоор нотлогдсон.

6.3.Төрийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө актлах саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэхдээ энэхүү журамд заасан мэдээллээс гадна дараах зүйлийг заавал тусган хүснэгтээр илэрхийлсэн байна:

6.3.1. данснаас хасах эд хөрөнгийн нэр, тодорхойлолт;

6.3.2. тоо хэмжээ;

6.3.3. данснаас хасах болсон шалтгаан;

6.3.4. уг эд хөрөнгийг акталж устгах, эсвэл акталж сэлбэгээр ашиглах тухай санал;

6.3.5. өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл, дүгнэлт;

6.3.6. байгалийн гэнэтийн аюул, техникийн осол, гэмтэлд өртсөн эд хөрөнгийн шалтгааны тухай холбогдох байгууллагын акт дүгнэлт.

6.4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь эд хөрөнгийг акталж данснаас хасахдаа дараах хэлбэрээр шийдвэрлэнэ:

6.4.1. эд хөрөнгийг худалдах;

6.4.2. төрийн өмчит бусад хуулийн этгээдэд шилжүүлэх;

6.4.3. сэлбэг, материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах'

6.4.4. шууд устгах;

6.4.5.барилга байгууламжийн хувьд тухайн газрыг цаашид ашиглах зориулалтын талаар чиглэл өгөх;

6.4.6.газар дээрх болон газар доорх барилга байгууламжийг буулгах, ашиглаж болох материалыг үнэ тогтоон орлогод авах, хог хаягдлыг цэвэрлэх, газрыг нөхөн сэргээх.

6.5.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр эд хөрөнгийг акталж, худалдахаар шийдвэрлэсэн тохиолдолд төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлөөс худалдах ажлыг зохион байгуулна. Хөрөнгө акталж, худалдах шийдвэрт худалдах үнийг заасан бол түүнээс багагүй үнээр, худалдах үнийг заагаагүй бол өмч хамгаалах Байнгын зөвлөлөөс үнийг тогтоож, худалдах ажлыг зохион байгуулна.

6.6.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр суудлын болон автомашин механизмыг акталж, сэлбэгээр худалдахаар шийдвэрлэсэн тохиолдолд тэдгээр хөрөнгийг автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.7.Акталсан тээврийн хэрэгслийг сэлбэгээр худалдан авсан этгээдэд тээврийн хэрэгслийн улсын дугаар шилжүүлэхийг хориглоно.

6.8.Төсөвт хуулийн этгээд нь акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогоос худалдан борлуулахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр улсын төсвийн "өмч хувьчлалын орлого" дансанд төвлөрүүлнэ. Төрийн өмчит компани болон төрийн өмчит үйлдвэрийн газар нь акталсан хөрөнгийн орлогыг өөрийн дансанд төвлөрүүлнэ.

6.9. Төрийн өмчит хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд түүний газар эзэмших/ашиглах эрхийг шилжүүлэн-эрх залгамжлан эзэмших төрийн өмчит хуулийн этгээдийг тогтоож, саналаа газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Долоо. Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох

7.1. Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.

7.2. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталж, данснаас хасахаар шийдвэрлэж, зөвшөөрөл авсан боловч ашиглалтын шаардлага хангаж байгаа, дахин ашиглах боломжтой хөрөнгийн үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөн тогтоож, дахин данс бүртгэлд тусгана.

7.3. Төрийн өмчит хуулийн этгээд нь энэ журмын 7.1, 7.2-д заасан асуудлаар саналаа бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэхдээ дараах баримт материалын хамт ирүүлнэ:

7.3.1. ашиглалтын хугацаа дуусаагүй, үлдэгдэл өртөгтэй боловч ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн эвдрэл, гэмтлийн шалтгааныг тогтоосон дүгнэлт, сэргээн засварлаж ашиглахад шаардагдах зардлын тооцоо үндэслэл;

7.3.2. эрх бүхий байгууллагаар хийлгэсэн хөрөнгийн үнэлгээ (байгаа бол);

7.3.3. өмнө нь эрх бүхий байгууллагаас гаргасан хөрөнгө акталж, данснаас хасах шийдвэр,

7.3.4. Хөрөнгийн ашиглалтын талаар гарсан мэргэжлийн байгууллагын дүгнэлт(байгаа бол);

7.3.5. Ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох асуудлыг хэлэлцсэн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлт,

7.3.6. хөрөнгийн жагсаалт (нэр, тоо ширхэг, ашиглалтад орсон он, шинэчлэн тогтоох үнийн санал, ашиглалтын хугацааг сунгах санал)

7.3.7. бусад шаардлагатай баримт материал.

Найм. Төрийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах

8.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийг өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хэрэгжүүлнэ.

8.2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь шийдвэрийн биелэлтийг уг шийдвэрт заасан хугацаанд холбогдох материалын хамт заасан хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тайлагнана.

8.3. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг акталж сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах, данснаас хасах шийдвэрийн хэрэгжилтийг устгалын акт, эргэлтийн хөрөнгөд орлого болгосон тэмдэглэл, худалдсан тухай акт хэлбэрээр баталгаажуулан, гүйцэтгэлийн үр дүнг холбогдох данс бүртгэлд тусгана.

8.4. Төрийн өмчит хуулийн этгээд олж авсан, бүртгэсэн, шилжүүлсэн, худалдсан, акталсан эд хөрөнгийн хөдлөлийн нэгдсэн тайланг жил бүр эрх бүхий байгууллагаас баталсан төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн "үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн жилийн мэдээ" маягтын дагуу гаргаж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлнэ.

8.5.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь олж авсан, бүртгэсэн, шилжүүлсэн, худалдсан, акталсан эд хөрөнгийн хөдлөлийн мэдээ, тайланг хагас, бүтэн жилээр “Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн нэгдсэн сан”-ийн программ хангамжид оруулж хэвшүүлнэ.

8.6. Тээврийн хэрэгслийг акталж данснаас хасах тухай шийдвэрийн биелэлтийг ирүүлэхдээ Автотээврийн үндэсний төвөөс автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хассан тухай лавлагааг ирүүлнэ.

Ес. Бусад

9.1.Эрх бүхий байгууллагын шийдвэр, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хийсэн хөрөнгийн дахин үнэлгээний үр дүн болон хөрөнгийн үнэлгээний залруулгыг холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу данс бүртгэлд тусгана.

9.2.Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийн элэгдлийн хугацаа, хэмжээг тооцохдоо Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримтална.

9.3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд тухайн эд хөрөнгийн иж бүрдэл, чанар байдал, бүрэн бүтэн байдлыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.

9.4.Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь эд хөрөнгийг харуул хамгаалалтаар хангах бөгөөд дутагдал, зөрчил гарсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

-----oO-----

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн
түрээсийн төлбөрийн доод хязгаар,
түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох
заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын
хувь хэмжээг шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 11, 17 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сангийн яамны 2020 оны 4-2/929 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг харгалзан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүнгийн 40 /дэчин/ хувиар тогтоосугай.

3. Түрээслэгч-түрээслүүлэгчийн хооронд байгуулсан төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний төлбөрийн хэмжээ нь батлагдсан доод хязгаараас багагүй байхаар хянан баталгаажуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга З.Мэндсайханд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны “Түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай” 102 дугаар тогтоолын 2 дугаар заалт, “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ батлах тухай” 119, 2018 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 59 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, түрээслүүлэгч нартай хагас жилээр болон жилийн эцэст тооцоо нийлж, түрээсийн орлогыг цаг хугацаанд нь улсын төсөвт төвлөрүүлж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс, Захиргаа удирдлагын албанд тус тус даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн
49 дүгээр тогтоолын хавсралт

**Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн
түрээсийн төлбөрийн доод хязгаар,
түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар**

1 Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслүүлэх төлбөрийн доод хязгаарыг түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны ангилал, салбарын чиглэл зэргийг харгалзан дараах байдлаар тогтооно:

№	Түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны ангилал, салбар, чиглэл, зориулалт	1 м.кв талбайн түрээсийн төлбөрийн доод жишиг үнэ (төгрөг)		
		Нийслэл Улаанбаатар	Аймгийн төв /Нийслэлийн Налайх, Багануур,	Сумын төвд
1.	Худалдаа, үйлчилгээ	15,000.00	7,000.00	3,000.00
2.	Албан тасалгаа	15,000.00	7,000.00	2,500.00
3.	Банк, санхүүгийн үйл ажиллагаа	15,000.00	7,000.00	3,000.00
4.	Цайны газар	10,000.00	6,000.00	2,500.00
5.	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа	10,000.00	6,000.00	2,500.00
6.	Хүүхдийн боловсрол, музей, уран, гар урлалын чиглэл, спортын	9,000.00	5,000.00	2,000.00
7.	Барилгын туслах талбай, агуулах, гарааш, подвал, вестибаль /1-6 дахь хэсэгт зааснаас бусад	12,000.00	5,000.00	2,000.00
8.	Бусад	10,000.00	5,000.00	3,000.00

2.Түрээсийн төлбөрийн доод үнийг тодорхой шалтгаанаар бууруулан тогтоох асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тавьж шийдвэрлүүлнэ.

3. Төрийн нууцад хамаарах болон төрийн тусгай хамгаалалтад байгаа төрийн өмчийн байр талбайн түрээсийн төлбөрийн доод үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тухай бүр гэрээнд тусган тогтооно.

4.Төрийн өмчийн бүртгэлд байгаа барилга байгууламжид түрээслэгчийн санхүүжилтээр урсгал засвар хийх тохиолдолд түрээсийн төлбөрөөс суутган тооцох асуудлыг засвар хийхээс өмнө Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ.

5.Төрийн өмчийн байранд төсөвт байгууллага, албан газар байрлах тохиолдолд өрөө тасалгааны түрээсийн төлбөрийг улсын төсөвт тусгаснаар тооцно

6.Төрийн өмчийн байранд төсөвт байгууллага, албан газар ашиглалтын зардлаар байрлаж болно. Энэ тохиолдолд түрээсийн гэрээ байгуулахгүй. (ашиглалтын гэрээ)

7.Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй орон сууцыг хөлслөх тохиолдолд төлбөрийг тухайн хуулийн этгээд Иргэний хууль болон

холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоож, гэрээ байгуулна.

8.Төрийн өөрийн өмчийн хөдлөх эд хөрөнгийг түрээслүүлэх, төлбөрийн хэмжээг 1 жилд байгуулах элэгдлийн хэмжээнээс багагүй байхаар тооцон эд хөрөнгийн ашиглалтын хугацаа, ашиглалтын нөхцөл, түрээсийн зах зээлийн дундаж үнэ зэргийг харгалзан түрээслүүлэгч тогтоож, гэрээнд тусган Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар баталгаажуулна.

9.Төрийн өөрийн өмчийн байр талбайд түрээслэгчийн салган зөөвөрлөх боломжтой хөрөнгө (бэлэн мөнгөний автомат машин, ундааны машин, антен, тоног төхөөрөмж, кабель, зар сурталчилгаа гэх мэт)-ийг суурилуулах, байршуулах, байрлуулах төлбөрийн хэмжээг ижил төрлийн түрээсийн зах зээлийн үнийг харгалзан түрээслүүлэгч тогтоож, гэрээнд тусган Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар баталгаажуулна.

-----oOo-----

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн
түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 28 дугаар зүйлийн 2, 3, 5 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 10, 17 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга З.Мэндсайханд үүрэг болгосугай:

2.1. Төрийн өмчит хуулийн этгээдээс тухайн хуулийн этгээдийн технологийн болон үндсэн үйл ажиллагаанаас бусад зориулалтаар төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлэх талаар ирүүлсэн саналыг хянан үзэж, зөвшөөрөл өгч байх;

2.2. Түрээслүүлэгч хуулийн этгээд төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэхдээ үндсэн үйл ажиллагаанд нь харшлах үйл ажиллагаа явуулахгүй, түрээслэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тодоор сонгон шалгаруулж дүнг олон нийтэд мэдээлж байгаа эсэхэд хяналт тавих;

2.3. Түрээслэгч-түрээслүүлэгчийн хооронд байгуулсан төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг батлагдсан загварын дагуу баталгаажуулах, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллах;

2.4. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгөд зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулалт хийхийг хориглох, зайлшгүй шаардлагатай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл өгөх, зөвшөөрөлгүй хөрөнгө оруулалт, их засвар хийсэн тохиолдолд зардлыг төрөөс хариуцахгүй байх;

2.5. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг санхүүгийн жилээр байгуулж, түрээсийн төлбөрийн тооцоог түрээслүүлэгчтэй хагас жил тутам нийлж баталгаажуулах.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны “Түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай” 102, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2018 оны 293 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцож, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс, Захиргаа, удирдлагын албанд тус тус даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн
50 дугаар тогтоолын хавсралт

БАТЛАВ
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

ТӨРИЙН ӨӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТҮРЭЭСИЙН
ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

20... оны дугаар сарын
.....-ны өдөр

Дугаар:.....

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас төрийн өөрийн өмчийн өмчлөгч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (цаашид “ТӨБЗГ” гэх), түүнийг төлөөлж тус газрын (албан хаагчийн албан тушаал, нэр) нөгөө талаас өмч эзэмшигч байгууллага (цаашид “түрээслүүлэгч” гэх), түүнийг төлөөлж тус байгууллагын (албан хаагчийн албан тушаал, нэр), нөгөө талаас (хуулийн этгээдийн нэр улсын бүртгэл, регистрийн дугаар, иргэний нэр, регистрийн дугаар , цаашид “түрээслэгч” гэх) нар (цаашид хамтад нь “талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож, Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Гэрээний зорилго: Түрээслүүлэгч төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө (цаашид “түрээсэлсэн эд хөрөнгө” гэх) -ийг зориулалтаар (түрээсийн зориулалтыг түрээсэлсэн эд хөрөнгө бүрээр заах) түрээслэгчийн ашиглалтад шилжүүлэн өгөх, түрээслэгч нь уг гэрээнд дурдсан нөхцөлөөр түрээсийн төлбөр төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Гэрээний зүйл нь түрээслүүлэгчийн эзэмшилд байгаа төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө (түрээсэлсэн эд хөрөнгийн хаяг байршил, давхар, өрөөний дугаар, талбайн хэмжээ, тоо ширхэг, чанар болон бусад шаардлагатай үзүүлэлтийг тусгах) байна.

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрыг
төлөөлж:

Түрээслүүлэгчийг
төлөөлж:

Түрээслэгчийг төлөөлж:

.....

.....

.....

1.3. Түрээсийн гэрээний хугацаа нь:-нээс эхлэн (нэг хүртэл) жил буюу хүртэл (дуусах огноог тусгах) байна.

1.4. Түрээсийн гэрээний хугацаа дуусгавар болоход түрээслүүлэгч болон түрээслэгч нар гэрээний үүргийн биелэлтийг хамтран дүгнэж 3 хувь акт үйлдэнэ.

1.5. Түрээсийн гэрээг нэг хүртэл жилээр 2 удаа сунгаж болно. “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний сунгалтын хуудас”-аар гэрээний хугацааг сунгаж, гэрээ дүгнэсэн тэмдэглэл болон тооцоо нийлсэн актыг хавсаргана. Түрээсийн гэрээний сунгалтын маягт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

1.6. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгөд зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулалт хийхийг хориглох, зайлшгүй шаардлагатай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авах бөгөөд зөвшөөрөлгүй хөрөнгө оруулалт, их засвар хийсэн тохиолдолд зардлыг төрөөс хариуцахгүй;

1.7. Түрээслүүлэгч хуулийн этгээд төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэхдээ үндсэн үйл ажиллагаандаа харшлах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

1.8. Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил газрыг түрээслүүлэх, ашиглуулах, эзэмшүүлэхийг энэхүү гэрээгээр зохицуулахгүй.

Хоёр. Эд хөрөнгө түрээслүүлэх, хүлээлцэх

2.1. Түрээслүүлэгч нь төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлнэ.

2.2. Түрээслүүлэгч болон түрээслэгч нь түрээсэлсэн эд хөрөнгийн өнгө үзэмж, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, түрээслүүлсэн хөрөнгийн схем, заагийг тогтоон фото зургаар баримтжуулан 3 хувь акт үйлдэж хүлээлцэнэ. Түрээсэлсэн эд хөрөнгийг хүлээлцсэн акт нь энэхүү түрээсийн гэрээний 1 дүгээр хавсралт болно.

2.3. Түрээслэгч нь түрээсэлсэн эд хөрөнгийг энэхүү гэрээний 1.1-д заасан зориулалтын дагуу түрээсэлж, чанар байдлыг муутгахгүй ашиглах бөгөөд түрээсэлсэн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцна. Түрээсэлсэн эд хөрөнгөд хохирол учруулбал хохирлыг нөхөн төлнө.

2.4. Түрээсэлсэн эд хөрөнгийг бусдад дамжуулан түрээслэх, барьцаалах, шилжүүлэх, баталгаа гаргахыг хориглоно.

2.5. Төрийн өмчийн барилга байгууламжид түрээслэгчийн санхүүжилтээр урсгал засвар хийх бол түрээсийн төлбөрөөс суутган тооцох асуудлаар засвар хийхээс өмнө Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авна.

2.6. Түрээслүүлэгч, түрээслэгч нар түрээсэлсэн эд хөрөнгийн ашиглалтын зардлыг хэмжигдэхүйц байлгах арга хэмжээ авна.

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрыг
төлөөлж:

.....

Түрээслүүлэгчийг
төлөөлж:

.....

Түрээслэгчийг төлөөлж:

.....

Гурав. Төлбөр тооцоо, барьцаа

3.1. Энэхүү гэрээний 1.2-т заасан түрээсэлсэн эд хөрөнгийн түрээсийн (НӨАТ багтаагүй) бөгөөд 1 м.кв талбайн 1 (нэгж хөрөнгийн) төлбөр нь 1(нэг) сарын түрээсийн төлбөр нь (тоогоор бичих) (үсгээр бичих) төгрөг, нийт төлбөр нь (тоогоор бичих) (үсгээр бичих) байна.

3.2. Түрээсийн төлбөр нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тогтоосон төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаараас багагүй байна.

3.3. Түрээслэгч нь гэрээний үүргийн биелэлтийн баталгаа болгож 1 (нэг) сарын төлбөртэй тэнцэх хэмжээний буюу (тоогоор бичих) (үсгээр бичих) төгрөгийг барьцаа болгон түрээслүүлэгчийн түрээсийн төлбөр авах дансанд урьдчилан байршуулан энэхүү гэрээний хугацаанд байлгана.

3.4. Түрээслүүлэгч түрээсийн гэрээгээ цуцлах тухай 1 сараас доошгүй хугацааны өмнө мэдэгдсэн тохиолдолд барьцаа нь түрээсийн төлбөрт тооцогдоно. Хэрэв дээрх хугацаанд мэдэгдээгүй бол барьцаа улсын орлого болгоно.

3.5. Түрээслэгч нь түрээсийн 1 (нэг) сарын төлбөр болох нийт (тоогоор бичих) (үсгээр бичих) төгрөгийг сарын 20-ны өдрийн дотор түрээслүүлэгчийн дансанд шилжүүлнэ.

Түрээсийн төлбөр төлөх: Банкны нэр:

Дансны нэр:,

Дансны дугаар:

Мөнгөн дүн:

Түрээслүүлэгч болон түрээслэгч тал нь түрээсийн төлбөр төлөх хуваарийг харилцан тохиролцоно. Түрээсийн төлбөр төлөх хуваарь нь энэхүү түрээсийн гэрээний 2 дугаар хавсралт болно.

3.6. Түрээслүүлэгч нь түрээсийн төлбөрийн 40 (дөчин) хувь болох (тоогоор бичих) (үсгээр бичих) төгрөгийг төлбөр орсноос хойш ажлын 5 өдрийн дотор улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлнэ.

Түрээсийн орлого төвлөрүүлэх: Банкны нэр: Төрийн сан,

Дансны нэр: Төрийн өмчийн түрээсийн,

Дансны дугаар: 1009 0000 0703,

Мөнгөн дүн:

3.7. Улсын төсвийн түрээсийн орлогын дансанд зөвхөн түрээслүүлэгчээс түрээсийн төлбөрийг шилжүүлнэ.

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрыг
төлөөлж:

.....

Түрээслүүлэгчийг
төлөөлж:

.....

Түрээслэгчийг төлөөлж:

.....

3.8. Түрээсийн төлбөр нь түрээсэлсэн эд хөрөнгийг гэрээнд заасан зориулалтын дагуу ашигласны төлөө түрээслэгчээс төлж буй төлбөр болно. Түрээсийн төлбөрт түрээсэлсэн эд хөрөнгийн ашиглалт (цахилгаан, дулаан, уур, цэвэр, бохир ус, интернэт, телефон утас, кабелийн суваг, хог хаягдал, цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, бусад)-ын төлбөр хамаарахгүй.

Дөрөв. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрх, үүрэг

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.1. Түрээсийн гэрээг хянан батлах, шаардлагатай тохиолдолд гэрээг нэг талын санаачилгаар, гэрээний хугацаа дуусахаас өмнө цуцлах;

4.2. Түрээсэлсэн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, түрээсийн төлбөр төлөлт, түрээсийн гэрээний биелэлтэд хяналт тавих;

4.3. Барилгын бүтээц, хийц, төлөвлөлтийг зохих зөвшөөрөлгүй өөрчилсөн, эвдэлсэн, гэмтээсэн тохиолдолд барилгыг хэвийн байдалд нь оруулах, учирсан хохирлыг арилгахыг түрээслэгчээс шаардах;

4.4. Түрээслүүлэгч, түрээслэгчийн гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих;

4.5. Түрээслүүлэгчийн түрээслүүлж буй байр талбайд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь хяналтын хэмжилт хийж баталгаажуулан зөрүүтэй тохиолдолд түрээслүүлэгчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх эрхтэй;

4.6. Энэхүү гэрээнд заасан хугацаанд түрээслүүлэгч түрээсийн төлбөрийн нийт дүнгийн 40 хувийг улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

4.7. Түрээслэгчээс бусдад учруулсан хохирлыг хариуцахгүй;

4.8. Түрээслэгчийн энэхүү гэрээний 2.6-д заасны дагуу хийсэн засварын зардлыг хариуцахгүй;

4.9. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Тав. Түрээслүүлэгчийн эрх, үүрэг

5.1. Түрээслүүлэгч эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг хариуцах, түрээсийн төлбөр, ашиглалтын зардал төлөх болон гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах эрхтэй.

5.2. Түрээсийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлөөгүй бол барьцаа хөрөнгийг түрээсийн төлбөрт суутган тооцож, түрээсийн байр талбайг чөлөөлөх арга хэмжээ авах, хөрөнгийг буцаан хүлээж авах, энэхүү гэрээний 5.3 дахь хэсэгт заасан алданги ногдуулж, төлүүлнэ.

5.3. Түрээслэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүй нөхцөлд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алданги тооцож, түрээслэгчээс нэхэмжилнэ. Хэрэв алданги тооцсон тохиолдолд улсын төвлөрсөн төсөвт 40 хувийг төвлөрүүлнэ. Алдангийн орлогын 40 хувийг улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлнэ.

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрыг
төлөөлж:

Түрээслүүлэгчийг
төлөөлж:

Түрээслэгчийг төлөөлж:

5.4. Түрээслэгчээс 1 сарын түрээсийн төлбөртэй тэнцэх хэмжээний барьцаа болгож тухайн түрээсийн төлбөрийн дансанд авна.

5.5. Энэхүү гэрээний аль нэг заалтыг түрээслэгч нь зөрчсөн тохиолдолд барьцаа төлбөрийг буцаан олгохгүй бөгөөд түрээсийн төлбөрт тооцно. Мөн гэрээний хугацаа дуусахад түрээсийн гэрээний биелэлтийг дүгнэж сунгуулах эсхүл цуцлах хүсэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлнэ.

5.6. Түрээслэгчид түрээсэлсэн эд хөрөнгийг нэг бүрчлэн хүлээлгэн өгч, энэхүү гэрээний 2.2-т заасны дагуу актад бүрэн тусгах үүрэгтэй.

5.7. Түрээслэгч иргэн, хуулийн этгээд нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүй бол гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж, учирсан хохирлыг нэхэмжлэх эрхтэй. Энэ талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй.

5.8. Түрээслэгч гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн тохиолдолд түрээсийн гэрээг цуцлах саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлнэ.

5.9. Түрээслэгчээс түрээсэлсэн эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар тавьсан барилгын үндсэн бүтээц, хийц, төлөвлөлтөд өөрчлөлт оруулах, их болон урсгал засвар хийхээс бусад саналыг судлан үзэж, ажлын 3 (гурав) өдрийн дотор хариу өгнө:

5.10. Түрээсэлсэн эд хөрөнгөд түрээслэгчээс үл хамаарах шалтгаанаар осол, гэмтэл гарвал түүний үр дагаврыг арилгах арга хэмжээг яаралтай авна. Энэ тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ажлын 3 (гурав) хоногийн дотор мэдэгдэнэ.

5.11. Эрх бүхий байгууллагаас түрээсэлсэн эд хөрөнгийн өмчлөх, эзэмших эрхийг шилжүүлэх, хувьчлах шийдвэр гарсан тохиолдолд энэ тухай түрээслэгчид ажлын 5 (таван) өдрийн дотор албан ёсоор мэдэгдэнэ. Ийнхүү шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дараа түрээсийн гэрээг нэг талын санаачилгаар цуцална.

5.12. Түрээсийн төлбөрийн зохих хувийг энэхүү гэрээнд заасны дагуу улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх үүрэгтэй.

5.13. Түрээслэгчийн энэхүү гэрээний 2.6-д заасны дагуу хийсэн засварын зардлыг хариуцах үүрэг хүлээхгүй;

5.14. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрлөөр түрээсийн гэрээг цуцлах;

5.15. Түрээсийн төлбөрөөс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогод хагас жил болон жилийн эцсээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай тооцоо нийлж байх;

5.16. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрыг
төлөөлж:

.....

Түрээслүүлэгчийг
төлөөлж:

.....

Түрээслэгчийг төлөөлж:

.....

Зургаа. Түрээслэгчийн эрх, үүрэг

6.1. Түрээсэлсэн эд хөрөнгөд засвар хийх саналаа энэхүү гэрээнд заасны дагуу тавьж шийдвэрлүүлэх.

6.2. Түрээсэлсэн эд хөрөнгийг энэхүү гэрээний 2.2-т заасны дагуу актаар хүлээн авах үүрэгтэй. Ийнхүү хүлээн авахдаа түрээслүүлэгчийн төлөөлөлтэй хамтран талбайн хэмжилт хийнэ.

6.3. Түрээсэлсэн эд хөрөнгийг энэхүү гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах үүрэгтэй

6.4. Түрээсэлсэн эд хөрөнгөд урсгал засварыг өөрийн зардлаар хийж болно. Урсгал засвар гэдэгт барилгын их засвар хооронд барилга ашиглалтыг сайжруулахаар хийгдэж буй засварыг ойлгоно. Урсгал засварын зардлыг түрээсийн төлбөрт суутган тооцохгүй.

6.5. Түрээсэлсэн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцах үүрэгтэй.

6.6. Түрээслэгчийн буруутай үйл ажиллагаанаас түрээсэлсэн эд хөрөнгөд учирсан гэмтэл, эвдрэл, хохирлыг бүрэн хариуцаж, өөрийн хөрөнгөөр барагдуулах;

6.7. Энэхүү гэрээнд заасны дагуу зохих зөвшөөрөл аваагүй хийсэн засварын зардлыг гэрээ хэрэгжих хугацаанд болон гэрээ цуцалсны дараа буцаан авах болон шаардах эрхээ алдана.

6.8. Түрээсийн төлбөр болон ашиглалтын зардлыг энэхүү гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй.

6.9. Түрээсэлсэн эд хөрөнгийг дамжуулан түрээслэх, барьцаалах, бусдад шилжүүлэх, баталгаа гаргахыг хориглоно.

6.10. Түрээсийн хугацаа дуусгавар болоход түрээсэлсэн эд хөрөнгийг түүнээс салгаж үл болох хөрөнгө оруулалт, засварын хамт түрээслүүлэгчид актаар хүлээлгэн өгөх үүрэгтэй.

6.11. Түрээсэлсэн эд хөрөнгөд хийсэн урсгал засвар, үйлчилгээний тайланг түрээслүүлэгчид тухай бүр гаргаж өгөх үүрэгтэй

6.12. Түрээслэгч нь гэрээний үүргийн биелэлтийн баталгаа болгож 1 сарын түрээсийн төлбөртэй тэнцэх хэмжээний төлбөрийг барьцаа болгож, түрээсийн гэрээний хугацаанд түрээслүүлэгчийн түрээсийн төлбөр авах дансанд байршуулах үүрэгтэй.

6.13. Түрээсийн хугацаа дуусгавар болоход өөрийн хөрөнгөөр авсан эд хогшил, тоног төхөөрөмжийг түрээслүүлэгчийн байр, эд хөрөнгийг сэвтээхгүй, гэмтээхгүй нөхцөлд буцаан авч болно. Түрээсэлсэн байрны үндсэн хийцийг өөрчлөхгүй, хаалга, цахилгаан, сантехник, цонх шал зэрэг барилгын иж бүрдлийг салган авахыг хориглоно.

6.14. Түрээсийн хугацаа дуусахаас өмнө гэрээг түрээслэгчийн санаачилгаар цуцалсан нөхцөлд барьцаа болон түрээсийн төлбөрийг шаардах эрхээ алдана.

6.15. Түрээслэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүй нөхцөлд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрыг
төлөөлж:

Түрээслүүлэгчийг
төлөөлж:

Түрээслэгчийг төлөөлж:

.....

.....

.....

6.16. Түрээслэгч төрийн өөрийн өмчийн эд хөрөнгөд зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулалт хийхийг хориглоно, зайлшгүй шаардлагатай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авах бөгөөд зөвшөөрөлгүй хөрөнгө оруулалт, их засвар хийсэн тохиолдолд зардлыг төрөөс нэхэмжлэхгүй.

6.17. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Долоо. Талуудын хариуцлага

7.1. Энэ гэрээнд заасан нөхцөлийг зөрчсөн тал түүнээс болж нөгөө талд, бусдад учирсан бүх хохирол, алдагдлыг үл маргалдах журмаар төлнө.

7.2. Талууд гэрээний үүргийн биелэлтийн хүрээнд харилцан хариуцлага хүлээх бөгөөд нэг тал нь үүргээ биелүүлээгүй бол биелүүлээгүй үүргийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

Найм. Маргаан шийдвэрлэх

8.1. Гэрээг тайлбарлах болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

8.2. Талууд харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Ес. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл

9.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөлийг арилах хүртэл хойшлуулж болно.

9.2. Энэхүү гэрээний үүргийн биелэлтэд саад болох нөхцөл байдал үүссэн болон дууссан тухайг талууд харилцан бичгээр мэдэгдэнэ.

9.3. Эрх бүхий байгууллагаас гаргасан нотлох баримт нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл байсан, мөн түүний үргэлжилсэн хугацааны нотолгоо болно.

Арав. Гэрээг дүгнэх, сунгах цуцлах болон нэмэлт, өөрчлөлт оруулах

10.1. Түрээслүүлэгч гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж энэхүү гэрээний 1 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсэгт заасны дагуу түрээсийн гэрээг нэг хүртэл жилээр 2 удаа сунгаж болно.

10.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас түрээсийн гэрээг дараах тохиолдолд нэг талын санаачилгаар, түрээсийн гэрээний хугацаа дуусахаас өмнө цуцалж болно:

10.2.1. Түрээслэгч барилгын үндсэн бүтээц, хийц, төлөвлөлтийг зохих зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн, эвдэлсэн, гэмтээсэн;

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрыг
төлөөлж:

.....

Түрээслүүлэгчийг
төлөөлж:

.....

Түрээслэгчийг төлөөлж:

.....

10.2.2. Түрээслэгч түрээсэлсэн эд хөрөнгийг дамжуулан түрээсэлсэн, бусдад барьцаалсан, шилжүүлсэн, баталгаа гаргасан, дутагдуулсан, шамшигдуулсан;

10.2.3. Эрх бүхий байгууллагаас түрээсэлсэн эд хөрөнгийг шилжүүлэх, худалдах, хувьчлахаар шийдвэрлэсэн;

10.2.4. Түрээслэгч дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тогтоогдсон; Энэ тохиолдолд түрээсийн барьцааг түрээсийн төлбөрт тооцож суутгана.

10.2.5. Түрээсэлсэн эд хөрөнгийг гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж ашиглаагүй, түрээслүүлэгчийн тавьсан шаардлагыг үндэслэлгүйгээр 2 буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй;

10.2.6. Түрээсийн төлбөрийг 30 (гуч) хоногоос илүү хугацаа хожимдуулан төлсөн.

10.3. Түрээслэгчийн санаачилгаар түрээсийн гэрээг хугацаа дуусахаас өмнө цуцалж болно. Энэ тохиолдолд түрээсийн барьцаа, түрээсийн төлбөрийг түрээслэгчид олгохгүй болно.

10.4. Түрээслэгч энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тухай саналаа түрээслүүлэгчид 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

10.5. Гэрээг цуцлах саналаа нөгөө талдаа заавал бичгээр мэдэгдэнэ.

10.6. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулна.

10.7. Энэхүү гэрээний нэмэлт, өөрчлөлт нь тус гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар батлуулснаар хүчин төгөлдөр болно.

10.8. Гэрээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулахыг санаачилсан тал нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ. Нөгөө тал нь саналыг зөвшөөрсөн эсэх тухай хариуг ажлын 10 өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.

Арван нэг. Бусад

11.1. Талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.

11.2. Гэрээ нь 2 хавсралт, холбогдох бичиг баримтын хамт нийт..... (.....) хуудас бөгөөд Монгол хэл дээр 3 (гурав) хувь үйлдэж, талууд тус бүр 1 (нэг) хувийг хадгална. Гэрээний эх хувь нь хууль зүйн адил хүчинтэй байна.

1.3. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

11.4. Бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

11.5. Энэхүү түрээсийн гэрээнд түрээсэлсэн эд хөрөнгийн фото зураг, түрээсийн барьцаа төлсөн баримт, тооцоо нийлсэн баримт, түрээслэгч иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбарыг тус тус хавсаргана.

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрыг
төлөөлж:

Түрээслүүлэгчийг
төлөөлж:

Түрээслэгчийг төлөөлж:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрыг
төлөөлж:

.....

Түрээслүүлэгчийг
төлөөлж:

.....

Түрээслэгчийг төлөөлж:

.....

.....

(хуулийн этгээдийн
дарга, нягтлан бодогч)

.....

(хэлтсийн дарга,
мэргэжилтэн)

.....

Утас:

Мэйл хаяг:

.....

(байгууллага /иргэн/-ын
нэр, гарын үсэг)

Утас:

Мэйл хаяг:

Утас:

Мэйл хаяг:

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрыг
төлөөлж:

.....

Түрээслүүлэгчийг
төлөөлж:

.....

Түрээслэгчийг төлөөлж:

.....

Түрээсийн гэрээний 1 дүгээр хавсралт

ТҮРЭЭСЭЛСЭН ЭД ХӨРӨНГӨ ХҮЛЭЭЛЦСЭН АКТ

20.... оны дугаар сарын-ны өдөр

Д/д	Түрээсэлсэн эд хөрөнгийн нэр	Тоо, талбайн хэмжээ (ширхэг, м.кв)	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Өнгө үзэмж	Чанар байдал	Зориулалт	Тайлбар
1								
2								
3								
4								
5								
6								
7								

Энэхүү актад түрээсэлсэн эд хөрөнгө бүрийн 4 талаас авсан өнгөт фото зургийг хавсаргана.

Эд хөрөнгө хүлээлгэн өгсөн түрээслүүлэгч:

.....

(байгууллага, албан хаагчийн нэр, гарын үсэг)

Эд хөрөнгө хүлээн авсан түрээслэгч:

.....

(байгууллага, албан хаагчийн нэр, гарын үсэг)

Түрээсийн гэрээний 2 дугаар хавсралт

ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР ТӨЛӨХ ХУВААРЬ

20..... оны дугаар сарын-ны өдөр

Д/д	Түрээсэлсэн эд хөрөнгийн нэр	Тоо, талбайн хэмжээ (ширхэг, м.кв)	Нэг сарын түрээсийн төлбөрийн хэмжээ (төгрөг)	Түрээсийн төлбөр төлөх огноо	Төлсөн дүн (төгрөг)	Биелэлт
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
НИЙТ ДҮН						
Улсын төсөвт төвлөрүүлэх дүн						

Түрээслүүлэгчийг төлөөлж:

.....

(байгууллага, албан хаагчийн нэр, гарын үсэг)

Түрээслэгчийг төлөөлж:

.....

(байгууллага, албан хаагч /эсхүл иргэн/-ийн нэр, гарын үсэг)

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

Сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгох “Сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийг хавсралтаар баталсугай.

2. “Сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийг төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх үйл ажиллагаанд ашиглахыг төсөвт байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, захирал нарт зөвлөсүгэй.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Төрийн өөрийн өмчийн эд түрээслэгчийг сонгон шалгаруулах тухай” 2017 оны 53, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2017 оны 268 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцож, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн
51 дүгээр тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ӨӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОХ
“СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ”**

1. Түрээслэгчийг сонгон шалгаруулах зарын маягт

Төрийн өмчит хуулийн этгээд нь сонгон шалгаруулалтын зарын маягтыг өдөр тутмын (тухайн орон нутгийн сонин) байгууллагын албан ёсны цахим хуудсанд ил тод нээлттэй нийтэлнэ.

Түрээслүүлэх эд хөрөнгийн танилцуулга

..... (эд хөрөнгийн тухай болон байр талбай түрээслүүлэх бол түрээслүүлэх талбайн хэмжээ, хаяг байршил зэргийг тодорхой тусгана).....

..... зориулалтаар (тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд харшлахааргүй байх шаардлагатай)

Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл

Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа	20.... оны дугаар сарын -ны өдрийнцагт /сонгон шалгаруулалтыг зарласнаас хойш хуанлийн 15 хоногоос багагүй
Материал хүлээн авах хаяг
Материал нээх хугацаа, хаяг байршил	/материал хүлээн авснаас хойш 1 цагийн дотор, оролцогчдын өмнө нээх/
Эд хөрөнгө түрээслүүлэх үнийн доод хэмжээ (.....үсгээр) төгрөг
Түрээслэгч үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийн мэдээлэл /шаардлагатай тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг бүрэн тусгах/

<p>Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаарх товч мэдээлэл</p>	<p>..... </p> <p>/шаардлагатай мэдээллийг тусгах/</p>
<p>Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал</p>	<ul style="list-style-type: none"> • Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ (иргэний хувьд цахим үнэмлэх), эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тус тус нотариатаар баталгаажуулсан хуулбар; • Үйл ажиллагааны танилцуулга, ажлын туршлагын талаарх мэдээлэл (өмнө нь хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын гэрээний хуулбар); • Санхүүгийн чадварыг нотлох баримт (иргэн бол харилцагч банкны тодорхойлолт /зээл/, сүүлийн 1 жилийн дансны хуулга, хуулийн этгээд бол сүүлийн 2 жилийн аудитлагдсан тайлан, татвар, нийгмийн даатгалын тодорхойлолт); • Ажиллах хүчний мэдээлэл, мэргэжлийн диплом, үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтрийг нотариатаар баталгаажуулсан хуулбар; • Шаардлагатай тохиолдолд худалдаа үйлчилгээ, нийтийн хоолны чиглэлийн технологийн баримт бичиг; • Талбай болон үндсэн хөрөнгө түрээслэх үнийн санал. <p>.....</p> <p>/Түрээслүүлэх эд хөрөнгийн нөхцөл байдал, онцлогоос хамааран түрээслүүлэгч нь нэмэлт материал шаардаж болох бөгөөд зард заавал тусгах/</p>

Түрээслүүлэх хөрөнгийн талаар мэдээлэл авах

Түрээслүүлэх хөрөнгийг өмч эзэмшигч байгууллага дээр очиж үзэж болох бөгөөд сонгон шалгаруулалтын заавар, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг утсаар болон цахим хуудаснаас авна уу.

Хаяг:

Холбогдох албан тушаалтан:

Утасны дугаар:

2. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах, нээх, дүгнэх аргачлал

2.1. Сонгон шалгаруулалтын материал ирүүлэх:

2.1.1. Оролцогч нь сонгон шалгаруулалтын материалыг тогтоосон хугацаанд, бүрэн бүрдүүлж битүүмжлэн ирүүлнэ. Бүрдүүлсэн материалын жагсаалтыг дугтуйны гадна талд бичсэн байна.

2.1.2. Оролцогч нь зард заасан хугацаанд материалаа өөрийн биеэр эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан түрээслүүлэгчийн бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгнө.

- 2.1.3. Оролцогч нь сонгон шалгаруулалтыг нээхээс өмнө татгалзах саналаа ирүүлж болно.
- 2.1.4. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаатай холбоотой гомдлыг сонгон шалгаруулалт зохион байгуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор тухайн байгууллагад гаргана.
- 2.1.5. Сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалын үнэн зөвийг оролцогч бүрэн хариуцна.

2.2. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах, нээх:

- 2.2.1. Түрээслүүлэгчийн бичиг хэргийн ажилтан сонгон шалгаруулалтын зард заасан хугацаанд ирүүлсэн материалыг бүртгэж, хүлээн авна. Бичиг хэргийн ажилтан битүүмжлээгүй, хугацаа хоцорсон материалыг хүлээн авахаас татгалзана.
- 2.2.2. Бичиг хэргийн ажилтан сонгон шалгаруулалтын материалыг бүртгэлийн хамт ажлын хэсгийн нарийн бичигт тэмдэглэл үйлдэн хүлээлгэн өгнө.
- 2.2.3. Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын материалыг нээж, бүрдлийг шалган Нээлтийн тэмдэглэл үйлдэнэ
- 2.2.4. Сонгон шалгаруулалтын материалын бүрдэл дутуу тохиолдолд оролцогчийг үл маргах журмаар хасна.

2.3. Сонгон шалгаруулалтын материалыг дүгнэх:

- 2.3.1. Ажлын хэсэг хуралдах бүр тэмдэглэлийг дэлгэрэнгүй хөтөлж зохих ёсоор баталгаажуулна.
- 2.3.2. Ажлын хэсгийн гишүүн бүр сонгон шалгаруулалтын материалтай бүрэн танилцсаны үндсэн дээр энэхүү зааврын дагуу дүгнэнэ.
- 2.3.3. Материалыг бүрэн ирүүлсэн, тавигдах шаардлагыг хангасан, ажлын хэсгийн гишүүдийн үнэлгээний нийлбэрээр оролцогчийг шалгаруулж, төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчээр сонгон шалгаруулна.
- 2.3.4. Ажлын хэсгийн нарийн бичиг хурлын тэмдэглэл хөтөлж баталгаажуулах, гишүүдийн онооны хуудсыг нэгтгэх, оролцогчдын материалыг хадгалах, зохих заавар журмын дагуу архивд шилжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэнэ.
- 2.3.5. Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг материал нээснээс хойш ажлын 10 (арван) өдрийн дотор энэхүү зааварт заасны дагуу дүгнэсэн байна.
- 2.3.6. Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг шалгарсан оролцогчид мэдэгдэл, бусад оролцогчид үндэслэл бүхий хариу хүргүүлнэ.
- 2.3.7. Мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 5 (таван) өдрийн дараа сонгон шалгаруулалтын тайлан (оролцогчдын материал, гишүүдийн үнэлгээний хуудас, хурлын тэмдэглэл, мэдэгдэл, үндэслэл бүхий хариу бичиг)-г иж бүрдэл болгон бэлтгэнэ
- 2.3.8. Ажлын хэсэг нь түрээсийн гэрээг байгуулах гэрээний төслийг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлнэ.

3. Сонгон шалгаруулалтын материалыг дүгнэх үнэлгээний хуудас

..... оны ... сарын өдөр

Улаанбаатар хот

Д/д	Сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр	Үнэлгээ /Шалгуур үзүүлэлтээр нийт 100 оноо/					Нийт оноо /100 оноон оос/
		Материалын бүрдэл /15 оноо/	Туршлага /15 оноо/	Ажиллах хүчний чадвар /20 оноо/	Санхүүгийн чадвар /25 оноо/	Төрийн өмчийн эд хөрөнгө түрээслэх үнийн санал /25 оноо/	
1							
2							

Жич:

- Оролцогчийн эрхлэх үйл ажиллагаа нь түрээслүүлэх эд хөрөнгийн зориулалтад нийцсэн байх;
- Түрээслэгчийн сонгон шалгаруулалтад оролцогчдын бүрдүүлбэл зохих материалыг хангасан оролцогчийн материалыг дүгнэнэ.
- Үнийн саналыг хувилж бодох аргачлалаар бодох бөгөөд 1 м.кв байр талбай түрээслэх хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогчид 25 оноо өгнө.

Дүгнэсэн: Ажлын хэсгийн/...../

4. Сонгон шалгаруулалтыг хүчингүйд тооцох

Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийн сонгон шалгаруулалтыг дараах нөхцөлд хүчингүйд тооцно.

- 4.1. Түрээслэгчийн сонгон шалгаруулалтыг холбогдох маягтын дагуу зарлаагүй.
- 4.2. Ажлын хэсэг материал нээснээс хойш ажлын 10 (арван) өдрийн дотор үнэлгээг хийгээгүй.
- 4.3. Ажлын хэсгийн гишүүд нь түрээслэгчийн сонгон шалгаруулалтад оролцож буй иргэн, хуулийн этгээдэд давуу байдал үүсгэсэн нь тодорхой болсон, сонгон шалгаруулалтыг дүгнэх маягтын дагуу үнэлгээг хийгээгүй.
- 4.4. Сонгон шалгаруулалтыг хүчингүйд тооцох эсэх асуудлыг тухайн түрээслүүлэгч байгууллага шийдвэрлэнэ.

-----oO-----

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 65

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 31 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах үйл ажиллагааг зохицуулах зорилгоор ТОГТООХ нь:

1. Төрийн өмчит хуулийн этгээдийн “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Өмч хамгаалах Байнгын зөвлөл” байгуулж үйл ажиллагаандаа энэхүү журмыг мөрдөж ажиллахыг Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг энэхүү журамд нийцүүлэн баталж, мөрдүүлэхийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт зөвлөсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Журам батлах тухай” 86 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 02 дугаар сарын 22-ний өдрийн
65 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь төрийн өмчит хуулийн этгээдийн Өмч хамгаалах Байнгын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, зохион байгуулалт, эрх, үүрэг, гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлоход оршино.

1.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн Өмч хамгаалах Байнгын зөвлөл үйл ажиллагаандаа энэхүү журмыг мөрдөж ажиллана.

1.3. Төрийн өмчит хуулийн этгээд гэдэгт төрийн байгууллага, албан газар, төсөвт байгууллага, түүний салбар нэгж, сан, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж, төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газар зэрэг төрийн өмчийг эзэмшиж үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийг ойлгоно.

1.4. Зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Татварын тухай багц хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын шийдвэр, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам” болон бусад шийдвэрийг удирдлага болгоно.

1.5. Зөвлөлийн үйл ажиллагаанд хамтын шийдвэр гаргах, ил тод, шуурхай, хариуцлагатай, ёс зүйтэй байх зарчмыг баримтална.

Хоёр. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх, үүрэг

2.1. Зохион байгуулалт

2.1.1. Зөвлөл нь орон тооны бус, байнгын үйл ажиллагаатай бөгөөд 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.1.2. Зөвлөлийг байгууллагын удирдлагын шийдвэрээр байгуулах бөгөөд үндсэн үйлдвэрлэл, үйл ажиллагаа хариуцсан дэд захирал эсхүл түүний үүрэг гүйцэтгэдэг менежерээр ахлуулж ерөнхий нягтлан бодогч, технологич, мэргэжлийн мэргэшсэн, чадварлаг ажилтнуудыг оролцуулна.

2.1.3. Зөвлөл нь тухай жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор байгууллагын удирдлагаар батлуулна.

2.1.4. Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь зөвлөлийн бүрэлдэхүүний чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн болон үр

дүнгийн гэрээнд нь тусгаж, ажиллах нөхцөл, боломжоор хангана. Шаардлагатай тохиолдолд үйл ажиллагаанд шаардагдах зардлыг төсөвт тусгуулна.

2.1.5. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд Зөвлөлийн дарга даргална. Даргын эзгүйд түүний даалгаснаар аль нэг гишүүн хуралдааныг даргална.

2.1.6. Зөвлөлийн хуралдаан ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна. Ээлжит хуралдааныг хагас жил тутамд, ээлжит бус хуралдааныг зөвлөлийн даргын товлосноор буюу гишүүдийн гуравны нэг болон удирдлагын санал болгосноор зарлан хуралдуулна. Хуралдаанд гишүүдийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно. Асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

2.1.7. Зөвлөл нь хуралдаанд судалгаа, тооцоо хийгдсэн, нотлох баримтад үндэслэсэн, санхүүгийн болон холбогдох бусад мэдээлэл бүхий баримт, материалыг бүрдүүлсний үндсэн дээр эрх бүхий байгууллагаас баталсан журамд нийцүүлэн бэлтгэсэн асуудлыг хэлэлцэнэ.

2.1.8. Зөвлөлийн шийдвэр нь тухайн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, хөрөнгийн тоо хэмжээ, чанар байдалд өгсөн дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал бүхий Дүгнэлт хэлбэрээр баталгаажиг гарна.

2.1.9. Хуралдааны шийдвэрийг хуралдаан болсноос хойш ажлын 3 өдөрт багтаан бэлтгэж Зөвлөлийн дарга, гишүүдийн гарын үсэг зурснаар баталгаажна.

Хуралдааны шийдвэрт хурал болсон газар, огноо, эхэлсэн- үргэлжилсэн хугацаа, ирц, хуралд оролцоогүй гишүүдийн нэр, шалтгаан, хэлэлцсэн асуудал, түүнийг танилцуулсан болон байлцсан этгээдийн нэр, албан тушаал, хэлэлцсэн асуудлын танилцуулга, холбогдуулан тавьсан асуулт, хариулт, тайлбар, хурлаас гарсан дүгнэлт, саналыг тусгана.

2.1.10. Зөвлөлийн дарга жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, гишүүдийн ирц, чиг үүргийн биелэлтийг гаргаж жилд 2-оос доошгүй удаа гүйцэтгэх удирдлагад танилцуулна.

2.1.11. Удирдлагад хуулиар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэх, тухайн асуудлыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөмж өгнө.

2.2. Зөвлөлийн эрх, үүрэг

2.2.1. Зөвлөл нь төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, хувийн хэрэг хөтлөх, улсын бүртгэлд бүртгүүлэх, хөрөнгийн тооллого хийх, санхүүгийн болон статистикийн мэдээ, тайланг гаргах, холбогдох журмын дагуу тайлагнах ажлыг хариуцан ажиллана.

2.2.2. Зөвлөл нь төрийн өмчийг үрэгдүүлэх, үнэгүйдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтэх зэрэг аливаа эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, бүртгэл, ашиглалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах үндсэн үүрэгтэй.

2.2.3. Хуулийн этгээдийн эд хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд хяналт тавьж, шалгалтыг дотоод хяналтын нэгжтэй хамтран

зохион байгуулж, холбогдох санал дүгнэлтээ гүйцэтгэх удирдлага, түүнчлэн эрх бүхий дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

2.2.4. Зөвлөл нь төрийн өмчийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг тухайн байгууллагын удирдлага, холбогдох ажилтнаас шаардах, тайлбар гаргуулах эрхтэй.

2.2.5. Зөвлөл нь эд хөрөнгийн талаар зөрчил гаргасан этгээдтэй хариуцлага тооцох, осол, гэмтэл, хохирол гарсан шалтгааныг тогтоож, хэрэв тодорхой этгээдийн буруугаас болсон бол Иргэний хуульд заасан журмаар хохирлыг аргуулах арга хэмжээг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд авч хэрэгжүүлнэ, эсхүл шийдвэрлүүлэх санал, дүгнэлт боловсруулна.

2.2.6. Зөвлөл нь санал боловсруулах, дүгнэлт гаргах, шийдвэр хэрэгжүүлэхдээ эрх бүхий байгууллагаас баталсан бүртгэл, мэдээллийн маягт болон хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх, ашиглалтаас хасах, устгах, худалдахтай холбоотой дараах баримт материалыг бүрдүүлэн хадгалж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хариуцан ажиллана. Үүнд:

а/Газар эзэмших эрхтэй холбоотой хэрэгжүүлэх ажил

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан ТӨХ-2 маягыг хөтөлнө.

Тухайн байгууллагад “газар эзэмших эрх” олгосон эрх бүхий байгууллагын шийдвэр, газар эзэмших/ ашиглах эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, тухайн газар дээр барилга, байгууламжийн жагсаалт, байршил зүйн схем зураглал.

Тухайн байгууллага хэд хэдэн байршилд газар эзэмшдэг бол тус бүрийн багц баримтыг бүрдүүлэн хавтаслаж хадгална.

Мөн газар эзэмших эрхийн хугацаа, сунгалт, төлбөр тооцоог тухай бүр нягталж, зөрчил гаргахгүй байхад хяналт тавьж ажиллана.

Төрийн өмчит болон төрийн өмчин оролцоотой хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газрын нэгж талбарыг хуваах, нэгтгэх, шилжүүлэх зэргээр өөрчлөлт орж байгаа нөхцөлд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан зөвшөөрөл, холбогдох дүгнэлт, үндэслэл бүхий тайлбарыг бэлтгэнэ.

б/Үл хөдлөх хөрөнгө (Барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн байгууламж, инженерийн шугам сүлжээ)-тэй хэрэгжүүлэх ажил

Үл хөдлөх хөрөнгийн паспорт хувийн хэргийг Барилга, хот байгуулалтын сайдын баталсан аргачлал, зааврын дагуу барилга, тус бүр дээр бүрдүүлэн хөтөлнө.

Мөн барилга байгууламжийн ТӨХ-3, ТӨХ-3.1 маягыг хөтөлж, санхүүгийн тайланд бүртгэсэн үнэлгээ үл хөдлөх хөрөнгөд хийсэн их болон урсгал засварын зардал, тухайн эд хөрөнгөтэй холбоотой бусдын өмнө хүлээсэн хариуцлагын (зээл, өрийн барьцаа, баталгаа гэх мэт) болон ашиглалтын талаарх мэдээллийг бүрдүүлнэ.

Орчны тойм зураг, байгуулалтын зураг /план/, гадна, дотор талын өнгөт фото зураг, инженерийн шугам сүлжээний техникийн зургийн хуулбар, үл хөдлөх хөрөнгийг бусад этгээдтэй хамтран эзэмшиж, өмчилдөг тохиолдолд тухайн барилгыг бүхэлд нь зураглан, хөршүүдтэй хамтран баталсан заагийн акт үйлдэнэ.

Үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх, худалдах бол түүнд ногдох газрын хэмжээ, үнэлгээ, гэрчилгээ, кадастрын зураг (салгаж хийлгэсэн) бэлтгэнэ.

Барилга, байгууламжийн ашиглалтын явцад гарсан өөрчлөлт, гэмтэл, эвдрэл, засан сайжруулалт, өргөтгөлийн талаар тухай бүр тэмдэглэл үйлдэн баримтжуулна.

в/Тээврийн хэрэгсэлтэй хэрэгжүүлэх ажил

Өөрийн байгууллагын эзэмшлийн автомашин бүрд эрх бүхий байгууллагаас баталсан хувийн хэрэг болон техник ашиглалтын дэвтэр хөтөлж, түүнд автомашин ашиглалтын болон дагалдах хөрөнгө, үзлэг оношилгоо, сэргээн засварлалт, осол гэмтэл түүний шалтгаан нөхцөлийн талаарх баримтыг бүрдүүлэн түүхчилсэн бүртгэлийг хөтөлнө.

Тээврийн хэрэгслийн ТӨХ-6 маягыг бүрдүүлж өөрчлөлтийг хөтөлнө. Тээврийн хэрэгсэл бүрийн улсын бүртгэл, техникийн хяналт, оношилгоо, татвар, даатгал болон ашиглалттай холбоотой зардал, төлбөр болон торгууль, хураамжийг цаг хугацаанд нь хийлгэхэд хяналт тавьж ажиллана. Холбогдох баримтыг бүрдүүлэн хадгална.

Тээврийн хэрэгслийн техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс засвар, үйлчилгээг холбогдох стандартын дагуу тогтоосон хугацаанд хийж, гүйцэтгэсэн байна.

Суудлын автомашины ашиглалттай холбоотой тухайн автомашиныг эзэмшиж буй жолоочтой эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж, түүний хэрэгжилтэд хяналт тавина.

Тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой байгууллагын дотоод журмыг боловсруулан батлуулж, мөрдүүлсэн байна.

Гурав. Төрийн өмчийн эд хөрөнгийг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах

3.1. Төрийн өмчийн эд хөрөнгийг ашиглаж буй албан хаагч, ажилтанд “эд хөрөнгө хариуцагчийн карт”-аар хариуцуулж бүрэн байдлыг хангуулна.

3.2. Суудлын автомашин, суурилагдсан тоног төхөөрөмж, буу галт зэвсэг зэрэг хөрөнгийг дангаараа хариуцаж байгаа ажилтантай “эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ” байгуулна

3.3. Төрийн өмчийн хөрөнгийг ашиглан үйл ажиллагаа явуулж буй ажилтан бүр хөрөнгийг ариг гамтай эдэлж хэрэглэн, эвдрэл гэмтэлд орохоос урьдчилан сэргийлэх, тухайн бүр засвар үйлчилгээ, арчилгаа хийлгэх үүрэгтэй.

3.4. Хөрөнгийг хадгалж буй агуулах, байр, хашааг цэвэр цэмцгэр, эмх цэгцтэй байлгаж эд хөрөнгийг төрөлжүүлж хураалт хадгалалтын цэгцлэх, аюулгүй ажиллагааг хангасан байх.

3.5. Хөрөнгийг тухай бүр засаж сэлбэх, сэргээн засварлах, арчилж тордох ажлыг хийж

3.6. Барилга байгууламжид тухайн аймаг, нийслэл дэх хот байгуулалт, төлөвлөлт хариуцсан байгууллагаас албан ёсны хаягийг авч барилга тус бүр дээр ил харагдахуйц байдлаар байрлуулна.

3.7. Онцгой шинжтэй хөрөнгийг зориулалтын байр, сав, сейф, хоргонд байршуулж хадгалалтын хэвийн нөхцөлийг хангах, гал усны аюулаас хамгаалах

3.8. Дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн автомашин, барилга байгууламжийн ашиглалтыг зогсоож, шинэ өмчлөгчид хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд битүүмжилж бүрэн бүтэн байдлыг хариуцна.

Дөрөв. Тооллого хийх, дүнг хэлэлцэх

4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72, 73 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн тооллогыг заасан хугацаанд бэлтгэлийн хангаж зохион байгуулна.

4.2. Хуулийн этгээдийн эд хөрөнгийн дотоодын болон улсын тооллогын ажлыг хуульд заасны дагуу зохион байгуулж, эрх бүхий этгээдээс баталсан журам, зааврын дагуу дүн, тайланг хугацаанд нь бэлтгэнэ.

4.3. Тооллогын дүнгээр бүртгэлд тусгаагүй хөрөнгийн ТӨ-9, дутагдсан ТӨ-10, маргаантай хөрөнгийн ТӨ-11, илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийн ТӨ-12 маягтыг бүрдүүлж, шалтгаан нөхцөлийг тогтоож дүгнэлт гаргана.

Тав.Төрийн өмчийн эд хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар санал дүгнэлт бэлтгэх, шийдвэрийг хэрэгжүүлэх

5.1. Зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, төрийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж, санал, зөвлөмж, дүгнэлт гаргана.

5.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь өмч хамгаалах Байнгын зөвлөлийн зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж, данснаас хасах санал хүргүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд зөвлөл нь дор дурдсан шаардлагыг хангаж төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагад хүсэлтийг хүргүүлэх ажлыг зохион байгуулна;

5.3. Хуулийн этгээдийн чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө олж авах бол эдийн засгийн тооцоо, үндэслэл, зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа, хөрөнгийн тоо хэмжээ, үнийн дээд хязгаар, техникийн болон бусад шаардлагын талаар зөвлөмж бэлтгэх.

5.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, хандив, тусламж, бэлэглэл, өр төлбөрт тооцон олж авсан хөрөнгө, төслийн шугамаар бий болсон эд хөрөнгийг бүртгэх бол хөрөнгийн чанар байдлыг нь харгалзан элэгдэл, хорогдлыг нь тооцон ашиглах хугацааг тогтоож дүгнэлт гаргах;

5.5. Хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх бол хөрөнгө хүлээн авах хуулийн этгээдтэй урьдчилан зөвшилцөж дүгнэлт гаргах;

5.6. Хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг худалдах бол хөрөнгийг худалдах доод үнийн санал бүхий дүгнэлт гаргах;

5.7. Хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг акталж данснаас хасах бол үндэслэл, хөрөнгийн ерөнхий болон техникийн байдлыг хөрөнгө нэг бүрээр газар дээр нь шалгаж, дүгнэлт бэлтгэх;

5.8. Хөрөнгийн асуудлыг тухайн хуулийн этгээдийн эрх барих эсхүл харьяа дээд байгууллагад уламжилж санал авсан байх;

5.9. “Төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн сангийн программ хангамжид хөрөнгийн бүртгэлийн мэдээлэл болон түүнтэй холбогдон гарсан шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр оруулах ажлыг хариуцан хийж хэвшүүлэх

5.10. Өмч хамгаалах зөвлөл нь эрх бүхий байгууллагын эд хөрөнгийн зохицуулалтын шийдвэрийг гүйцэтгэх удирдлагын тушаалаар комисс томилон хэрэгжүүлж, биелэлтийг заасан хугацаанд албан бичгээр хүргүүлэх үүрэг хүлээнэ.

5.11. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр шилжүүлэхээр шийдвэрлэсэн хөрөнгийг актаар хүлээлцэх, акталж данснаас хасах хөрөнгийг ангилж үнэ тогтоон хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах, сэлбэг, материал болгон ашиглах, устгах хөрөнгийг устгалын акт үйлдэн данснаас хасах ажлыг зохион байгуулна.

5.12. Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжид сэлбэг эд анги солих, барилга байгууламжид их засвар хийх тохиолдолд батлагдсан норм норматив, стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана.

5.13. Ашиглалтын хугацаа дуусаагүй, үлдэгдэл өртөгтэй боловч ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн эвдрэл, гэмтлийн шалтгааныг тогтоосон дүгнэлт, хохирол барагдуулсныг нотлох баримт, сэргээн засварлаж ашиглахад шаардагдах эдийн засгийн тооцоо үндэслэлийг гаргах;

5.14. Үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг худалдах, үнийг шинэчлэн тогтоох зорилгоор санал бэлтгэх, тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр хөрөнгийн үнэлгээ хийлгэх;

5.15. Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй буу, галт зэвсгийн бүртгэл, паспортыг хөтөлж Цагдаагийн байгууллагад бүртгүүлэх;

5.16. Механизм, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспортыг хөтлөх, барилга байгууламжид суурилсан бол энэ тухай мэдээллийг оруулах;

5.17. Тусгай зөвшөөрөл, патент лиценз бүхий биет бус хөрөнгийн эрхийг нотлох баримт материалыг бүрдүүлэн хяналт тавих.

Зургаа. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээсээр ашиглуулахад тавих хяналт

6.1. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах, түрээсийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалт, түрээсийн хөрөнгийн ашиглалт, талбайн хэмжээ, чанар байдалд хяналт тавьж ажиллана.

6.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 50 дугаар тогтоолын 2.2 дахь заалтад заасны дагуу Түрээслүүлэгч хуулийн этгээд төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэхдээ үндсэн үйл ажиллагаанд нь харшлах үйл ажиллагаа явуулахгүй, түрээслэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тодоор сонгон шалгаруулж дүнг олон нийтэд мэдээлж байгаа эсэхэд хяналт тавина.

Долоо. Ажил тайлагнах

7.1. Өмч хамгаалах зөвлөл тухайн жилд гүйцэтгэсэн ажил, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал зэргийг тусгасан ажлын тайланг дараа жилийн ажлын төлөвлөгөөний хамт жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдөрт багтаан удирдлагад танилцуулна.

7.2. Төрийн өмчит хуулийн этгээд нь үндсэн хөрөнгө шилжүүлэх, акталж, данснаас хасах, худалдах саналаа хагас бүтэн жилээр хийсэн тооллогын үр дүнгээр эрх бүхий байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

7.3. Өмч хамгаалах Байнгын зөвлөл нь жилийн ажлын үр дүнг хавсралтад заасны дагуу дүгнэн байгууллагын удирдлага (удирдах зөвлөл)-д танилцуулна.

Найм. Бусад

8.1. Өмч хамгаалах Байнгын зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актад заасан хариуцлага хүлээнэ.

8.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажлын үр дүнгээс хамааруулан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн нэмэгдэл цалин хөлс, урамшуулал олгож болно.

-----oOo-----



ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН
ЭТГЭЭДҮҮДИЙН ДАРГА, ЗАХИРАЛ
НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: nfo@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2022 оны 01 сарын 19-ны өдрийн А-1/120

Зөвлөмж хүргүүлэх тухай

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолын дагуу төрийн өмчит хуулийн этгээдтэй байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний 2020 оны биелэлтийг дүгнэж газрын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 538 дугаар тогтоол батлагдсан.

Өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөмж бэлтгэн хавсралтаар хүргүүлж байна. Хэрэгжүүлэх арга хэмжээ авч биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэхийг мэдэгдье.

Тогтоолыг (Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын <https://pcsp.gov.mn/> веб сайтад нэвтэрч татан авч болно)

Хавсралт 2 хуудастай

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний
өдрийн А-1/120 дугаар албан бичгийн
хавсралт

ТӨРИЙН ӨМЧ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭЭР ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УДИРДЛАГА, ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

1. Хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын талаар:

Байгууллагын Өмч хамгаалах Байнгын зөвлөл (ӨХБЗ)-ийн журмын хэрэгжилтийг хангаж, тухайн жилд хийсэн ажлын тайланг бэлтгэж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг цаг хугацаандаа тайлагнах, хөрөнгийн чанар байдал, ашиглалт, хадгалалтын байдал, үр ашгийг дээшлүүлэхэд хяналт тавих зэргээр үйл ажиллагаагаа идэвхжүүлэх;

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоолгох саналаа ирүүлж шийдвэрлүүлж байх;

Барилгын хувийн хэрэг болон тээврийн хэрэгслийн паспортын хөтлөлт, баяжуулалтыг тухай бүр хийж, гэрчилгээ, холбогдох баримтын бүрдлийг байнга хангасан байх;

Үндсэн хөрөнгийн дансны ангиллыг буруу тодорхойлсон, хөрөнгийн нэршил оновчгүй, тодорхойгүй, гадаад хэлээр бүртгэлд тусгасан байдлыг монгол хэлээр зөв томъёолж залруулга хийх;

Тээврийн хэрэгслийн үзлэг шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал. Үүнд:

Тээврийн хэрэгслийг акталж, худалдаж данснаас хассан тухай бүр тээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулдаггүй, гэрчилгээ нь эзэмшигч байгууллагын нэр дээр бүртгэлгүй, өөр байгууллагын эсхүл хувь хүний дээр байдаг. Олон жил ашиглаж элэгдэж дууссан, ашиглалтын шаардлага хангахгүй, болон засварын зардалгүйн улмаас засаж сэлбэж чадахгүй зогссон хөдөлгөөнд оролцоогүй тээврийн хэрэгслүүд байна. Тэдгээрийн татвар, хураамжийг төлөөгүй байгаа нь дараа нь уг тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасуулах үед төлбөр хураамжийг нөхөн төлөх асуудал тулгарч байна.

Иймд Авто тээврийн үндэсний төвөөс өөрийн байгууллагын нэр дээр бүртгэлтэй байгаа тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээг авч Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын бүртгэлийн мэдээтэй тулган баталгаажуулж, 2022 оны 1 дүгээр улиралд багтаан илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, албан татварын тооцоог хийж, шилжилт хөдөлгөөнийг тухай бүр тусгуулж байх;

2. Хөрөнгийн бүртгэл хөдлөл, өөрчлөлт, тайлагналын чиглэлээр:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 323 дугаар тогтоолоор баталсан төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн болон Захиргааны статистикийн маягтуудыг зааврын дагуу байнга хөтөлж, тайлагнах хугацаанд нь ирүүлж байх;

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр

тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах;

Хөрөнгө олж авах, данснаас хасах саналаа эрх бүхий дээд байгууллагадаа уламжлан, дэмжсэн тохиолдолд дээрх журамд заасан баримтын бүрдлийг бүрэн хангаж албан бичигт хавсарган ирүүлж байх;

Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, биелэлтийг тогтоолд заасан хугацаанд ирүүлж тайлагнаж байх;

3. Газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэлийн талаар:

Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн доорх газрын эзэмших, ашиглах эрхийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу баталгаажуулах, үнэлэх, бүртгэлд тусгах, Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын 6 дугаар заалт, 2020 оны 10 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

4. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар

Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэхдээ Засгийн газрын 2001 оны 134, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолын мөрдлөг болгож түрээслэгчийг сонгон шалгаруулж байх, хөрөнгө түрээслэх зөвшөөрөл авч байх, гэрээг баталгаажуулах, түрээсийн төлбөрийг цаг хугацаанд нь тооцоо нийлж Улсын төсөвт төвлөрүүлсэн байх;

Өмч хамгаалах Байнгын зөвлөл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолын дагуу жил бүр Төрийн өмч эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэх бэлтгэлийг хангаж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 86 дугаар тогтоолоор баталсан журмын хүрээнд жилийн тайлангаа бэлтгэж хэвших.

-----oO-----

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ НЭМЭЛТ ЗӨВЛӨМЖ

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн холбогдох хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор улсын үзлэг тооллогын дүнгээр төрийн болон орон нутгийн өмчийн мэдээллийн цахим санг үүсгэх, мэдээллийн үнэн зөв байдлыг нягталж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын төрийн цахим санд холбох замаар дундын мэдээллийн сан бүрдүүлэх зорилго тавьж байна. Тооллогын дүнгээр цуглуулах мэдээллээс дараах мэдээлэл **Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд тусгагдана:**

1.Үл хөдлөх эд хөрөнгө эзэмшигч, ашиглагч хуулийн этгээдийн мэдээлэл:

- 1.1. Хуулийн этгээдийн оноосон нэр;
- 1.2. Хуулийн этгээдийн хэлбэр;
- 1.3. Хуулийн этгээдийн регистр;
- 1.4. Хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар;
- 1.5. Хуулийн этгээдийн албан ёсны хаяг;

2.Мэдүүлэг гаргагч эрх бүхий этгээдийн /иргэний/ мэдээлэл:

- 2.1.Иргэний регистрийн дугаар;
- 2.2.Овог;
- 2.3.Эцэг/эх/-ийн нэр;
- 2.4.Өөрийн нэр;
- 2.5.Харъяалал;
- 2.6.Оршин суугаа хаяг;

3. Үл хөдлөх эд хөрөнгийн мэдээлэл:

- 3.1. Үл хөдлөх эд хөрөнгийн төрөл /Г-газар, Ү-ҮХЭХ/;
- 3.2. Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн дугаар;
- 3.3. Газрын нэгж талбарын дугаар;
- 3.4. Үл хөдлөх эд хөрөнгийн нийт талбайн хэмжээ;
- 3.5. Үл хөдлөх эд хөрөнгийн зориулалт;
- 3.6. Үл хөдлөх эд хөрөнгийн үнэ;
- 3.7. Үл хөдлөх эд хөрөнгийн хаяг /Аймаг нийслэл, сум дүүрэг, хороо, хороолол, байшингийн дугаар, давхар, тоот/;
- 3.8. Үл хөдлөх эд хөрөнгийн хийц,
- 3.9. Дэд бүтэц, хангамж /цахилгаан, дулаан, ус/;
- 3.10. Эзэмших, ашиглах эрх үүссэн шийдвэр, нэр, огноо, дугаар;
- 3.11. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх бүртгэлтэй эсэх; /бүртгэгдсэн бол огноо, эрхийн төрөл, улсын бүртгэлийн болон гэрчилгээний дугаар/
- 3.12.Дуусаагүй барилга бол гүйцэтгэлийн хувь

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд бүр өөрийн байгууллагын эзэмшилд байгаа газар, үл хөдлөх хөрөнгийн дээрх мэдээллийг цуглуулан нэгтгэж, эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх бэлтгэл ажлыг хангана.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулиас: - 3.1.4."эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл" гэж өмчийн хэлбэр, өмчлөгчийн иргэний харьяалал харгалзахгүйгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгийн эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг" хэлнэ.

9.11. Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан нь төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох боломжтой байх бөгөөд төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагад дундын мэдээллийн сан үүсгэн ажиллуулна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиас:

3.1.1. "үл хөдлөх эд хөрөнгийн эрх" гэж газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд хөрөнгийн өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийг; хэлнэ

4.3. Хуулиар төрийн болон албаны нууцад хамааруулсан үл хөдлөх эд хөрөнгө болон түүнтэй холбоотой эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журмыг Засгийн газар батална. (журам батлагдсан)

4.4. Орон сууц болон хэсгээр өмчлөх дундын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг тухайн үл хөдлөх эд хөрөнгийн доорх болон орчны газрын нэгж талбарын дугаарт үндэслэн бүртгэнэ.

10.9. Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаас бусад төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журмыг энэ хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн Засгийн газар батална. (журам хийгдэж байгаа)

-----oO-----